



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙГ ХОС ХЭЛНИЙ АРГА ЗҮЙГЭЭР ЗААХ ЗӨВЛӨМЖ

(Сонсголгүй суралцагчидтай ажилладаг монгол хэл, уран
зохиолын багш нарт зориулав)

Улаанбаатар хот
2022 он

ЗӨВЛӨМЖИЙН АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	03
Товчилсон үгийн тайлбар.....	05
Хүснэгтийн жагсаалт.	06
Зураглалын жагсаалт	07
Загварын жагсаалт.	08
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ	09
1.1. Сонсголгүй хүний тухай ойлголт.....	09
1.2. Хос хэл, соёлын арга зүй гэж юу вэ?	11
1.3. Дохионы хэл гэж юу вэ?	15
1.4. Сонсголгүй хүний ахуй соёл.....	23
ХОЁРДУГААР ХЭСЭГ	26
2.1. Сонсголгүй хүүхдийн онцлог	26
2.2. Сонсголгүй хүүхэдтэй ажиллах багшийн мэргэжлийн ур чадвар.	29
2.3. Сонсголгүй хүүхэдтэй ажиллах арга зүй	32
2.4. Сонсголгүй хүүхдэд зориулсан буюу хараанд тулгуурласан хичээлийн хэрэглэгдэхүүн.....	34
ГУРАВДУГААР ХЭСЭГ	36
Хос хэл, соёлын арга зүйгээр унших, ярих, бичих чадвар	
3.1. Унших чадварыг дохионы хэлний аргаар олгох.....	36
– Бичгийн хэлнээс унших	36
– Дохионы хэлнээс унших.....	45
3.2. Дохионы хэлээр ярих чадвар.....	53
3.3. Бичих чадвар хөгжүүлэх арга зүй	66
3.4. Монгол хэлний хэл зүйн ойлголт	79-93
3.5. Ном зүй	94

ӨМНӨХ ҮГ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид (ХБХЭТК) манай улс 2009 оны 05 дугаар сард нэгдэж, улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан байдаг. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид сонсголгүй хүмүүсийн нийгмийн бүлэгт хамаарах чухал 5 зүйл бий.

- **2-р зүйл** – Тодорхойлолт: “хэлний” тодорхойлолт хэсэгт ярианы болон дохионы хэл тэгш эрхтэй гэдгийг дурдсан.
- **9-р зүйл** – Хүртээмж: Энэ зүйл нь оролцогч улсууд тэгш эрхийн үндсэн дээр хүртэх бололцоог баталгаажуулсан үүрэгтэй болохыг зохицуулсан. Жишээ нь: чанартай орчуулгын үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн дохионы хэлний хэлмэрчээр хангах, санхүүжүүлэх.
- **21-р зүйл:** Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээлэл хүртэх эрх чөлөө. Оролцогч улсууд дохионы хэлний хэрэглээг дэмжих, хүлээн зөвшөөрүүлэх үүрэг хүлээнэ.
- **24-р зүйл** – Боловсрол: Сонсголгүй хүүхдүүд дохионы хэл дээр боловсрол эзэмших эрхтэй. Багш болон боловсролын ажилтнууд дохионы хэлний өндөр чадвартай байх ёстой.
- **30-р зүйл:** Нийгэм соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх, сонсголгүй хүмүүс хэл, соёлын байдлаа дэмжүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

Манай улс нэгдэн орсон НҮБ-ын ХБХЭТК-ийн зүйл заалтыг сонсголгүй хүүхдэд боловсрол олгож буй боловсролын байгууллага, сургууль хэрэгжүүлж баталгаажуулах үүрэгтэй байдаг. Конвенцийн эдгээр зүйл заалтаас харвал сонсголгүй хүүхэд нь сонсголгүй хүний эх хэл дохионы хэлээр боловсрол эзэмшиж, сонсголгүйн хэл, соёлын байдлаа дэмжүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй байна. Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш, боловсролын ажилтнууд дохионы хэлний өндөр чадвартай байх талаар тусгажээ. Дохионы хэл бол монгол ярианы хэлний нэгэн адил тэгш эрхтэй хэл гэдгийг ч дурдсан байна.

Тус конвенцид дурдсанаар сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш, боловсролын байгууллагын ажилтан нар сонсголгүй хүүхдэд боловсрол олгох тохиромжтой сургалтын арга зүй, тэдний эх хэл дохионы хэл, сонсголгүй хүний соёл, онцлогийн талаар мэдлэгтэй байж, ажиллах арга зүйг эзэмшсэн байх нь чухал юм.

Сонсголгүй хүүхдэд зориулсан монгол хэлний хичээлийг хос хэл, соёлын арга зүйгээр заах зөвлөмжид сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш нар болон монгол хэл, уран зохиолын багш, бага ангийн багш нарт тухайн хичээлийг заахад нэн шаардлагатай арга зүйг тусган боловсруулсан болно.

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш сонсголгүй хүний тухай ойлголт болон тэдний хэл, соёл, онцлог, заах арга зүйн талаар мэдлэг, ойлголттой байх нь чухал юм. Орчин үед дэлхий нийтэд түгээмэл ашигладаг сонсголгүйн соёлын талаарх мэдээллийг зөвлөмжийн нэг болон хоёрдугаар хэсэгт оруулсан болно. Багш сонсголгүй хүний соёлын тухай ойлголт мэдлэг эзэмшсэнээр сонсголгүй хүүхэдтэй ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Зөвлөмжийн гуравдугаар хэсэгт сонсголгүй хүүхдийн унших, ярих, бичих чадварыг хөгжүүлэх, хэл зүйн үгийн сангийн ойлголтыг нэмэгдүүлэхэд хос хэл, соёлын арга зүйгээр сургалтыг хэрхэн зохион байгуулахыг жишээгээр тайлбарлав. Хос хэл, соёлын арга зүйгээр сургалтыг зохион байгуулахад багшаас дохионы хэлний өндөр ур чадвар шаардана. Иймээс сонсголгүй хүүхдийн багш дохионы хэлний мэдлэг, ур чадвараа сайжруулж, хос хэл, соёлын арга зүйгээр сургалтын үйл ажиллагааг явуулах нь сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх ач холбогдолтой.

Энэхүү хос хэл, соёлын арга зүйгээр монгол хэлний хичээл заах арга зүйн зөвлөмжийг зөвхөн монгол хэл, бага ангийн багш төдийгүй, бусад мэргэжлийн багш нар ч өөрсдийн судлагдахууны хүрээнд хос хэлний арга зүйгээр сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөж, зохион байгуулах нь чухал байна.

Багш нар сонсголгүй хүүхдэд хүртээмжтэй, чанартай боловсролыг олгоход эх хэлний бичгийн боловсролыг чухалчилж авч үзэх нь нэн тулгамдаж буй асуудлын нэг бөгөөд энэ хүрээнд монгол хэлний хичээлийг хос хэл, соёлын арга зүйгээр заах арга зүйн зөвлөмжийг хичээл сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг хүсэж байна.

БАГШ ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага

ХБХЭТК – Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц

ICED – Сонсголгүй хүний боловсролын талаарх чуулган

ЕБС – Ерөнхий боловсролын сургууль

БШУЯ – Боловсрол Шинжлэх Ухааны Яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Боловсрол соёлын ба анагаах талын хандлага сонсголгүй хүүхдийн боловсролд
- Хүснэгт 2. Хурууны үсгийг илэрхийлэх аргачлал
- Хүснэгт 3. Сонсголтой ба сонсголгүй хүний ахуй соёлын харьцуулалт
- Хүснэгт 4. Сонсголгүй хүүхэд аман хэл ба хос хэл соёлын орчинд суралцснаар гарах үр дагаварын харьцуулалт
- Хүснэгт 5. Үгийн утгыг таниулахад ашиглах зураг
- Хүснэгт 6. Үгүйсгэх нөхцөлийг дохиогоор илэрхийлэх нь
- Хүснэгт 7. Цагаар төгсгөх нөхцөлийг илэрхийлсэн дохио, тайлбар
- Хүснэгт 8. Шүлгийн мөрийг дохионы хэлээр хэрхэн илэрхийлэх талаар
- Хүснэгт 9. Зүйр үгийг дохиогоор тайлбарлах, таниулах аргачлал
- Хүснэгт 10. Өгүүлбэр дэлгэрүүлэх ажлын хуудас
- Хүснэгт 11. POSTER аргын тайлбар
- Хүснэгт 12. Үеийн хэлбэр
- Хүснэгт 13. Эгшиг зохицох ёс
- Хүснэгт 14. Үгсийн аймгийн ангилал (дэлгэрэнгүй)
- Хүснэгт 15. Бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврыг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 16. Үгсийн аймгийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 17. Үгсийн аймгийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 18. Нэрийн дагавар, нөхцөлийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 19. Үйлийн дагавар, нөхцөлийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 20. Олон тооны дагаврыг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 21. Тийн ялгалын нөхцөлийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 22. Дагавар, нөхцөлийн үүргийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ
- Хүснэгт 23. Бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврыг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ

ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ

Зураг 1.	Хос хэл, соёлын арга зүйн бүтцийн зураг
Зураг 2.	MRI тархины өнгөт зураг
Зураг 3.	Дохионы хэлний таван бүрдүүлбэрээр задлах аргачлал
Зураг 4.	Зурагтай болон зураггүй хэрчмэл үг
Зураг 5.	Дохионы хэл, зураг, бичвэр бүхий үзүүлэн
Зураг 6.	Хөдөлгөөнт цахим хичээлийн зураг
Зураг 7.	Хичээлийг дохиогоор илэрхийлсэн дүрст бичлэг
Зураг 8.	Бичвэр, зураг бүхий хэрчмэл үгтэй карт
Зураг 9.	“А” үсгийг зөв илэрхийлэх нь
Зураг 10.	“Г” үсгээр эхэлсэн дохионы зураг
Зураг 11.	“Г” үсэг таниулахад ашиглах үзүүлэн материал
Зураг 12.	“М” үсгийн үе таниулахад ашиглах үзүүлэн
Зураг 13.	Юмсын зураг болон нэр бүхий үзүүлэн
Зураг 14.	Үгийн утгыг таниулахад ашиглах зураг
Зураг 15.	Өгүүлбэрийн утгын ялгааг илэрхийлэх зураг
Зураг 16.	Үлгэрийн дүрийг танилцуулах үзүүлэн
Зураг 17.	Үлгэрийн үйл явдлыг илэрхийлсэн үзүүлэн
Зураг 18.	Үлгэрийн бодох, ярих үйлдлийг илэрхийлэх үзүүлэн
Зураг 19.	Үлгэрийн дүрийг хэрхэн ялгаж дохих талаар
Зураг 20.	Салаа утгатай үгийг таниулахад ашиглах материал
Зураг 21.	Эсрэг, ижил, ойролцоо үгийг таниулахад ашиглах материал
Зураг 22.	Өгүүлбэр зохион бичүүлэх үзүүлэн

ЗАГВАРЫН ЖАГСААЛТ

- | | |
|------------|---|
| Загвар 1. | Хэлэлцүүлэг зохион явуулах дараалал |
| Загвар 2. | Блүүмийн асуулт |
| Загвар 3. | Кирилл үсгийн зөв бичихийн ангилал |
| Загвар 4. | Эгшгийн ангилал |
| Загвар 5. | Зөв бичих дүрэм |
| Загвар 6. | Үгсийн аймгийн ерөнхий ангилал |
| Загвар 7. | Нэрийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 8. | Нэрийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 9. | Цагаар төгсгөх нөхцөлийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 10. | Үйлийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 11. | Үйлийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 12. | Жинхэнэ нэрийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 13. | Үгсийн аймгийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ |
| Загвар 13. | Хэл заслын хичээлд өргөн хэрэглэгддэг үг хэллэг бага ангийн монгол хэлний суралцахуйн удирдамжид тусгагдсан жишээ |

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1.1. СОНСГОЛГҮЙ ХҮНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Өнөөгийн нийгэмд сонсголгүй хүнд хандах ерөнхий хоёр хандлага байдаг бөгөөд энэ нь нэгдүгээрт, боловсрол соёлын хандлага, хоёрдугаарт анагаахын хандлага юм. Энэхүү нийгэмд тогтсон хандлага нь сонсголгүй хүнийг үнэлэх, хүндлэх, харилцах, боловсрол, мэргэжил эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд оролцох гэх мэт хувь хүний болон нийгмийн харилцааны бүхий л хүрээг хамруулан нөлөөлж байдаг нь тухайн хүний хөгжилд дэмжлэг эсвэл саад болдог байна.

Боловсрол соёлын хандлага нь сонсголгүй хүмүүсийг нийгмийн бие даасан иргэн бөгөөд нийгмийн бүхий л салбарт жирийн сонсголтой хүмүүсийн адил үнэлдэг буюу сонсголгүй хүмүүсийг нийгэм “хүн” гэсэн утгаар нь авч үзэж, тэднийг бусдын адил сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд бие даан оролцох боломжтой хүмүүс гэж үздэг. Харин **анагаахын талын хандлага** нь сонсголгүй хүнийг “хүн” хэмээх үнэт зүйл, бүхэллэг чанараар нь авч үзэхээс илүү сонсохгүй байгаа чихийг нь онцгойлон авч үздэг байна. Чих нь сонсохгүй байгаа учраас тухайн хүнийг хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй, бие эрхтний эмгэгтэй хэмээн эрхтэн тогтолцооны өөрчлөлттэй гэж дүгнэж, түүнийг хөгжих боломж, чадвар чадамжийг үнэлэхэд хүндрэлтэй байдаг.

Боловсрол соёлын болон анагаахын хандлагаар сонсголгүй хүнийг хэрхэн тодорхойлдогийг авч үзвэл:

Анагаахын талаас тайлбарлавал:

“Сонсох эрхтний аливаа нэгэн гэмтэл, өвчлөлийн улмаас эсвэл удамшлын шалтгаанаар сонсох эрхтэн нь үүргээ ямар нэгэн хэмжээгээр гүйцэтгэж чадахгүйгээс улмаар тухайн хүний хэл яриа нь хөгжөөгүй буюу сонсголын бэрхшээлтэй болсон хүнийг сонсголгүй хүн гэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Боловсрол, соёлын талаас тайлбарлавал:

Сонсголгүй суралцагч болон иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үздэггүй бөгөөд харин тэднийг өөрсдийн бие даасан хэл (дохионы хэл) соёлтой (хараан дээр суурилсан соёл) хэлний цөөнх хэмээн үздэг.

Дээрх хоёр хандлага нь сонсголгүй хүүхдийн боловсролд өөр өөрсдийн хандлагаар тайлбарладаг ба сонсголгүй хүүхдийн сурч хөгжих, боловсрол эзэмшихэд хүндрэл учруулдаг.

Хүснэгт 1. Боловсрол соёлын ба анагаах талын хандлага сонсголгүй хүүхдийн боловсролд

Боловсрол соёлын хандлага	Согог зүй буюу анагаах талын хандлага
<ul style="list-style-type: none">• Энэ хандлага нь сонсголгүй хүүхдэд үр дүнтэй, чанартай боловсрол олгох нэг чухал хөшүүрэг нь болдог.• Сонсголгүй хүүхдийн тусгай сургуульд судалгаагаар нотлогдсон дэвшилтэт заах арга зүй буюу хос хэл, соёлын арга зүйг нэвтрүүлж, сонсголгүй сурагчдад эх хэл болох дохионы хэлээр боловсрол эзэмших	<ul style="list-style-type: none">• Сонсохгүй байгаа учир сурч чадахгүй гэж үзэн, сонсох чадварыг сайжруулах /дунгийн суулгац суулгаж/ сонсдог болгох гэж оролддог.• Дохионы хэлийг хүлээн зөвшөөрдөггүй ба үлдэц сонсгол дээр нь суурилан аман хэл сургах гэж чармайдаг.

<p>бүхий л боломж нөхцөлийг бий болгож өгдөг.</p> <ul style="list-style-type: none">• Сургалтын байгууллага нь сонсголгүй хүний соёлд суурилсан хараагаар мэдээлэл хүлээн авч суралцах орчин бүрдүүлдэг.	<ul style="list-style-type: none">• Үлдэц сонсголгүй учир аман хэлд сурахгүй бол уруулаас уншуулах буюу хүний амны хөдөлгөөнийг хараад юу ярьж байгааг уншуулж сургахыг зорилго болгодог.• Энэхүү хандлагаар сонсголгүй хүүхдийн мэдлэг, чадварыг хөгжүүлэхээс илүү сонсож, ярихыг хөгжүүлэхийг хичээдэг.
--	--

1.2. ХОС ХЭЛ, СОЁЛЫН АРГА ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Хос хэл соёлын арга зүй гэдэг нь:

Хос хэл соёлын арга зүй нь дохионы хэлийг бичгийн монгол хэлтэй хослуулан, монгол ахуй соёл болон харааны хүртэхүй дээр суурилсан сонсголгүй хүний соёлыг хослуулан сургалтаа явуулж боловсрол олгоход чиглэнэ. Хос хэл, соёлын сургалтын хөтөлбөр нь хүүхдийг сурган хүмүүжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаа, хүүхэдтэй харилцах болон бүх төрлийн хичээлд (математик, нийгмийн ухаан г.м) дохионы хэл болон бичгийн хэлийг хослуулан хэрэглэх, сонсголгүй хүүхдийг сонсголтой болон сонсголгүй хүнтэй хичээлийн танхимд, гадаад орчинд, нийгэмд буюу ямар ч орчинд чөлөөтэй харилцаж чаддаг болгон сурган хүмүүжүүлэх сургалтын хөтөлбөр юм. /Soltero, 2004/ Монгол улсын хувьд монгол дохионы хэл ба монгол бичгийн хэлийг хослуулсан арга зүйгээр сонсголгүй хүүхдэд боловсрол олгоно.

Зураг 1. Хос хэл, соёлын арга зүйн бүтцийн зураг



2010 оны 7-р сард Канад улсын Ванкувер хотноо сонсголгүй хүний боловсролын талаарх олон улсын 21-р конгресс (ICED) хуралдсан. Уг чуулга уулзалтаар 1880 онд сонсголгүй хүүхдийг аман хэлний арга зүйгээр боловсрол эзэмшүүлэх шийдвэр гаргасан байна. 1880 оноос 1960 он хүртэл 100 шахам жил сонсголгүй хүүхдийг аман хэлний арга зүйгээр боловсрол эзэмшүүлж байсан. 1960 оноос хойш дохионы хэл сонсголгүй хүний төрөлх хэл мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, дохионы хэлээр боловсрол олгож эхэлсэн. 1987 оноос сонсголгүй хүүхдэд чанартай, үр дүнтэй боловсрол олгох арга зүй нь хос хэл, соёлын арга зүй болохыг баталж, олон улс оронд уг арга зүйгээр сонсголгүй хүүхдэд боловсрол олгодог болсон.

Эх хэл нь хүүхдийн хөгжилд чухал үүрэгтэй гэдгийг нь анхаарах хэрэгтэй. Эх хэл бол хүүхдийн хөгжлийн олон талуудын (танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн, нийгмийн) суурийг тавих, хөгжүүлэхэд маш их үүрэгтэй. Ялангуяа сонсголгүй хүүхдийн хэл ярианы хөгжлийн суурийг эрт оролцооны бага, балчир насанд нь эх хэл болох дохионы хэлээр харилцан ярианд сургах нь чухал юм.

Аливаа гадаад хэлийг сурахад өөрийн эх хэлээрээ дамжуулан суралцдагтай адил сонсголгүй хүүхдэд эх хэлээр нь буюу дохионы хэлээр заах арга зүйг ашиглан, дохионы хэлний бүтцээр ярьж, учрыг тайлбарлан ажиллах нь үр дүнтэй байна.

Хос хэлээр заах арга:

Хүүхэд хоёр дахь хэлээр чөлөөтэй ярихаас өмнө эх хэлээ анхлан эзэмшдэг хос хэлний боловсролын гол арга бөгөөд хоёр дахь хэлээр чөлөөтэй ярих гэдэгт тухайн хэлээр ярих, бичих, унших чадвартай болохыг хэлнэ.

Сонсголтой хүүхдэд багш шинэ үгийг тайлбарлахдаа аман ярианы хэлээр ярьж, хэрхэн бичихийг заахдаа баруунаас зүүн рүү, дээрээс доошоо, доороос дээшээ, дармал, бичмэл үсэг, том, жижиг үсэг гэх мэтчилэн үйлдэл бүрийг хүүхдийн мэддэг аман ярианы хэлээр хэлж өгдгийг хос хэлээр хичээлээ зааж байна гэнэ.

Учир нь төрөлх эх хэл болох ярианы монгол хэл дээр тулгуурлан бичгийн монгол хэлний боловсролыг эзэмшүүлж байна гэсэн үг юм. Дохио зангаа, хурууны үсэг зэрэг нь эх хэл болох монгол дохионы хэлээр бичгийн монгол хэлний боловсролыг олгох шаардлага тулгараад байна.

Хүүхдийн хэл ярианы хөгжлийн үе 0-3 насанд идэвхтэй байдаг боловч дийлэнх эцэг эхчүүд дохионы хэлийг мэддэггүйгээс улбаалан сонсголгүй хүүхэд санаа бодлоо үгээр (дохиогоор) илэрхийлэх насанд нь дохио зангаа, ахуйн хэрэглээний цөөн дохионы үгээр харилцдаг байх тохиолдлууд их байна. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн хүүхэд дохионы хэлээр ярьж сурчихаад сургуульд ордог бол сургуулийн өмнөх боловсрол эзэмшээгүй хүүхэд дохионы хэлний анхан шатны ч мэдлэггүй 1 дүгээр ангид элсэж байна. Энэ үед багш юуны түрүүнд тус хүүхдийн хэл яриаг хөгжүүлэхэд буюу дохионы хэлийг сургахад анхаарлаа хандуулах нь чухал байна. Ярианы хэлийг эзэмшсэн хүүхэд дараагийн хэлийг асуудалгүй сурна. Энгийн харилцан ярианы үгээр ч харилцаж чадахгүй байгаа хүүхдэд бичгийн хэлийг шууд заах нь ойлгох, суралцах явцыг удаашруулах болно. Энэ мэтчилэн төрөлх хэлээ эзэмшээгүй хүүхэд сургуульд шууд элсэн суралцаж, улмаар ЕБС-ийн хөтөлбөрийг эзэмшихэд хүндрэлтэй байх нь олонтаа тохиолдоно. Жишээ нь:

“Аав” гэсэн дохиог зааж өгөхдөө “аав”-ын зургийг бэлтгээд хүүхдийн хэд хэдэн удаагийн давтамжтайгаар аав гэж дохиж үзүүлнэ. Дараа нь зураг дээрх аав руу заагаад дахин аав гэж дохино. Хүүхэд зөв дохиж сурсны дараа аав хаана байна гэх мэтээр бататгасан асуултуудыг асууна.

Хичээлийн турш хуулан бичлэг хийлгэх нь хүүхэд бичиж буй зүйлийн талаар ойлголт өгөхөөс илүүтэй цэвэр бичих, үгийг алдаагүй бичих дадалд л сургана. Сонсголгүй сурагч харь хэлийг сурч байгаа учраас хичээлээ хөтөлбөрийн дагуу орохын зэрэгцээ шинэ үгийг тасралтгүй цээжлүүлж байх нь чухал. Жишээ нь: Гарах гэсэн үг нь үндсэн ба салаа утгатай. Тэдгээр утгын хоорондын ялгааг тайлбарлаж ойлгуулна. Утга өөр ч нэг үгээр бичигдэж байгаа нь дохионы хэлэнд мөн нэг янзаар дохигдохгүй гэдгийг сануулна. Техник технологи хөгжсөн энэ үед үгсийн салаа утгын зургийг интернетээс хайж зураг ашиглан тайлбарлавал илүү ойлгомжтой байх болно. Хамраас цус гарах, нар гарах, гэрээс гарах, сургуулиас гарах (хаалгаар), сургуулиас гарах (бүр мөсөн гарах), ууланд гарах, гараанаас гарах гэх мэт.

Монгол хэлний хичээл дээр эх, зүйр цэцэн үг, шүлэг, яруу найраг, хэлц үг зэргийг хүнд, хөнгөн гэж ялгалгүй анги бүрийн номон дээр байгаа сэдвийн хүрээнд хичээлээ явуулах, тэдгээрийг механикаар цээжлүүлэлгүй далд утга илэрхийлэх гэсэн санаа зэргийг ярилцах, тайлбарлаж өгөх замаар сэтгэх, төсөөлөх чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мэдээж дүрс бичлэг, зураг ашиглавал хүүхдүүд шүлэг, яруу найргийн утга уялдаа хамаарлыг ч хамтад нь сайтар тогтоох болно.

Дохионы хэл, бичгийн монгол хэл хоёр нь нийгэмтэй хөл зэрэгцэн алхахад маш чухал үүргийг гүйцэтгэх салшгүй холбоотой хос хэл гэдгийг ямагт бодолцоно. Эцэг эх, хүүхэд, багш гурвын хамтын ажиллагаа ч чухал хувь нэмрээ оруулна.

Харь хэл

Сонсголгүй хүүхдийг бичгийн хэлийг сурах боломж хомс, оюуны чадавх доогуур гэж үнэлэх буруу ойлголтууд түгээмэл байдаг. Гэвч монгол хэл нь тэдэнд харь хэл гэдгийг хараахан анзаараагүй хүмүүс бий. Казах, Тува хүүхдийн нэгэн адилаар амьдарч буй газраас шалтгаалан өөрийн ярьж буй хэлнээс огт өөр хэлийг сурах хэрэгцээ тулгарч байна гэсэн үг юм. Нэг ялгарах зүйл нь сонсголгүй хүүхдүүд монгол ярианы хэлийг сурахгүй зөвхөн бичгийн хэлийг сурна.

Англи хэлийг монгол сонсголтой хүнд заахдаа тэдэнд тохируулж дүрэм, үгийн санг цөөлөхөөс илүүтэйгээр эх хэл дээр нь бүх дүрэм, үг, өгүүлбэрийг сайтар ойлгуулахын тулд маш их дадлагыг хийдэг. Хэрэв хүүхдийн ялгаатай хэрэгцээг харгалзан хөтөлбөрийг хөнгөвчилбөл тэр хэрээр хязгаартай сэтгэж, бичиж, уншина. Төгсөөд их сургуульд орох үед ердийн ЕБС төгссөн хүүхэдтэй харьцуулахад харьцангуй муу мэдлэг эзэмшсэн байх учраас цаашдын суралцах үйлд хүндрэл учирна. Дохионы хэлийг маш сайн эзэмшиж, сонсголгүй хүүхэд бүрт монгол хэлний дүрмийг дохионы хэлээр зааж тасралтгүй унших, бичих, харах, ярих дадлагыг хийснээр бодит үр дүнд хүрэх болно.

Харааны хүртэхүй дээр суурилсан хэл (дохионы хэл), соёл (сонсголгүй хүн)

Бид аман ярианы хэлээр өдөр тутамдаа харилцахдаа харилцаж байгаа хүнийхээ нүд рүү тасралтгүй харж ярьдаггүй. Өөр үйлдэл хийнгээ, өөр зүг рүү харж байхдаа ч хэлж буй үгсийг сонсож, хариулж байдаг. Гэтэл дохионы хэл нь амаар бус хөдөлгөөн, биеийн хэлэмж, гараар илэрхийлэгддэг хэл учраас зайлшгүй өгүүлж буй хүн рүү төвлөрч, нүд салгалгүй харж байж авах ёстой мэдээллийг бүрэн дүүрэн хүлээж авна. Зөвхөн харилцаагаар хязгаарлагдахгүй хонх, машины дуут дохио, зурагтын мэдээ, нэвтрүүлэг, нэрээр дуудах гэх мэт гаднаас ирж буй дуу чимээтэй мэдээллийг хүртэл хараагаар хүлээж авах боломжтой хэлбэрээр орлуулах нь зүйтэй юм. Жишээ нь:

1. Сонсголгүй суралцагчдад хичээл орох үед хонх дуугаргахын оронд завсарлагаа эхлэх, дуусах цагийг илтгэсэн өнгөөр анивчдаг гэрлийг анги танхимд байрлуулах
2. Машины жолооч сонсголгүй хүн гэдгийг мэдсэн тохиолдолд түүнийг дуудахдаа дуут дохиогоо ашиглалгүй гэрлээ асааж, унтрааж анивчуулах
3. Зурагтын мэдээ, нэвтрүүлгийг болж өгвөл дохионы хэлний орчуулгатайгаар нийтэд хүргэх хэрэгтэй. Бид зурагт үзэхдээ дууг нь маш сул дээр нь тавьчхаад сонсох гэж оролдож, зоволгүй шууд л чангалж асуудлаа шийдэхийг хүсдэг. Үүнтэй нэгэн адилаар хэлмэрчийн дүрсийг маш жижгээр гаргах нь тэрүүхэн тэндээ дохиж байгаа жижиг хүнийг удаан харж буй сонсголгүй хүний хувьд нүд өвтгөх, мэдээллийг дутуу хүлээж авах, хурууны үсгийг огт харахгүй байх зэрэг асуудлуудыг дагуулна. Хэлмэрч байхгүй байгаа тохиолдолд хадмалыг оруулах.
4. Монгол улсад амьдрахдаа нэг нэр, өөр орны хаа нэгтээ очихдоо нэг нэрээр дуудуулдаг. Сонсголгүй хүн, тэдэнтэй харилцдаг хүн бүр өөрийн гэсэн дохионы нэртэй. Та ч дохионы хэлээр харилцагчдын эгнээнд нэгдэх гэж байгаа бол сонсголгүй хүмүүсээс өөрийн дохионы нэрийг аваарай. Хэчнээн чанга орилж, чанга чимээ гаргалаа ч бүрэн сонсголгүй болсон хүн үүнийг сонсож чадахгүй, үүнийг нь

мэдсээр байж орилж байгаа нь доромж утгыг илтгэнэ. Дохионы нэрээр дуудаж хэвшээрэй.

5. Уруулаас унших нь хараан дээр суурилсан хэлний нэг хэлбэр гэж андуурч болохгүй. Хэдий цагаан толгойн үсгийг, ижил амны хайрцагтай м, п, б, в гэх мэт үсгүүдийг уруулаас уншиж ялган таних арга зүй байж болох ч үг болон өгүүлбэр бүтэхэд утга, агуулга, үг, үсэг гээлгүй ойлгоход хүндрэлтэй байна. Амны хайрцаг ижил илэрхийлэгдэх хэдэн арван үгс байгаагаар зогсохгүй уруул хөдлөлгүйгээр илэрхийлэгдэх үгс ч цөөнгүй байдаг.
6. Дохионы хэлээр өгүүлж байгаа зүйл нь хийсвэр зүйл ч бай бодит зүйл ч бай нүдэнд харагдахуйц дүрслэлтэй байж гэмээн таны хэлж байгааг түргэн ойлгоно. Учир нь ярианаас тань бүх зүйлийг кино мэт бодит болгон тархиндаа төсөөлөн харилцан яриа өрнүүлдэг нь тэдний биднээс ялгарах нэг онцлог болно.
7. Сонсголгүй хүн хараагаар мэдээлэл авдаг учраас харах мэдрэхүй өндөр хөгжсөн байдаг. Энэ тэнд чимээ гарах, юм унах чимээ зэрэгт сонсголтой хүмүүс анхаарлаа хандуулдаг бол нүдний буланд хөдөлгөөн харагдах төдийд сонсголгүй хүмүүс тэр зүг рүү анхаарлаа хандуулна. Сонсголтой хүн сонсгол дээр суурилсан соёлтой, сонсголгүй хүн хараан дээр суурилсан соёлтой, хараан дээр суурилсан хэлээр ярьдаг юм.

Швед загвар

1980-аад оны эхээр Шведийн сонсголгүй хүүхдийн тусгай боловсролын сургуулиудад, үндэсний хэмжээнд эрх зүйн баримт бичигт маш олон чухал өөрчлөлтүүдийг авч ирсэн үе байсан. 1981 онд Швед дохионы хэлийг сонсголгүй хүмүүсийн эрх бөгөөд хос хэлтэй хэмээн хүлээн зөвшөөрч Шведийн засгийн газар баталснаар үндэсний хөтөлбөртөө тусгаж, шинэ санаачилга, үйл ажиллагааны хэрэгжилтийг сонсголгүй хүүхдийн сургуульд нэвтрүүлж эхлэх боломжтой болсон юм. (SVARTHOLM, 2010b).

Сонсголгүй хүүхдийн өөрсдийн эх хэл нь болох дохионы хэлэнд суурилж хос хэлний арга зүйгээр заах загвар арга зүйг аливаа хоёр дахь хэлийг заахад суурь хэл болгон ашиглаж заах, СӨБ-ийн хүрээнд, мөн түүнчлэн гэр бүлийнхэн нь хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэхэд нь заавал ч үгүй маш сайн дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй юм. Хоёр дахь хэл гэдэг нь ярианы хэлийг бус голчлон бичгийн хэлийг хэлж байгаа ба нийгмийн харилцаанд ашиглагддаг бичгийн хэлний бүтцийг тодорхойлох юм. Учир нь бичгийн хэлийг хараагаараа хүртээмжтэйгээр хүлээн авч чаддаг бол ярианы хэлийг харааны хүртэхүйгээр хүртэх боломжгүй учраас ийнхүү хоёр дахь хэл гэдэгт тухайн улсын хэлний бичгийн хэлийг хэлж байна гэсэн үг.

Шведийн хэл шинжээчийн тусламжтайгаар сургуулиудад хөгжлийн ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор сонсголгүй ба сонсголтой хүүхдийн хоёр дахь хэлний эзэмшихүйн ялгаа ба ижил талыг илрүүлэхээр судалгаа хийсэн. (SVARTHOLM, 2006, 2010b, SCHÖNSTRÖM, 2010). Хэл шинжээчид ба багш нарын хамтарсан багаар анги танхимын хүрээнд судалгаа хийгдсэн. Сонсголгүй багш, суралцагчид эхийг уншаад эхэд илэрхийлэгдэж буй утгыг Швед дохионы хэлээр хэлэх маягаар сонсголтой багш, суралцагчид ч адилхан даалгаврыг гүйцэтгүүлэн харьцуулах зорилготой байсан бөгөөд багш нар хэлний талаас хэл шинжлэлийн илэрхийллүүдийг эхээс олж тайлбарлаж байсан бөгөөд тэд хоёр хэлийг харьцуулж хэл шинжлэлийн онцлог талуудыг тайлбарласан судалгааны ажил болсон. (MAHSHIE, 1995, SVARTHOLM, 1993).

1.3. ДОХИОНЫ ХЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Дохионы хэлний үүсэл ба түүхэн баримт

МЭӨ 5 дугаар зууны Грекийн үед дохио зангааг харилцааны нэгэн хэлбэр болгон ашигладаг байсан тухай тэмдэглэсэн байдаг ба Барууны орнуудад 17 дугаар зууны үеэс дохионы хэл нь хараан дээр суурилсан хэл буюу харилцааны нэгэн арга хэрэгсэл хэмээн тэмдэглэгдэжээ. Дохионы хэл нь дохио зангаа, нүүрний хувирал, хөдөлгөөн, гарын дохио, цагаан толгойн хурууны үсгүүдийг илэрхийлэх гарын байрлал зэрэг өөрийн гэсэн тогтолцооноос бүрдсэн хэл юм. Дохионууд нь гагцхүү үгсийг илэрхийлэхээс гадна ямарваа нэгэн зүйлийн утга санаа, үг хэллэгийг бүрэн гүйцэд илэрхийлэх боломжтой байдаг.

Дохионы хэл нь байгалийн жам ёсны хэл бөгөөд аман ярианы бүтцээс ялгаатай бүтэцтэй байдаг ба сонсголгүй хүмүүс болон тэдэнтэй ойр харилцдаг хүмүүс уг хэлээр харилцдаг. Дэлхий дахинаа олон дохионы хэл бие даан хөгжиж ирсэн учир хамгийн анхны дохиог тодорхойлох боломжгүй байдаг. Дохионы хэлний бүтэц, тогтолцоо болон хурууны үсгийн гарын авлага нь дэлхий даяар танигдаж, түгээн дэлгэрсэн. 19 дүгээр зууныг хүртэл дохионы хэлний тухай бидний мэдэх мэдлэг нь олон баримтжуулалт, судалгаанаас илүүтэй аман ярианы хэлнээс үгийг дохионы хэл рүү хөрвүүлэхэд хялбарчлах байдлаар ашигладаг цагаан толгойн хурууны үсгийн гарын авлага (хурууны үсгийн систем)-р л хязгаарлагддаг байжээ.

Дохионы хэлний тодорхойлолт

Дохионы хэл нь амаар бус гараар илэрхийлэгддэг, чихээр бус нүдээр сонсогддог сонсголгүй хүний эх хэл юм. Энэхүү хэл нь дэлхийд нэг ижил хэлбэрээр ашиглагддаггүй, орон орны сонсголгүй иргэд өөр өөрийн улсынхаа дохионы хэлийг харилцаандаа ашигладаг. Дэлхийн даяаршлын нөлөөгөөр дохионы хэл бол бие даасан бүтэц, дүрэмтэй хэл шинжлэлийн судлагдахуун бүхий бие даасан хэл мөн гэдгийг олон эх сурвалж, бичиг баримтуудад дурдаж дэлхий дээрх олон үндэстний хэлтэй эн зэрэгцэхүйц үзэл баримтлал бий болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 2 дугаар зүйлд бичигдсэн тодорхойлолтод: *“Language” includes spoken and signed languages and other forms of non spoken languages;* буюу *“Хэл” гэдэгт аман ярианы болон дохионы хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг хамааруулна;* гэсэн байдаг. Ийнхүү дохионы хэл бол хараан дээр суурилсан хэл бөгөөд хэл шинжлэлийн хүрээнд олон нарийн дүрэм, бүтэц, тогтолцооноос бүрдсэн сонсголгүй хүмүүсийн эх хэл мөн.

Дохионы хэл бол жам ёсны хэл

Дохионы хэлний тухай нэгэн буруу ойлголт байдаг нь дохионы хэлийг зөвхөн дохио зангаа юм уу пантомимо гэх үзэл юм. Энэ бол үнэнд нийцэхгүй бөгөөд ярианы хэлний нэгэн адил дохионы хэл нь уламжлалт үгийн сангаас эх авсан нарийн түвэгтэй хэл зүйн тогтолцоотой. Байгалиас заяасан дохионы хэл бол хэн нэгний зохион бүтээсэн зүйл биш, харин сонсголгүй хүмүүсийн дунд хувьсан өөрчлөгдөж ирсэн байна. Түүний нэгэн адил дохионы хэл бол ярианы хэлний үзэгдэх байдлын төлөөлөл бас биш юм. Дохионы хэл нь үсэг үсгээр гараараа бүх л үгийг галиглах албагүй. Ихэвчлэн ярианы хэлний үгсээс өөр дэс дарааллаар өрнөдөг. Дохионы хэлээр аливаа ойлгохуйц үзэл баримтлал, санаа бүрийг илэрхийлж болно.

Дохионы хэлний нийгмийн бүлэг бүр хэл шинжлэлийн хувилбарын онцлогтой. Ярианы

хэлэнд байх ганц үгтэй уялдах олон төрлийн дохио байх нь цөөнгүй. *Монгол Үндэсний Дохионы Хэлний Хөгжлийн Зөвлөл, 2017 (Хамтран ажиллахуй-Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хүрээнд Хэрэгжүүлэх Дохионы Хэлний Гарын Авлага номын орчуулсан хувилбар)*

Дэлхий дахинаа хэрэглэгдэж буй дохионы хэл нь олон жилийн тэртээгээс тодорхой нийгмийн бүлгүүдийн дунд хэрэглэгдэж, оршин тогтносоор ирсэн тул асар их үгийн сантай (дохионы сан) , баялаг түүхтэй хэл юм. Тиймээс шинэ үг буюу дохиог шинээр зохиож, хөгжүүлэх шаардлагагүй бөгөөд өнөөгийн өдөр тутмын харилцаанд хэрэглэгдэж буй дохионуудыг судалж, тухайн улсын яриа болон бичгийн хэлэн дэх ямар үг дохионы хэлэн дэх үгтэй утга нэг байгааг судлан тодорхойлох дохиог үгжүүлэх судалгааны ажлыг хийх нь орон орны нэн тэргүүний шийдэх асуудал болоод буй. Нийгэм цаг үеийн хувьсал, шинэчлэлийг даган хүмүүсийн харилцаанд нийтээр хэрэглэх шинэ үг, хэллэг үүсдэг. Тухайн улсын хэлний санд шинэ ухагдахуун, үгс нэмэгдэхэд дохионы хэлний сан зэрэгцэн хөгжиж баяжиж байдаг.

Дохионы хэл ба сонсголгүй хүүхдийн боловсрол

Сонсголтой хүүхэд төрсөн цагаасаа эхлэн аливааг амаараа хэлэхийг оролдон шулганаж байдаг нь аман ярианы хэлд орох гэж байгаа хүүхдийн зөнгөөрөө үйлдэгддэг үйл юм. Сонсголгүй хүүхэд ч өөрийн хэрэгцээ, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийн тулд гараараа шулганах буюу үгийн дохиог гүйцэд бус илэрхийлж байгаа нь дохионы хэлээр хэлд орох гэж байгаагийн илрэл.

Сонсголтой хүүхэд төрсөн цагаасаа эхлэн аливааг амаараа хэлэхийг оролдон шулганаж байдаг нь аман ярианы хэлд орох гэж байгаа хүүхдийн зөнгөөрөө үйлдэгддэг үйл юм. Сонсголгүй хүүхэд ч өөрийн хэрэгцээ, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийн тулд гараараа шулганах буюу ямарваа нэгэн үгийн дохиог бүрэн зөв биш ч дөхүүлэн чадахаараа илэрхийлж байгаа нь дохионы хэлээр хэлд орох гэж байгаагийн илрэл бөгөөд хүн төрөлх хэлээ байгалийн жам ёсоор суралцаж, өөртөө шингээн хэл ярианы хөгжлийн эхлэлийг тавьж буйтай адил юм. Дохионы хэл нь сонсголгүй хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, нийгэмшихүйн гээд бие хүний цогц хөгжилд маш чухал голлох үүргийг гүйцэтгэдэг. Дохионы хэлийг сурах, дохионы хэлээр боловсрол олгохтой холбоотой нийгэмд түгсэн ташаа ойлголт нь сонсголгүй хүүхдийн хэл яриа, танин мэдэхүйн хөгжилд саад болно.Энэ нь сонсголгүй хүүхдийг анагаах, эмнэл зүй талаас хандах хандлагаас үүдэлтэй юм. Тархи, мэдрэлийн шинжлэх ухааны талаас дохионы хэлний сөрөг нөлөөллүүдийг баталж, нотлон гаргаж ирсэн холбогдох судалгааны баримт бичгүүд байдаггүй, харин ч эсрэгээрээ дохионы хэл нь сонсголгүй хүүхдийн тархинд ямар эерэг ач холбогдолтой, аман ярианы хэлтэй эн дүйцэх тархины хариу үйлдэл, идэвхжлүүдийг харуулсан судалгаанууд олон байдаг.

2004 онд танин мэдэхүй, неврологи буюу тархи шинжлэлийн профессор Мак Свийний нь дохионы хэлээр болон ярианы хэл дээр яригдсан яриа сонсголтой болон сонсголгүй хүний тархинд хэрхэн хүлээн авч, тархины аль хэсгүүд идэвхжиж байгааг судлахаар англи хэлээр ярьдаг нэг сонсголтой хүн болон англи дохионы хэлээр ярьдаг нэг сонсголгүй хүнийг судалгаанд оролцуулжээ. Судалгаанд оролцогч талуудад өөрсдийнх нь эх хэл дээр нэг өгүүлбэрийг хэлэхэд тархи, мэдрэлийн үйл ажиллагаанд ажиглагдсан зөрүүтэй үзүүлэлт байгаагүй бөгөөд сонсголтой хүний тархи нь аман ярианы хэлээр мэдээллийг хүлээн авахад тархины сонсголын төв нь илүү идэвхжиж


харагдсан бол Британи дохионы хэлийг харааны хүртэхүйгээр хүлээн авч буй сонсголгүй хүний визуал буюу харааны мэдрэхүй илүү өргөн хүрээнд идэвхжиж, боловсруулагдаж байгаа нь судалгаагаар тогтоогджээ. Уг судалгааны дүгнэлтэд аудио-визуал болон визуал хэлбэрээр ялгаатай хүлээн авч буй ярианы болон дохионы хэлний бүтэц нь тархины идэвхжилд ялгаагүй хариу үйлдэл үзүүлж байдаг бөгөөд хэл шинжлэлийн бүтэц талаас, тархинд очих хүртэхүйн ялгаатай байдлаас өөрөөр зөрүүтэй тархи мэдрэлийн үзүүлэлтүүд ажиглагдаагүй байна. MacSweeney M, Campbell R, Woll B,

Giampietro V, David AS, McGuire PK, et al. Dissociating linguistic and nonlinguistic gestural communication in the brain, *Neuroimage*, 2004, vol. 22 (pg. 1605-1618) <https://www.ucl.ac.uk/icn/people/mairead-macsweeney> Sign Language and the Brain: A Review | The Journal of Deaf Studies and Deaf Education | Oxford Academic (oup.com)

Зургийн тайлбар:

- (a) MRI тархины өнгөт зураг: Төрөлх англи дохионы хэлтэй сонсголгүй болон сонсголтой хүүхдийн англи дохионы хэлээр мэдээллийг хүлээн авч байгаа тархины идэвхжлийн зураг (эхний болон хоёр дахь багана) болон дохионы хэлгүй аудио-визуал хэлбэрээр мэдээллийг хүлээн авсан сонсголтой хүүхдийн тархины идэвхжлийн бүсчлэлийн зураг (гурав дахь багана)
- (b) Өнгөөр ялгарч харагдаж буй тархины хэсгүүд нь ямар нэг утгагүй дохио зангааг хүлээн авахаас илүүтэй англи дохионы хэлээр мэдээллийг хүлээн авахад хэрхэн өргөжин тэлж байгаа үзүүлэлт

Зураг 2. MRI тархины өнгөт зураг



Сонсголтой болон сонсголгүй суралцагчдын боловсрол эзэмших сургалтын хэл нь хоорондоо хүлээн авах аргаараа ялгаатай буюу нэг нь хараагаараа нэг нь сонороороо илүү мэдэрч, хүлээн авч тархиндаа боловсруулдаг гэсэн үг юм. Тиймээс дохионы хэл нь ярианы хэл дээрх бүх мэдээллийг тухайн яриаг хүлээн авч буй сонсголгүй хүнд адилхан бүрэн ойлгогдохоор байдаг гэхдээ тархинд өөр замаар хүрч боловсруулагдаж байдаг гэсэн үг юм.

Боловсрол эзэмших бүх шатлалуудад дохионы хэл нь тухайн сонсголгүй хүүхдийн сургалтын үндсэн хэл гэж хүлээн зөвшөөрөгдөж, дохионы хэлний орчин, харааны хүртэхүйд ээлтэй сургалтын материал, дохионы хэлний академик болон харилцааны

өндөр ур чадвартай багш, хэлмэрч зэрэг мэргэжлийн баг боловсролын хамтарсан үйлчилгээг үзүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Дохионы хэлээр харилцагчид

Сонсголгүй хүмүүс нь нийт хүн амын цөөн хувийг эзлэн хэлний цөөнх гэх бүлэгт хамаарагддаг ч дохионы хэлийг сонсголгүй хүмүүсийн нийгмийн бүлгүүдээс гадна тэдний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, тэдэнтэй ажилладаг багш нар, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч зэрэг бусад хүмүүс өргөнөөр хэрэглэж, дохионы хэлээр харилцагчдын тоо жил бүр нэмэгдэж байна. Дохионы хэлний хэрэглээ нь ярианы хэлний нэгэн адил жендер, нас, шашин, үндэс угсаа, гэх мэт хүчин зүйлийн нөлөөгөөр янз бүр байж болно.

Дохионы хэлийг зөвхөн сонсголгүй, сул сонсголтой хүмүүс л харилцаандаа ашигладаг бус тэдний цаана гэр бүлийн гишүүд, сонсголгүй суралцагчидтай ажилладаг багш, сурган хүмүүжүүлэгчид, орчуулгын үйлчилгээ үзүүлдэг дохионы хэлний хэлмэрч, орчуулагч нар, төрийн олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажилтнууд гэх зэрэг олон талт бүлгийн нэн хэрэгцээтэй харилцааны хэл мөн юм.

Одоогоор дэлхий дахинаа 300 гаруй дохионы хэл идэвхтэй хэрэглэгдэж байгаа бөгөөд орон орны сонсголгүй хүмүүс хоорондоо олон улсын дохионы хэлээр харилцаж, ойлголцоно.

Хурууны үсэг, биеийн хэлэмж, дохио зангаа, дохионы хэл

Дийлэнх хүмүүс дохио зангаа, хурууны үсэг ашиглаж сураад, түүнийгээ дохионы хэлийг сурчихлаа гэж эндүү боддог. Яг үнэндээ дохио зангаа, биеийн хэлэмж, хурууны үсэг нь дохионы хэлэнд туслах хэрэглүүр болж нийлэмж хэлбэрээр илэрхийлэгддэг.

Хурууны үсэг нь оноосон нэр буюу хүмүүсийн нэр, брендийн нэр, ном болон киноны нэр, улс орон, хотын нэрс зэргийг хэлэхэд л ашиглана.

Дохио зангаа нь хүмүүс хоорондоо аман ярианы хэлээр харилцаж байхдаа ярилцаж буй сэдвээ тодотгохын тулд гараа хөдөлгөх, ямар нэг зүйл рүү долоовор хуруугаараа зааж ярих зэрэг хөдөлгөөнийг давхар хийхэд хэрэглэгдэх бөгөөд энэ нь сонсголтой хүмүүст ч сонсголгүй хүмүүст ч адилхан утга санаагаар ойлгогддог нүүр царай болон биеийн энгийн хөдөлгөөний нэгдэл юм.

Биеийн хэлэмж мөн адил сонсголгүй, сонсголтой хүмүүсийн аль алинд илрэх ба үгээр харилцан ойлголцохдоо давхар биеийн байрлал, зогсолт, суулт, гар, хөлөө хөдөлгөн өөрсдийн сэтгэл хөдлөл, мэдрэмжээ гадаад үйлдлээрээ илэрхийлэхэд тус болно. Тиймээс дохио зангаа, биеийн хэлэмж зэрэг нь мэдрэгдэж буй мэдрэмжээ дохионы хэлээр илэрхийлэхээс гадна яриандаа сэтгэл хөдлөлийн дүрийг нэмж тодотгоход туслах хэрэглүүр хэлний бага нэгжид тооцогдоно.

Монгол цагаан толгойн хурууны үсэг

Орос цагаан толгойн хурууны үсэг Монгол улсад нэвтрэх үед “ө” болон “ү” хурууны үсгийг шинээр зохиож, 2012 онд БШУЯ-ны дэргэд монгол дохионы хэлний стандарт боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээрт үндэслэн хатуугийн тэмдгийн (ь) хурууны үсгийг өөрчилсөн. Өдгөө Монгол цагаан толгойн хурууны үсгийг хүний нэр, байгууллагын нэр, мэргэжлийн нэр томъёо, улс орон, газар усны нэр зэргийг хэлэхэд өргөн хэрэглэж байна.

Зөв үсэглэх дүрэм:

1. Баруун гараа баруун мөрний харалдаа чанх урд байрлуулна. (зүүн гараар үсэглэж болно. Гэхдээ хоёр гараа солбин үсэглэж болохгүй) Үсгүүдийг холбож үг бүтээхдээ цохилттой эсхүл хэт дээр, доор үсэглэлгүй нэгэн хэмнэлээр бугуйгаа зөөлөн хөдөлгөх,
2. й, ы, ь, ъ (хагас и, зөөлний...) гэх мэт үгээр хэлэгддэг үсгүүдийг хурууны үсгээр илэрхийлэх,
3. Ойролцоо харагддаг үсгүүдийн ялгааг таньж, ь, ъ үсгүүдийг дүрмийн дагуу үсэглэхийг анхаарах,

Урт эгшиг: Эхний үсгээ гарган зүүнээс баруун чиглэл рүү татах,

Хос эгшиг: Эхний үсгийн алгыг өөр лүүгээ харуулж гаргаад шууд дараагийн үсэг рүү шилжүүлэн хөдөлгөх,

Хүснэгт 2. Хурууны үсгийг илэрхийлэх аргачлал

МОНГОЛ ЦАГААН ТОЛГОЙН ХУРУУНЫ ҮСЭГ		
Гарын алга	Хөдөлгөөнгүй	Хөдөлгөөнтэй
Зүүн тийш харуулах	а, б, в, е, ж, к, н, о, р, с, ф, х, ч, ы, э, ю, я	ё, к, ө
Өөр лүүгээ харуулах	и, у, ү, ц, ш, щ	д, й
Урагшаа харуулах	-	з, ь, ъ
Өөр лүүгээ харуулж, хурууны үзүүрийг доошоо чиглүүлэх	г, л, м, п, т	-

Ихэнхдээ ь, ъ үсгийг зөв үсэглэж зааж өгвөл цаашид асуудалгүй зөв ялгаж бичиж чадна. Мөн ф үсэг.

Нутгийн аялгууны дохио ба ялгаатай дохигддог үгс

Нутгийн аялгууны дохио нь тодорхой нэг ястан буюу нутаг дэвсгэрийн хүрээнд зөвхөн нутгийн ард түмний цөөн хүний эрхэлдэг аж ахуй, зан заншил, хэлний түүхтэй уялдаж ярианы хэлэнд хэрэглэгддэг. Өөр өөр нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа сонсголгүй иргэдийн нэг үгийг илэрхийлэх дохио нь өөр хоорондоо ялгаатай байна.

Зарим тохиолдолд хэдий нэг үгийг дохиж байгаа ч хоорондоо бага зэрэг ялгаатай харагдах нь (далайцтай, гарын хэлбэр өөр, түргэн, удаан, зогсолттой г.м) нас, хүйс зэргээс хамаарна.

Монгол дохионы хэлний үүсэл ба хэрэглээ

1964 онд Улаанбаатар хотод сонсголгүй хүүхдийн 29 дүгээр тусгай сургууль байгуулагдах үед Оросын холбооны улсад мэргэшсэн багш нар орос хурууны үсэг ба зарим дохиог Монгол улсад нэвтрүүлж байсан. Тухайн үед орос хурууны үсэг, дохиог харилцаандаа түлхүү ашигладаг байсан ч сонсголгүй сурагчид, хүмүүсийн харилцааны явцад уран яруу дүрслэл, утга төгөлдөр монгол дохионы хэл үүсэж хөгжин, бий болсон. 2009-2010 онд тухайн үеийн БСШУЯ-ны санаачлагаар НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр анх удаа "Монгол дохионы хэлний түгээмэл дохио"-ны судалгааг хийсэн. Моррис Свадишийн бүх хэлэнд байдаг түгээмэл 200 үгийг дохионы хэлний

судалгаанд зориулсан Вүүдвардын 100 үгийн жагсаалтын дагуу хэдөө орон нутгийн 4 бүсэд судалгаа хийсэн. Орос дохионы хэл монгол дохионы хэлийг дээрх Үг-Статистикийн аргаар судалсан бөгөөд хоорондын харилцан хамаарал нь 16%-тай гарсан. 20% доош үзүүлэлт нь уг 2 хэл тусдаа бие даасан, өөр өөр дохионы хэлний гарал үүсэлтэй болох нь тогтоогдсон.

50-иад жил хэрэглэгдэж буй монгол сонсголгүй хүмүүсийн дунд хэвшиж тогтсон монгол дохионы хэлийг судлахын оронд хөгжүүлэх гэж оролдож байсан үе саяхан юм.

2016 он хүртэл монгол хэлний үгийн санд байгаа үгсийг дохионы хэлээр илэрхийлэх боломжгүй гэж эндүү ойлгон шинэ дохиог санаачлан 10 орчим дохионы хэлний сурах бичиг, толь бичгийг гаргасан. Эдгээрийн дийлэнх нь хэрэглээнд нэвтрээгүй, сонсголгүй хүмүүс ч өдөр тутмын харилцаанд хэрэглэгддэг эдгээр дохиог хүлээн зөвшөөрч, шинээр гарсан дохионуудыг ойлгохгүй байснаар нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй учраас монгол дохионы хэлийг судлах, хөгжүүлэх гэсэн арга барилаа өөрчилсөн байна. Өргөн хэрэглэгддэг дохио, өвөрмөц дохио, хэллэг дохио гэх мэт дохиог монгол хэлний үгсийн сангийн аль үгтэй утга дүйцэхүйц байгааг судлахыг дохиог үгжүүлэх гэнэ. Өмнө дурдсанчлан дохионы хэл нь бичгийн хэлний үг нэг бүртэй таарч тохирдоггүй. Нэг дохиог бичгийн (аман ярианы хэлний олон үгээр илэрхийлэх тохиолдол байдагтай нэгэн адил нэг бичгийн) ярианы хэл дэх үг олон дохиогоор илэрхийлэгдэнэ. Аль ч улсын дохионы хэлийг стандартчлах боломжгүй. Жишээ нь: “Орох” гэдэг үг нь үндсэн ба салаа утгыг агуулдаг. Бороо орох, хөлд орох, хөлд орох, гарч орох, ажилд орох, хаалгаар орох гэх мэт. Эдгээр “орох” гэсэн үгийг дохионы хэлээр илэрхийлэхэд бүгд өмнөх үгийн утгаас хамаарч өөрөөр дохигддог. Иймээс нэг үгийн дохиог батлан гаргахад цаашид өөрчлөгдөхгүй гэсэн баталгаа байдаггүй. Цаашид энэ талын судалгааг дохионы хэл судлаач нар хийх шаардлагатай.

Цаг үеэ дагаад зарим үгс устаж алга болно, эсвэл шинээр үг үүсэж хөгжинө зээлдмэл дохиотой ч болно. Зээлдмэл дохио нь дэлхий нийтийн нэршил, аль нэг улсын соёл, уламжлалт үйл нь монгол дохионы хэлний үгсийн санд байхгүй байгаа тохиолдолд гадны дохиог монголдоо хэрэглэхийг хэлдэг. Жишээлбэл: Коронавирус. Техник технологи хөгжсөн энэ үед цахимаар өдөр тутамдаа гадны мэдээ мэдээлэл, дохиог харсаар монгол дохиогоо ашиглахын оронд гадаад дохио ашиглаж байгаа нь хэл болоод соёл аажмаар устаж үгүй болох аюулыг авч ирдэг учраас хойч үедээ өөрийн төрөлх хэлээрээ бахархах, зөв зохистой ашиглах мэдлэг, хандлагыг өвлүүлэх үе ирээд байна. Монгол улсын сонсголгүй иргэн бүр эх хэл болох монгол дохионы хэлийг сурах, монгол дохионы хэлээр мэдээлэл авах, нийгмийн харилцаанд оролцох бүрэн эрхтэй.

Монгол дохионы хэлийг хэл шинжлэлийн талаас тодорхойлох нь

Авиа авиалбар талаас

Дохионы хэлэнд авиа авиалбартай адилтгах нэгэн ухагдахуун бий. Хэлэнд аливаа үгийн авиа авиалбаруудыг нийлэмж, хувирлаар аливаа үгийг дуудан хэлдэг бол дохионы хэлэнд нэг үг буюу нэг дохиог бүтээн илэрхийлэхэд гарын таван бүрдүүлбэрийн нийлэмжээр бүтдэг. Гарын таван бүрдүүлбэр нь гарын хэлбэр, гарын байрлал, алганы чиглэл, гарын хөдөлгөөн, үгэн бус илэрхийлэл гэх үндсэн таван бүрдүүлбэрүүд бөгөөд нэг үгийг дуудахад сонсогдох авиалбартай ижил үүргийг гүйцэтгэх нь бий. Аль нэг бүрдүүлбэр дутуу илэрхийлэгдвэл тухайн үг буюу дохио утгын хувьд буруу эсвэл өөр утгатай үгээр илэрхийлэгддэг.

ГАРЫН ХЭЛБЭР (Handshapes)

Эхний бүрдүүлбэр нь гарын хэлбэр байна. Гар атгасан, хоёр хуруу гозойсон, гарын хуруунууд салангид эсвэл нийлсэн зэрэг нэг дохио буюу нэг үгийг дохиод гар ямар хэлбэртэй байх ёстойг заана. Дохио бүр янз бүрийн гарын хэлбэрээр илэрхийлэгдэнэ. Жишээ нь: “ажил” дохионы гарын хэлбэр нь гараа атгасан хэлбэртэй бол “хайр” дохио нь гараа дэлгэж хуруунуудаа нийлүүлсэн байдалтай гарын хэлбэрээр илэрхийлэгдэнэ.

ГАРЫН БАЙРЛАЛ (Location)

Биеийн нүүрэн талд, цээжний урд, чамархайн дээр гэх мэтчилэн аль хэсэгт хэрхэн байрлуулахыг заана. Дохионы хэлээр харилцахад биеийн байрлал нэн чухал байдаг. Гарын хэлбэр, хөдөлгөөн адил дохио байрлалаар ялгана. Жишээ нь: аав ээж, эмээ өвөө

АЛГАНЫ ЧИГЛЭЛ (Palm Orientation)

Хоёр гарын алганы чиглэл атгасан ч, дэлгэсэн ч аль чигт харуулсан байх ёстойг илэрхийлнэ. Дохионы хэлний утга хөдөлгөөнөөр илэрхийлэгдэх нь элбэг бөгөөд зарим дохиог хөдөлгөөний ялгаагаар танина. Гарын хэлбэр, байрлал ижил ч хөдөлгөөн өөр дохио байдаг. Жишээ нь: хайр, итгэх, тайвшрах


ХӨДӨЛГӨӨН (Movement)

Гарын хөдөлгөөн дээшээ, доошоо, баруун, зүүн, чичирхийлж, мурилзуулж гэх мэт хэрхэн зөв дүрмийн дагуу хөдөлгөхийг хэлнэ. Алга дээшээ, доошоо харсан байрлалтай эсвэл баруун, зүүн тийш харсан байрлалаар уг дохионы утга тодорхойлогддог. Жишээ нь: баримт, байна, гуйх дохиог алганы байрлалаар нь ялгаж танина.

ҮГЭН БУС ИЛЭРХИЙЛЭЛ (Non Manual Markers)

Нүүр царайн хувирал, уруулын хайрцаг, хацар, хөмсөг, толгойн хөдөлгөөн хэрхэн илэрхийлэгдэхийг хэлнэ. Үгэн бус илэрхийлэл нь тухайн дохионы утгыг нэн тодорхой илэрхийлдэг. Үгэн бус илэрхийллүүд болох нүүр хувирал, биеийн хэлэмж нь дохиотой хамт хэрэглэгдэж уг дохионыхоо утгыг маш тодорхойгоор илэрхийлдэг.

БАЯРЛАЛАА гэх дохиог бүрдүүлбэрээр задалж харвал



“Баярлалаа” гэх дохионы гарын хөдөлгөөнийг дахин дахин хийж, үгэн бус илэрхийлэл- бөхөлзөж, цөхөрсөн царай гаргавал энэ үг машид их талархсанаа хүндэтгэлтэйгээр илэрхийлж байгааг илтгэнэ. Харин хөдөлгөөнийг хурдан 1 удаа хийж, цээжээ өргөчихөөд, харцаа өөр тийш нь чиглүүлчихээд царайгаа огт хувиргалгүй хэлбэл худал үнэн хүчилж баярлалаа гэж хэлж байгаа болно. Энэ мэтээр зарим өгүүлбэр болон холбоо үгийг илэрхийлэхдээ 1 үгийн бүрдүүлбэрийг хувилгах тохиолдол бий.

Дэлхий дахины дохионы хэлний хууль

Дэлхийн олон орон өөрийн сонсголгүй иргэдэд зориулсан дохионы хэлийг хүлээн зөвшөөрч албан ёсны хэл болгон хуульчилсан байдаг. Энэ нь сонсголгүй иргэдийн эрх тэгш байдал болон сурч боловсрох, танин мэдэх, аливаа үйлчилгээг саадгүй авах боломжийг нээж, нийгмийн харилцаанд эрх тэгш хамруулах бодлого хэрэгжиж, үр дүнгээ өгснээр өөрчлөгдөн шинэчлэгдэж, уламжлагдан хэрэглэгдэж байна. Дэлхийн улс орнууд дохионы хэлийг сонсголгүй хүмүүсийн албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрдөг. Манай дэлхий дээр 200 гаруй үндэстэн дохионы хэлээр хоорондоо харилцдаг бөгөөд тэрхүү үндэстэн бүрийн дохионы хэл нь тухайн үндэстний соёл, онцлогийг өөртөө шингээсэн байдаг. Тэр дундаа үндэсний дохионы хэл нь нийгэмдээ тэгш хамрагдан оролцох боломжийг сонсголгүй хүмүүст олгодог.

1995 онд Дэлхийн түүхэнд анх Африк тивийн Уганда улсад үндэсний дохионы хэлний тухай хууль санаачлан баталсан байдаг билээ. Тэр үеэс хойш дохионы хэлийг үндсэн хуулиараа 51 улс баталсан байна. Сонсголгүй хүний дохионы хэлийг үндэсний албан ёсны хэлний хамт эрх тэгш байдлаар хуульчилсан байдаг. Энэ нь дохионы хэлийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын 193 орны 25 хувийг эзэлж байна. Сонсголгүй Иргэдийн Дэлхийн Холбоог анх 1951 онд Итали улсын Ром хотод үүсгэн байгуулж энэхүү хурлаар тус Холбооноос дохионы хэлийг сонсголгүй иргэдийн нэгдүгээр хэл хэмээн тунхагласнаар улс орон бүр өөрсдийн дохионы хэлийг бий болгон хөгжүүлж иржээ. Сонсголгүй иргэдийн эх хэл бол дохионы хэл юм. 2017 онд хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейнаас 09 дүгээр сарын 23-ны өдрийг “Дохионы хэлний олон улсын өдөр” хэмээн дэлхий даяар, жил бүр уламжлал болгон тэмдэглэж байх тэмдэглэлт өдөр болгон албан ёсоор баталсан билээ.



1.4 СОНСГОЛГҮЙ ХҮНИЙ АХУЙ СОЁЛ

“Сонсголгүй хүний ахуй соёл” гэдэг үгийг илэрхийлэх англи хэллэг нь “Deaf culture” гэдэг үг байна. Ахуй соёл гэдэг нь соёл иргэншил бөгөөд урлаг, итгэл үнэмшил, зан үйл болон хүний бодол үйл ажиллагаа нь дараагийн үедээ өвлөгдөх нийгмийн загварыг хэлнэ. Эдгээр загвар, шинж чанар, бүтээгдэхүүн нь тухайн цаг үе, бүлэг эсвэл хүн амын илэрхийлэл хэмээн үздэг. 1980-аад оноос хойш сонсголгүй хүний ахуй соёл гэсэн ойлголтыг Америк Нэгдсэн улсын “Сонсголгүйчүүдийн бахархал” хөдөлгөөнийхөн олон нийтэд өргөнөөр танилцуулсан. Тэр үеэс хойш “Deaf culture” үгийн утгыг тодорхойлохын тулд эхний үсгийг томоор тэмдэглэх болжээ. “Deaf culture” үгийн эхний үсэг жижиг үсгээр эхэлбэл сонсголгүй хүний сонсголын байдлыг илэрхийлэх бол томоор эхэлсэн үг нь сонсголгүй хүний ахуй соёлыг илэрхийлдэг юм.

Сонсголгүй хүний ахуй соёл гэдэг ойлголтыг сонсголтой хүмүүс гайхаж, улмаар буруу ойлгон монгол хүн биш юмуу, монголын уламжлалт соёлоо хүндлэхгүй байна, гадаадын соёлд хэт автаж байна гэх мэт шүүмжлэл гарч байсан. Сонсголгүй хүний ахуй соёл гэдэг нь монголын уламжлалт соёл, ёс заншлаас ангид соёл бус тэдний хараан дээр суурилсан аливаа харилцааны хэрэгсэл, арга хэлбэрүүд юм. Дэлхийн улс бүрийн сонсголгүй хүмүүс хоёр соёлтой буюу хос соёлтой. Жишээлбэл, Орос улсын сонсголгүй хүмүүсийн нэгдүгээр соёл нь өөрийн улсын уламжлалт соёл, ёс заншил бол хоёрдугаар соёл нь хараан дээр суурилсан ахуй соёл юм. Манай улсын сонсголгүй хүмүүсийн нэгдүгээр соёл нь монголын уламжлалт соёл, зан заншил бол хоёр дахь соёл нь хараан дээр суурилсан ахуй соёл байна. Дэлхий даяар сонсголгүй иргэдийн дохионы хэл өөр хэдий ч ахуй соёл нь нийтлэг байдгаараа онцлогтой.

Сонсголгүй иргэд ихэнхдээ харааны мэдрэхүйгээр мэдээллээ хүлээн авч харилцдаг нь тэрхүү соёлыг өвөрмөц болгодог ба дараах хүснэгтээр сонсголтой ба сонсголгүй хүний ахуй соёлыг харьцуулан гаргасан болно. Сонсголгүй хүний ахуй соёл нь харааны хүртэхүй дээр суурилдаг ба техник технологийн хөгжил нь сонсголгүй хүний ахуй соёлд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгааг харж болно.

Хүснэгт 3. Сонсголтой ба сонсголгүй хүний ахуй соёлын харьцуулалт

Сонсголтой хүний ахуй соёл	Сонсголгүй хүний ахуй соёл	
Сонсголтой хүний өдөр тутмын амьдрал дуу чимээ, сонсгол дээр суурилсан байдаг. Жишээлбэл:	Сонсголгүй хүний өдөр тутмын амьдрал хараан дээр суурилсан байдаг. Жишээлбэл:	
Бие биенээ “хөөе” эсвэл нэрээр нь дуудах	Гараараа даллах болон гараараа мөрөнд нь зөөлөн хүрч дуудах	
Хол байгаа хүнийг чанга дуугаар “хөөе” эсвэл нэрээр нь дуудаж өөрлүүгээ анхаарал татах	Хол байгаа хүнийг шалан дээр хөлөөрөө дэвсэлж доргилт үүсгэж дууддаг. Ширээ цохиж чичиргээн үүсгэн дуудаж холбогдох	

<p>Баяр хүргэхдээ алгаа ташиж баяр хүргэх</p>	<p>Баяр хүргэхдээ хоёр гараа дээш өргөн гарын бугуйгаа хоёр тийш эргүүлэн сэгсэрч баяр хүргэх</p>	
<p>Ширээний зохион байгуулалт ямар ч хэлбэрээр байж болно. Учир нь ард, урд байгаа хүнийхээ яриаг сонсож байдаг учир заавал нүүрлүү нь харахгүй</p>	<p>Сонсголгүй хүмүүс нэгнийхээ яриаг харахын тулд бие биерүүгээ харж суух шаардлагатай учраас тойрог буюу П хэлбэрээр тойрч суух, мөн дугуй ширээг голчлон ашиглах</p>	
<p>Хоорондоо ярилцаж байхдаа заавал бие биерүүгээ харж ярихгүй, яриаг нь сонсоод өөр тийшээ хараад ярилцаж болох</p>	<p>Хоорондоо ярилцаж байхдаа харцаа салгалгүйгээр харж ярилцаг. Өөр тийш харвал яриаг харах боломжгүй учраас бие биерүүгээ хараад ярилцах</p>	
<p>Цагийн сэрүүлэг ашиглаж сэрэх</p>	<p>Чичирдэг бугуйн цаг болон утасны чичиргээт сэрүүлэг ашиглан сэрэх</p>	
<p>Хаалга тогшиж, хонх дуугарахад сонсох</p>	<p>Хаалганы товчлуур дарахад хонхны дуу бус гэрэл анивчих</p>	
<p>Утас нь дуугарахад дуу сонсогдох</p>	<p>Утас нь дуугарахад чичиргээт доргилт үүсгэх эсвэл гэрэл анивчин асах</p>	
<p>Харанхуй газар бие биенээ сайн харахгүй байсан ч ярилцах</p>	<p>Харанхуй газар бие биенээ харахгүй учир сайн харагдуулахаар газар очиж ярилцах</p>	
<p>Утсаар ярихдаа дуу дуугаа сонсон ярилцах</p>	<p>Утсаар ярихдаа бие биенийхээ дүрсийг харалцан ярилцах</p>	
<p>Хүмүүс бие биенээ нэрээр нь дуудах</p>	<p>Хүмүүс бие биенийхээ нэрийг “Дохиотой нэр буюу Х-О-Ч”-оор дуудах</p>	

Сонсголгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралдаа хийж хэвшсэн ахуй соёл нь сонсголтой хүмүүст этгээд санагдаж магадгүй. Хол байгаа нэгнээ дуудах гэж ширээ цохих, шал дэвслэхэд сонсголгүй хүмүүсийг уурлаж бүдүүлэг хандаж байна гэж буруугаар ойлгох тохиолдол байдаг.

Хоорондоо ярилцаж байхдаа харцаа салгалгүйгээр харж ярилцдаг. Өөр тийш харвал яриаг харах боломжгүй учраас бие биерүүгээ хараад ярилцдаг. Энэ нь хүн рүү цоо ширтэх, гөлрөхийг хэлэхгүй бөгөөд хэрэв харцаа буруулах, анхаарал сарниулах нь харилцааг тасалж, ярьж байгаа сонсголгүй хүний яриаг сонирхохгүй байгаа мэт эвгүй мэдрэмж төрүүлдэг.

Хүмүүсийн нийтлэг алдаа нь сонсголгүй хүнтэй харилцаж байхдаа өөр тийш харах, яриагаа шууд таслан бусад хүмүүстэй ярих явдал юм. Сонсголгүй хүнтэй ярьж буй тухайн ярианы сэдвээ ярьж дууссаны дараа эсвэл “Түр хүлээнэ үү” гэсэн дохиог илэрхийлсний дараа бусад хүний асуултад хариулаад, тэр даруй сонсголгүй хүнтэй яриагаа үргэлжлүүлж болно. Энэ нь зөвхөн сонсголгүй насанд хүрсэн хүмүүс бус сонсголгүй хүүхдэд ч хамаарна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 СОНСГОЛГҮЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Сонсголтой хүүхэд нь 7,8 сартайгаасаа эхлэн бусдын өөрт хандсан үг яриаг сонсож дуурайн шулганан аажмаар тухайн үгийг хэлж, ярьж эхэлдэг бол сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь сонсдоггүйн улмаас үгэн харилцаанд орох хэрэгцээ байдаггүй, өөрөөр хэлбэл тэдэнд шулганаа болон үг яриа үүсдэггүй.

Хүн хэл яриа эзэмшихэд сонсгол маш чухал үүрэгтэй. Огт сонсдоггүй буюу их хэмжээгээр сонсголоо алдсан хүүхэд өөрөө биеэ дааж болон бусдын нөлөөгүйгээр хэл яриа эзэмшиж чаддаггүй. Учир нь сонсголоо алдсан хүүхэд түүнийг хүрээлэн байгаа хүмүүсийн яриаг ойлгож тэдний яриаг дууриах боломжгүй юм. Түүнээс гадна өөрийнхөө авианы дуудлагыг сонсож, хянаж чаддаггүй.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн мэдээлэл дамжуулах гол арга болсон аман яриа, бусад хүмүүстэй харьцах боломж хязгаарлагдмал болдгоос бусадтай харьцах, бодол санаа, хүсэл эрмэлзлээ илэрхийлэхдээ дохионы хэлийг ашиглана. Сонсголгүй хүүхдийн хувьд дохионы хэл нь тэдний эх хэл юм. Дохионы хэл нь үггүй дүрслэл, хөдөлгөөнөөр илэрхийлэгддэг хэл юм.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэц, танин мэдэхүйн онцлог:

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэц, танин мэдэхүйн онцлог дараах байдлаар илэрдэг. Сэрэл хүртэхүй буюу мэдрэхүйн аль нэг эрхтэн гэмтсэн тохиолдолд нөгөө эрхтнүүд түүнийг орлох чадвартай байдаг.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн харааны сэрэл хүртэхүйн нь сонсох сэрэл хүртэхүйгээ орлож эд юмсыг гол чухал шинжээр нь бус бусад зүйлээс тод ялгарах шинжээр нь ялгадаг ба бие даан эд юмсыг задлан шинжилж чаддаггүй. Удаан хүртэхүйтэй бөгөөд сонсголын сэрэл муу хөгжсөний улмаас авиагаа ялган хүртэж чаддаггүй, харааны сэрэл хүртэхүйн тусламжтайгаар аливаа зүйлийг бүхэл бүтнээр ажиглаж хүртдэг.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хараа дүрслэлийн ой давамгай хөгжсөн байдаг. Эвч тэд шинэ зүйлийг удаан тогтоодог. Тогтоосноо удаан хадгалж чаддаггүй. Утгачлах тогтоох чадвар хөгжөөгүйн улмаас уялдаа холбоо, хамааралд нь үгийн утгыг ойлгохгүй байх хүндрэлтэй тулгардаг нь хэл ярианы хөгжилтэй салшгүй холбоотой.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн анхаарлын төвлөрөлт харьцангуй сарнимтгай, тогтворгүй байдаг. Анхаарлаа нэг үйлдлээс нөгөө үйлдэлд шилжүүлж чаддаггүй, анхаарлын багтаамж сул байна. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд харааны хүртэхүйгээр хүлээж авсан зүйлээ ямар ч нөхцөлд өөр үйлдэл гүйцэтгэх үед сэргээн санах талаар сайн хөгжсөн байна. Ялангуяа бусдын хурууны үсгээр, уруулын хөдөлгөөнөөр ярьж хэлж байгааг сайн ойлгож, хүлээж авахдаа хурдан байна. Энэ нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийн анхаарлын онцлог юм.

Хэл сэтгэхүй хоёр салшгүй холбоотойгоор хөгждөг тул сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэхүйн хөгжил өвөрмөц онцлогтой.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн бодит сэтгэхүй илүү хөгжсөн боловч тэр нь эмх замбараагүй байдаг. Аливаа зүйлд утга холбоос тогтоон хандах, зүйрлэн харьцуулах зэрэг сэтгэхүйн үйлдлүүд хангалтгүй хөгжсөн байна.

ЕБС-д элсэн орж байгаа сонсголын бэрхшээлтэй сурагчид үгийн нөөц багатай, ахуйн бага зэрэг дохиотой, амьсгалын хуваарилалт сул, өгүүлэх эрхтний хөдөлгөөн хөшингө, булчингийн үйл ажиллагааны холбоос чангарсан, хэт чангарсан эсвэл суларсан, аман яриагаар харилцаанд орох чадваргүй, сэтгэхүйн хөгжил хоцорсон байгаа нь бага насанд нь хөгжлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт болон СӨБ-д хамрагдалт хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд сургуульд орсон өдрөөс нь хурууны үсэг заах, шинэ

үг тогтоолгох, нүдлүүлэх, цээжлүүлэх, дохиогоор ойлгуулах, бичиж сургах зэрэг олон үйлдлийг зэрэг хийж монгол хэл бичигт сургах үйл ажиллагаа эхэлдэг.

Сонсголын бэрхшээлтэй харагдах дүрслэл дээр тулгуурлан шинээр үг эзэмшиж байдаг боловч бусдын хэлж яриаг сонсдоггүй, үг хэллэгээ байнга харилцаанд хэрэглэдэггүй тул амархан мартдаг. Өөрөөр хэлбэл хэл яриаг хэрэглээ болгож тогтмол аман яриагаар харилцдаггүйтай холбоотой. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь хэл яриа сурахын ач холбогдлыг төдийлөн сайн ойлгодоггүй, өөр хоорондоо дохионы хэлээр харилцах нь илүү амархан бөгөөд төвөггүй байдаг.

Хүүхэд бүрийн нас сэтгэхүйн онцлог, хөгжил нь харилцан адилгүй. Сонсголгүй хүүхэд ч нас насны сэтгэхүйн хөгжлөөрөө өөр өөр байдаг. Сонсголгүй хүүхэд нь бие бялдар, хөдөлгөөний чадвар нь харьцангуй сайн хөгжсөн ч оюун ухаан, хэл яриа, нийгэмшихүйн хөгжлийн хувьд харьцангуй сул байдаг. Ялгаатай байдал нь сонсголгүй хүүхэд өөрөөс нь шалтгаалахгүй ба хүрээлэн буй орчин, нийгмийн хандлага, хүмүүсийн харилцаа зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болох талтай байна.

Сонсголгүй хүүхэд оюун ухааны хөгжлийн хувьд эрүүл байх бөгөөд харин сонсож чадахгүй байгаагийн улмаас хэл яриа хөгжихгүйтэй холбоотой хөгжлийн хоцрогдол үүсэх магадлалтай байдаг. Иймээс сонсголгүй хүүхдэд дохионы хэлийг аль болох бага наснаас нь зааж, эзэмшүүлснээр хоцрогдлоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.

Сонсголгүй хүүхдүүд өөрсдийн эх хэл болох бүтэц дүрэм бүхий дохионы хэлээрээ, онцлогтоо тохирсон хос хэл, соёлын арга зүйгээр суралцсанаар хөгжлийн хоцрогдол үүсэхгүй байх боломжтойг багш нар анхаарч ажиллах хэрэгтэй байна.

1. Хэл ярианы хөгжил

Хэл ярианы хөгжил дутуу, үгийг буруу ойлгож, буруу сонсож, буруу хэлж ярьдаг

Сонсголгүй болон сул сонсголтой хүүхдийн онцлогийн нэг болох “Хэл ярианы хөгжил дутуу, үгийг буруу ойлгож, буруу сонсож, буруу хэлж ярьдаг” гэсэн энэхүү дүгнэлт харин зөв дүгнэлт байна. Сонсголгүй хүүхдийн хэл нь аман ярианы хэл биш бөгөөд яаж дуугардаг, хэрхэн сонсогддогийг ч мэдэхгүй байж аман хэлийг хүчээр сурснаар аман хэлний хөгжил хоцрогдож, улмаар амаар ярьж байгаа хүмүүсийн үгийг уруулаас уншин буруу ойлгож, сонсгол сул учир буруу сонсож, өөрийн ярьж байгаагаа сонсохгүй учир буруу ярьдаг.

Үгийн баялаг хомс

Сонсголтой хүүхэд төрсөн цагаасаа эхлэн сонсголоороо дамжуулан аливаа үг хэллэгүүдийг тогтоон авч, үгийн нөөц нэмэгдэн сурдаг ба сургуульд орсноор үгийн баялаг нэмэгдэж, бичгийн хэлэнд суралцдаг. Сонсголгүй хүүхдийг төрсөн мөчөөс нь эхлэн эх хэл дохионы хэлээр харилцаж, дохионы хэлтэй орчин бүрдүүлж, сургуульд хос хэл, соёлын арга зүйгээр сургалтаа явуулахгүй байснаар тухайн хүүхэд үгийн нөөц багатай болдог.

Сонсголгүй хүүхэд сонсохгүй учраас өөрөө үг болон утгатай танилцаж, үгийн баялагаа нэмэгдүүлэх боломжгүй заавал дохионы хэлний чадвартай багш, эцэг эх, асран хамгаалагчдын тусламжтайгаар үгийн нөөц баялагаа нэмэгдүүлдэг. Сонсголгүй сурагчдад үгийн нөөцийг нэмэгдүүлэх тохиромжтой арга зүй ашиглан сургалтаа явуулаагүй байж, сонсголгүй сурагчдын онцлог нь “Үгийн баялаг хомс” гэж дүгнэх нь тохиромжгүй.

2. Нийгэмшихүйн хөгжил

Идэвх санаачилга сул, өөртөө итгэх итгэл муутай

Сонсголгүй хүүхэд хүний ярьж, хэлж байгааг сайн ойлгохгүй учраас буруу хариу үйлдэл үзүүлэх, бодол санаагаа илэрхийлж чадахгүй байдаг. Ийм үйлдэл гаргасанд ярьж байгаа хүн нь тухайн сонсголгүй хүүхдийн хариу үйлдэлд дургүйцэн, аман хэлээр мэдэгдэхгүй юм ярьж, биеийн хэлэмжээр бүдүүлэг хандаж, “чи чадахгүй” гэж хэлэх нь сонсголгүй хүүхдийг өөртөө итгэх итгэлгүй идэвх санаачилгагүй болгоход хүргэдэг. Сонсголгүй хүүхдэд ярьж, зааж байгаа хүн нь дохионы хэлээр маш тодорхой ярьж, чадна гэж урам зориг өгч байх нь тухайн хүүхэд маш сайн ойлгож, хариу үйлдлээ зөв илэрхийлж, идэвх санаачилгатай болох бүрэн боломжгүй. Өөрийгөө илэрхийлж, хүмүүс хүүхдийг ойлгож дэмжиж байхад сонсголгүй хүүхдүүд өөртөө итгэх итгэлтэй болж, цаашлаад сурах, олон нийтийн ажилд оролцох, бусдыгаа уриалах идэвхтэй болдог.

Сонсголгүй хүүхдийн ихэнх нь сонсголтой гэр бүлд төрж өсдөг бөгөөд гэр бүлийнхэн нь ойр зуурын ахуйн дохио хэрэглэхээс өөр дохионы хэл мэдэхгүй учир хүүхэд ганцаардаж, гэр бүлтэйгээ сэтгэлээ нээж, чөлөөтэй харилцаж чадахгүй байдаг нь өөртөө итгэх итгэл муутай, санаачилгагүй болгоход хүргэдэг.

Сонсголгүй сурагчид дохионы хэлтэй орчинд өөр хоорондоо болон бусад сонсголгүй хүмүүстэй харилцах, уралдаан тэмцээн, үйл ажиллагаанд хамтран оролцохдоо өөртөө итгэлтэй байж, ямар ч асуудалгүй чөлөөтэй харилцаж байдаг ч дохионы хэлний бус

орчинд оролцоо бага, идэвх муутай байдаг. Үүний учрыг сайн мэдэхгүй хүмүүс нь сонсголгүй хүүхдийг өөртөө итгэх итгэл муутай гэж дүгнэж үздэг.

Хүснэгт 4. Сонсголгүй хүүхэд аман хэл ба хос хэл соёлын орчинд суралцснаар гарах үр дагаварын харьцуулалт

Сонсголгүй хүүхэд хос хэл, соёлын бус орчинд, аман хэлний арга зүйгээр суралцсанаар	Сонсголгүй сурагчид хос хэл, соёлын орчинд тухайн арга зүйгээр суралцсанаар
Оюун ухааны хөгжил хоцрогдсон байх	Оюун ухааны хөгжил сонсголтой хүүхдийнх шиг хэвийн явагдах
Сэтгэн бодох үйл ажиллагаа сул байх	Хараанд суурилсан дүрслэлээр сэтгэн бодох чадвартай болох
Хэл ярианы хөгжил дутуу болох	Аман хэлний хөгжил дутуу ч дохионы хэлний чадвар сайтай, өөрийгөө илэрхийлэх чадвартай болох
Үгийг буруу ойлгож, буруу сонсож, буруу хэлж ярьдаг байх	Аман хэлийг буруу ойлгож, сонсож, буруу ярьдаг ч дохионы хэлээр бодол санаагаа илэрхийлэх чадвартай болох
Үгийн баялаг хомс байх	Үгийн утгыг хос хэл, соёлын арга зүйгээр сайн тайлбарлаж ойлгосноор мартаж нь багасаж, үгийн нөөц нэмэгдэх
Идэвх санаачлага сул байх	Суралцах орчин нь хос хэл, соёлын орчин байхад идэвх санаачлага нэмэгдэх
Өөртөө итгэх итгэл муутай байх	Дохионы хэлээрээ чөлөөтэй харилцаж, өөрийгөө илэрхийлж суралцсанаар өөртөө итгэх итгэлтэй болох

Сонсголгүй хүүхдийг “Сонсголын бэрхшээл”-ээс болж янз бүрийн онцлогтой гэж үзэх нь ерөөсгөл ойлголт юм. Хөгжлийн бэрхшээл нь өөрөө хөгжихөд саад болж байгаа бэрхшээл биш, харин хүртээмжгүй орчин, нийгэм, хүмүүсийн хандлага зэргийн нөлөөгөөр хөгжихөд бэрхшээл учруулдаг. Сонсголгүй хүүхдэд тулгарч буй аливаа асуудлаас үүдэн гарсан үр нөлөөг сонсголгүй хүүхдийн онцлог хэмээн дүгнэсэн байна. Хүртээмжтэй орчин бүрдүүлж, нийгмийн зүгээс хандах хандлагыг өөрчилснөөр сонсголгүй хүхэд ямар нэг асуудалгүй бусдын адил өсөж хөгжин, сурч боловсрох, амьдрах хүрэн боломжтой.

Сонсголгүй хүүхдийн онцлог гэж авч үзэхээс илүү хүүхдийн хөгжлийн онцлогийг авч үзэн, тухайн хөгжлийн онцлогт тохируулан хичээл сургалтаа явуулах, хүүхэдтэй ажиллах нь зүйтэй. Сонсголгүй хүүхдийг төрсөн цагаасаа эх хэлээ сурч, эрт оролцооны хөтөлбөр болон сургуулийн өмнөх боловсролд хамруулагүйгээс үүдэн хэл яриа, нийгэмшихүй, оюун ухаан, сэтгэхүйн хөгжлөөрөө хоцрогдож байдаг. Жишээлбэл: 6 настай хүүхдийн хэл ярианы хөгжилд “Зүйр цэцэн үгийн утгыг ойлгоно” гэж үздэг. Сонсголгүй 6 настай хүүхэд нь сургуульд орж эх хэлээ сурч эхэлж байдаг учир зүйр үгийн утгыг ойлгохгүй байдаг. Үүнийг “оюун ухааны хөгжил хоцрогдсон” гэж үзэн дүгнэх нь буруу юм. Сонсголгүй хүүхэд нь эх хэлээ сурснаар 6 настайдаа биш ч 7,8 наснаасаа зүйр үгийн утгыг ойлгох боломжтой. Мөн сонсголгүй хүүхэд бүрийн онцлог гэж нийтэд нь авч үзэж болохгүй ба сонсголтой хүүхэд бүр хөгжлийн өөр өөр онцлогтой байдгийн адил сонсголгүй хүүхэд бүр ч ялгаатай онцлогтой байдаг. Сонсголгүй хүүхдийн хөгжлийн онцлог гэж үзэх бус эх хэлээ хожуу сурах, дохионы хэлтэй орчинд хөгжөөгүй зэргээс үүдэн гарсан хөгжлийн хоцрогдол гэж авч үзэх хэрэгтэй.

2.2 СОНСГОЛГҮЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ БАГШИЙН ЧАДВАР

Манай ард түмний өв уламжлалд эрдэм мэдлэгтэй хүнийг багш хэмээн нэрлэж ирсэн. Өнөө үед багшийг хүүхэд, өсвөр залуу үеийнхэнд амьдралд нь хэрэгтэй мэдлэг, чадвар олгох тэднийг бие хүн болгон хүмүүжүүлэх арга ухаан эзэмшүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэн байхыг чухалчилж байна.

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багшийн ур чадвар нь сонсголгүй хүүхдийн хөгжлийн онцлогийг судалж мэдсэн, дохионы хэлний өндөр ур чадвартай байх нэмэлт мэдлэг, чадварыг багшаас шаардаж байна.

Монгол дохионы хэлний өндөр түвшний чадвартай байх

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг бага, дунд, ахлах ангийн бүх багш нарын дохионы хэлний чадвар өндөр түвшний байхаас гадна тухайн судлагдахууны онол, арга зүйн мэдлэг чадвар өндөртэй байх нь зүйн хэрэг юм. Дохионы хэл нь байнга хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэж байдаг хэл учир багш нар дохионы хэлний чадвараа хөгжүүлж байх хэрэгтэй.

Манай улсад сонсголгүй хүүхдэд боловсрол олгодог сургуулийн багш нарт ямар хэмжээний дохионы хэлний мэдлэгтэй байх шалгуур, шаардлага байдаггүй. Ямар ч дохионы хэлний мэдлэггүй хүн багшаар ажилд орж, ажиллах хугацаандаа сонсголгүй хүүхэд болон бусад багш нар, богино хугацааны сургалтаас анхан шатны дохионы хэлний мэдлэг, чадвар олж авч, ажиллаж байгаа нь нууц биш юм. Сонсголгүй хүүхдийн боловсрол хангалттай эзэмшиж чадахгүй байгаагийн хамгийн том шалтгаан үүнд байна. Монгол улс бодлогоор сонсголгүйн боловсролын дохионы хэлний өндөр чадвартай багш, боловсон хүчин бэлдэх тогтолцоо бий болгох шаардлага үүсч байна. Дохионы хэлний өндөр чадвартай багш гэдэгт ерөнхийд нь дараах шалгуурыг хангасан багшийг хэлж болно. Үүнд:

- Монгол дохионы хэлний түүх, дүрэм бүтцийн талаар ойлголт, мэдлэг эзэмшсэн байх
- Монгол дохионы хэлний бүтэц, дүрмийн дагуу үгэн бус илэрхийллийг маш сайн ашиглан ярьдаг байх
- Сонсголгүй хүний хараан дээр суурилсан ахуй соёлыг мэддэг байх
- Дохионы хэлнээс унших, бичих чадвартай байх
- Дохионы хэлний чадвараа тасралтгүй хөгжүүлдэг байх

Багшийн дохионы хэлний чадварын түвшинг сургууль, боловсролын мэргэжлийн байгууллагаас тасралтгүй хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, хяналт үнэлгээ хийдэг байх хэрэгцээ үүсч байна. Дохионы хэлний өндөр чадваргүй багш сонсголгүй хүүхдэд хичээл сургалтаа явуулж, чанартай боловсрол эзэмшүүлэхэд хүндрэлийг үүсгэж байна.

Монгол дохионы хэлний түүх, хөгжил, дүрэм, бүтцийн талаар мэдлэгтэй байх

Сонсголгүй хүүхдийн багш сонсголгүйн түүх, монгол дохионы хэлний түүхэн хөгжил, бүтэц дүрмийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байх хэрэгтэй. Сонсголгүй сурагчдад энэ талын мэдээлэл өгч, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн, сонсголгүй сурагчдаар өөрсдийн түүхээр бахархах сэтгэл төрүүлж, түүхээ үргэлжлүүлэх хэрэгтэй талаар ойлголт, мэдлэгийг эзэмшүүлнэ.

Монгол дохионы хэлний бүтэц, дүрмийн дагуу дохиж чаддаг байх

Дохионы хэл нь өөрийн гэсэн бүтэц, дүрэмтэй бие даасан хэл. Сонсголгүй хүүхэд, хүмүүс өөрсдийн төрөлх хэлээ дүрэм, бүтцийнх нь дагуу хэрэглэдэг. Энэ нь сонсголгүй хүүхдэд өөр шигээ сонсголгүй хүүхэд, хүмүүстэй харилцаж эхэлснээс хойш байгалийн жамаар бий болдог. Дохионы хэлийг бүтэц, дүрмийнх нь дагуу хэрэглэж чадахгүй, монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн дагуу дохиж ярьж, хичээлээ заагаад байвал сонсголгүй хүүхдүүд сайн ойлгож, бичиж сурч чадахгүй. Тэдний эх хэлээр ярьж, хичээлээ заавал илүү үр дүнтэй.

Сонсголгүй хүний хэл соёл буюу хараа болон сонор дээр суурилсан соёлын ялгаатай байдлын талаар мэдлэг, ойлголттой байх

Сонсголгүй хүний хараан дээр суурилсан ахуй соёлын талаар мэдлэгтэй байж, соёлыг нь хүндэтгэж, дагаж мөрдөж байх нь сонсголгүй сурагчдад хүндлэгдэж, улмаар сурагчид хичээлдээ идэвхтэй суралцах үндэс болно. Дохионы хэлийг сайн эзэмшсэн ч хараан дээр суурилсан соёлыг хүндэтгэж, харьцахгүй байх нь сонсголгүй хүмүүст хүндэтгэлгүй хандаж байгаа хэрэг болно. Дохионы хэл, сонсголгүй хүний ахуй соёл салшгүй холбоотой юм. /Сонсголгүй хүний хэл соёл буюу хараа болон сонор дээр суурилсан соёлын талаар 22 дахь хуудаснаас үзнэ үү./

Дохионы хэлээр унших чадвартай байх

Сонсголтой хүүхэд хоорондоо юу ярьдаг яг түүн шиг сонсголгүй сурагчид дохионы хэлээрээ хоорондоо чөлөөтэй харилцдаг. Сонсголгүй сурагчид дохионы хэлээрээ хурдан ярьж байдаг учир багш нар тэдний ярьж байгаа зүйлийг 100 хувьд ойлгох хэрэгцээ үүсдэг. Багштайгаа харилцахдаа дохиогоо удаашруулан, багшдаа зориулж дохиж ярьдаг. Эсвэл ангийнхаа сул сонсголтой сурагчаар дамжуулан багшдаа хэлж, ярилцдаг. Багш нь юм асуухаар сурагчид “чи ярь, хэл” гэж бие бие рүүгээ зааж, өөрөө ярихаас зайлсхийдэг. Багш нь сайн ханддаг сурагчаар дамжуулан ярилцах ч тохиолдол байдаг. Сайн харилцан ойлголцож чадахгүй байснаар сонсголгүй сурагчид багштайгаа илэн далангүй чөлөөтэй харилцах боломжгүй байдал үүсдэгийг анхаарах хэрэгтэй.

Сурагчдынхаа санаа бодлыг сонсдог байх

Багш нь сонсголгүй сурагчтай холбоотой аливаа асуудалд өмнөөс нь шийдвэр гаргахгүй заавал сурагчдын санаа бодлыг сонсож, шийдвэр гаргахад зөвлөн, дэмждэг байх хэрэгтэй. Сонсголгүй сурагчдаа шийдвэр гаргаж мэдэхгүй, чадахгүй гэсэн хандлагаар харилцаж болохгүй. Ямар нэг үйл ажиллагаа зохиогдоход сурагчдаасаа асуухгүй өмнөөс нь шийдэж, сурагчдыгаа оролцуулах тохиолдол гаргах нь сонсголгүй сурагч юу болоод байгааг ойлгож, мэдэхгүй байхад хүргэж болзошгүй.

Дохионы хэлээр ярихдаа үгэн бус илэрхийллийг сайн ашиглаж ярьдаг байх

Үгэн бус илэрхийлэл гэдэг нь дохионы хэлээр ярьж буй тухайн хүнээс гарах нүүр царайны хувирал, амны хөдөлгөөн, нүдний харцны чиглэл, биеийн хэлэмж, дохио зангаа зэрэг юм. Дохионы хэл сайн мэддэг ч үгэн бус илэрхийллийг хослуулж ярьж чадахгүй бол тухайн хүний ярьж буй зүйл утгагүй болно.

Багш “Та нарыг даалгавраа хийсэнд баяртай байна” гэсэн өгүүлбэрийг хэлэхдээ үгэн бус илэрхийлэл ашиглахгүй дохиж яривал сурагчид “та нар, даалгавар, хийх, баярлах, байна” гэж ойлгоно. “Та нар” үгийг дохихдоо хүүхэд бүр лүү харцаа салгахгүй харж, “хийх” үгийг дохихдоо зэрэг амны хөдөлгөөнөөр “УА” гэж дохино. Харин “баяртай байна” гэдгийг дохихдоо нүүрэндээ баяр баясал тодруулж, толгойгоо дохиж ярина. Ингэж үгэн бус илэрхийлэл гаргаснаар сурагчид утга агуулгыг сайн ойлгож чадна.

Амны хөдөлгөөнийг дуу гаргахгүй хийх ба амаараа ярьж байгаа нь амны хөдөлгөөн хийж байгаа гэсэн үг биш. Амаар ярих, дохионы хэлээр ярих хоёрыг зэрэг хийх ямар ч боломжгүй. Ярьж байгаа хүн нь өөрийнхөө яриаг сонсоод ойлгож байгаа учир дохиогоор ярьсныг сурагчид ойлгосон байгаа гэж бодож болохгүй юм. Амаар ярьж байгаа зүйлдээ илүү анхаараад, дохионы хэлний бүрэм, бүтцийн дагуу ярих боломжгүй болно. Амны ямар ч хөдөлгөөн гаргахгүй ярих нь дохионы хэлээр ярьж байгаа хүний агуулгыг ойлгож чадахгүйд хүргэдэг. Аль алиныг нь анхаарч дохионы хэлний бүтцийн нэг хэсэг болох үгэн бус илэрхийллийн амны хөдөлгөөнийг зайлшгүй хийх хэрэгтэй.

2.3 СОНСГОЛГҮЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Сургуулийн орчинд - сонсголгүй хүүхэдтэй харилцах харилцаа

- Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг, хичээл сургалт явуулдаг бүх багш нар дохионы хэлний өндөр ур чадвартай, сонсголгүй хүний ахуй соёлын талаар мэдлэгтэй байх.
- Сургуулийн ажилтан, албан хаагчид ахисан түвшний дохионы хэлний чадвар эзэмшсэн, сонсголгүй хүний ахуй соёлын талаар ойлголттой байх.
- Хичээл заадаг багш нар хос хэл, соёлын арга зүйг эзэмшсэн, тухайн арга зүйгээр сургалтаа явуулдаг байх.
- Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар дохионы хэлний өндөр чадвартай байж, багш нартай ажиллахаас илүү сонсголгүй сурагчтай ажиллаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эрх нь зөрчигдөхөөс хамгаалж ажилладаг байх.
- Сурагчдаа нэрээр нь үсэглэж хэлэх болон аман хэлээр дуудах бус тэдний дохиотой нэрээр дууддаг байх.
- Хичээл сургалт явуулж байх үедээ сайн сурагч руу бус бүх сурагч руу ээлжлэн харж хичээлээ заадаг байх.
- Сонсголгүй хүүхдийн багш нар тухайн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдыг дохионы хэлний чадвар эзэмшихэд анхаарч, дохионы хэлний сургалтад хамруулж байх.
- Аливаа үйл ажиллагаа, тэмцээн уралдаан дээр сонсголгүй сурагчдынхаа өмнөөс шийдвэр гаргах бус тэдний санал бодол, хүсэл сонирхлыг асууж, ярилцан дэмждэг, хүлээн авч тусгадаг байх.
- Сонсголгүй сурагчид багштайгаа ярилцахаас ихэвчлэн дөлж, асуусан асуултад нь хариулж байдаг. Багшийнхаа ярьж буй дохиог сайн ойлгодоггүй учраас чөлөөтэй ярилцаж чадахгүй байдаг. Багш дохионы хэлээ сайжруулан хичээлийн бус цагаар сурагчидтайгаа чөлөөт ярилцлага өрнүүлдэг байх.
- Дохионы хэлээр ярихдаа амаараа ярихгүй ба дуу гаргахгүй амны хайрцгаар, үгэн бус илэрхийллээр ярих.

Сургалт явуулах орчин

- Сонсголгүй сурагчдын хараан дээр суурилсан сургалтын орчин бүрдүүлэх
- Сургуулийн орчин дахь мэдээлэл, зарлалыг байнга бичвэр хэлбэрээр бус дүрст бичлэг, зураг хэлбэрээр боловсруулж танилцуулж байх
- Сургалтын материалаа зураг дүрс, товч бичвэр бүхий өнгө дүрс сайтай үзүүлэн, тараах материал боловсруулсан байх
- Завсарлагааны мэдээллийг дуут дохиогоор бус гэрлэн дохиогоор хүргэдэг байх
- Эрдмийн баяр, Шинэ жилийн баяр, Төгсөлтийн баяр аливаа үйл ажиллагааг дохионы хэлтэй хөтлөгч удирдаж, сургуулийн удирдлага, багш нар дохионы хэлээр ярьдаг байх хэрэгтэй. Харин тухайн үйл ажиллагааг гадны зочид, сул сонсголтой сурагч, багш нарт зориулан дохионы хэлнээс ярианы хэл рүү хэлмэрчлэн хүргэдэг байх. Мөн баярын үйл ажиллагааны үзүүлбэр нь морин хуур, хөгжим дарах, аман хэлээр дуулах бус бүжиг, дохионы хэлтэй болон үггүй жүжиг зэрэг байх.
- Анги танхимын ширээний зохион байгуулалт нь хагас дугуй болон, “П” хэлбэртэй байж сургалтын үйл ажиллагаа явуулах
- Сургуулийн орчин, анги танхим харанхуй бүдэг бус гэрэл гэгээтэй орчинтой байх

Сонсголгүй хүүхдийн ангийн зохион байгуулалт

Хичээллэх үеийн харилцааны орчин буюу анги танхим нь сонсголтой хүүхдийн ч сонсголгүй хүүхдийн ч суралцахуйн үйлд маш чухал. Хараан дээр суурилсан соёлд нийцэх орчин, зохион байгуулалтаар хичээлийг явуулбал тохирно.

Ширээг сонсголтой хүүхдийн ангид засдагтай ижил 3 салаа болгон хуваавал хүүхэд багштай дохиогоор харьцахад тухайн хүүхдийн ард эсвэл урд сууж байгаа хүүхэд дохиог нь харж чадахгүй. Иймээс П эсвэл хагас дугуй хэлбэрээр буюу U хэлбэрээр байрлуулж тавибал хүүхдүүд бүгд бие биесээ, багшийг харж чадна.

Сандал хэт намхан эсвэл өндөр байх нь удаан хугацаагаар хичээл хийж байгаа хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс гадна ширээний араас дохиогоор ярьж байгаа хүүхдийн гар таллаж харагдана. Дэвтэр дээр бичихэд, дохиогоор ярихад саадгүй байх өндөрт сандлыг тааруулна.

Гэрэлтүүлэггүй, хэт хурц гэрэлтүүлэгтэй, анивчдаг гэрэлтэй орчинд хараагаар бүх мэдээллийг авдаг сонсголгүй хүүхдийн нүд хэт их ачааллаж хараа муудан, амархан ядарна. Цагаан эсвэл шар өнгийн гэрлийн аль нь туяа багатай, хүүхдийн хараанд нөлөөлөхгүйг судлах хэрэгтэй.

Хичээл орж буй багшийн хувцаслалт албан байх ёстойгоос гадна хувцасны өнгөн дээр чухал ач холбогдол өгөх шаардлагатай. Эрээн мяраан хээтэй, толботой хувцас, хэт өнгөлөг, гялгар хувцас өмссөн багш дохионы хэлээр ярихад сурагчид багш руу удаан харж, нүдэндээ хэт их ачаалал авах болно. Иймд гарын өнгө ялгарахуйц цулгай хувцаславал тохиромжтой.


Багш ширээний ард суунгаа дохиж байгаа тохиолдолд зөөврийн эсвэл суурин компьютероос холдож дохио саадгүй харагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Проектор эсвэл самбар, хэвлэмэл материал ашиглаж, үүнийгээ тайлбарлахдаа үг, зургийг хааж зогсохгүй, хэт хол эсвэл урд зогсохгүй яг хажууд нь зогсож хичээлээ орно.

2.4 СОНСГОЛГҮЙ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН БУЮУ ХАРААНД ТУЛГУУРЛАСАН ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Сонсголгүй хүүхдэд хос хэл, соёлын арга зүйгээр сургалтаа явуулахад тэдний хараан дээр суурилсан сургалтын хэрэглэгдэхүүний гүйцэтгэх үүрэг их байдаг. Хос хэл гэдэг нь дохионы хэл болон бичгийн хэлний нэгдмэл ойлголт бол хараан дээр суурилсан сургалтын хэрэглэгдэхүүн нь дохионы хэл, бичгийн хэл, зураг дүрс агуулсан байдаг учраас салшгүй холбоотой. Сонсголтой хүүхэд төрсөн цагаасаа сонсголоороо бүх мэдээллийг хүлээн авсан байдаг ба ямар нэг зүйл хэлэхэд тухайн үгийн зураг дүрслэл шууд бууж ирдэг бол сонсголгүй хүүхэд эсрэгээрээ байдаг. Дохионы хэлээ хожимдож сурсан хүүхдэд дохионы хэлээр аливаа зүйлийг хэлэхэд ямар зураг, дүрслэлтэй байдгийг мэдэхгүй байдаг. Тийм учраас сонсголгүй хүүхдэд хичээл заахдаа зураг дүрстэй үзүүлэн материал ашиглах нь чухал юм.

Сургалтын хэрэглэгдэхүүн нь бичвэр бүхий хэрчмэл үг байхаас илүү зураг дүрс, дохионы хэл, хурууны үсэг, бичвэртэй хэрэглэгдэхүүн байх нь илүү үр дүнтэй байдаг. Зөвхөн хэрчмэл үгийг сонсголгүй сурагчдад уншуулахад тухайн үг нь ямар утга илэрхийлж байгаа эсэхийг уншаад санахгүй, амархан мартчихдаг тохиолдол байдаг. Аль болох зурагтай хэрчмэл үзүүлэн байх хэрэгтэй. Жишээлбэл: доорх “хөхрөх” гэсэн зураггүй хэрчмэл үзүүлэн сонсголгүй хүүхдүүд уншууд ямар утга илэрхийлж байгааг санах гэж оролддог бол зурагтай хэрчмэл үгийг хараад шууд ойлгодог. Энэ нь үгийг цээжлэх, утгыг нь мэдэж авахад илүү үр дүнтэй байдаг.

Зураг 4. Зурагтай болон зураггүй хэрчмэл үг



Сонсголгүй хүүхдэд хичээлд ашиглахаас гадна хүүхэд өөрөө бие даан сурч болохуйц сургалтын хэрэглэгдэхүүн хэрэгтэй байдаг. Сонсголгүй хүүхдэд байнга зааж цээжлүүлэхээс илүү бие даан сурах боломжоор хангаж өгөх, бие даан сурах арга барил анхаарч, ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн байх хэрэгтэй байдаг.

Сонсголгүйн боловсрол төрийн бус байгууллага нь сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны сонсголгүй хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, дохионы хэлний чадварыг сайжруулах зорилгоор сонсголгүй хүүхдийн онцлогт тохирсон, бие даан ашиглахад хялбар дохионы хэлний зурагт толь бичиг, дохионы хэлний зурган карт, дохионы хэлний дүрст бичлэг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж гаргасан байдаг. Тус байгууллагаас гаргасан сургалтын хэрэглэгдэхүүн нь зураг, бичвэр, хурууны үсэг, дохионы хэлийг багтаасан сонсголгүй хүүхдэд хэрэглэхэд тохиромжтой байдгаараа онцлог юм.

Сонсголгүй хүүхдэд хичээл заахад ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн нь сонсгол дээр суурилсан аудио бичлэг, хөгжим, дуу чимээ бүхий хэрэглэгдэхүүн байх нь тохиромжгүй. Эдгээрийг сонсголын үлдэгдэлтэй сул сонсголтой хүүхдэд ганцаарчлан ажиллахдаа дуу чимээг таниулах, ялгаж сонсгох зэргээр ашиглаж болно.

Сонсголгүй хүүхдэд хараан дээр суурилсан зураг, дүрстэй, хөдөлгөөнтэй сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах хэрэгтэй. Ямар ч хамаагүй зураг дүрс ашиглах бус заах

хичээлийн агуулга, илэрхийлж буй үг, өгүүлбэрийн утгад тохирсон зураг, дүрстэй үзүүлэн байх хэрэгтэй. Сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн сонирхолыг татсан, өнгө загвартай, үзэж харахад ойлгомжтой төрөл бүрийн хэрэглэгдэхүүн байх хэрэгтэй. Зарим сургалтын хэрэглэгдэхүүнээс жишээ болгон харуулвал:

- Дохионы хэл, зураг, бичвэр бүхий үзүүлэн

Зураг 5. Дохионы хэл, зураг, бичвэр бүхий үзүүлэн




- Хөдөлгөөнт цахим хичээл

Зураг 6. Хөдөлгөөнт цахим хичээлийн зураг



- Хичээлийг дохиогоор илэрхийлсэн дүрст бичлэг

Зураг 7. Хичээлийг дохиогоор илэрхийлсэн дүрст бичлэг



- Бичвэр, зураг бүхий хэрчмэл үгтэй карт

Зураг 8. Бичвэр, зураг бүхий хэрчмэл үгтэй карт



ГУРАВДУГААР ХЭСЭГ

3.1.1 МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛНИЙ УНШИХ ЧАДВАР

Шинжлэх ухаан хөгжсөн 21 дүгээр зууны өнөө үед хүн бүр тэр тусмаа хүүхэд бүхнийг унших чадвар эзэмших хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд тавигдах болжээ. Унших чадвар эзэмшээгүй бол боловсрол эзэмших, мэргэжилтэй болох, цаашлаад нийгмийн амьдралд оролцох тухай ярих шаардлагагүй болно. Хүүхэд уншиж, бичиж сурч байж боловсрол мэргэжил эзэмшин, нийгэмтэйгээ хөл нийлүүлэн алхах, ажиллаж амьдрах боломж бүрддэг.

Сонсголтой хүүхэд харах мэдрэхүйн тусламжтайгаар тэмдэг, зураг дүрс, томъёо загвар, хүснэгт гэх мэт төрөл бүрийн бичгэн мэдээллийг уншдаг. Сонсголтой хүүхэд нь зөвхөн бичгэн хэлбэртэй мэдээллийг уншдаг бол сонсголгүй хүүхэд дараах хоёр аргаар уншдаг юм.

1. Бичгийн хэлээс унших
2. Дохионы хэлээс унших

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш нар тухайн хүүхдийн дохионы хэл болон бичгийн хэлээс унших чадварыг хөгжүүлж ажиллах хэрэгтэй.

НЭГ: Бичгийн хэлээс унших

Ямар чадвар эзэмших вэ?

Бичгийн хэлээс унших гэдэг нь ямар нэг бичвэрийг уншиж ойлгохыг хэлнэ. Сонсголгүй хүүхдэд бичгийн хэлээс уншуулах чадвар эзэмшүүлэхдээ хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог болон бичиг үсгийн мэдлэгийн түвшинг харгалзан тэдэнд тохирсон үг, өгүүлбэр, эх бичвэрийг сонгоно.

Сонсголтой хүүхдийн унших чадварыг сайжруулахын тулд хэрэглэдэг бүхий л арга зүйг сонсголгүй хүүхдийн суралцахуйд хэрэглэх шаардлагатай. Тухайн аргыг хэрэглэхдээ сонсголтой хүүхдэд аман хэлээр, сонсголгүй хүүхдэд дохионы хэлээр зааж тайлбарлана. Тэдэнд сонсголтой хүүхдэд заадаг агуулгыг сонсголгүй учир сурах, хөгжих боломжгүй гэж үзэн хялбаршуулан, дүйцүүлэн заах нь тухайн сонсголгүй хүүхдийн сурч, боловсрох эрхийг зөрчиж буй асуудал юм.

Сонсголгүй хүүхдийн оюун ухаан, сэтгэхүйн хөгжлийн онцлог харилцан адилгүй байдаг. Тиймээс тэдний хөгжлийн онцлогт тохируулан хичээлийн агуулгаа сурч чадахгүй гэж танаж, хялбаршуулан заах бус сурах ёстой агуулгаас хугацаагаар хоцрон зааж болно. Жишээлбэл: 7 дугаар ангийн сонсголгүй сурагчид тухайн ангид үзэх ёстой хичээлийг хүүхэд ойлгосон эсэхийг үл харгалзан хугацаанд нь заах гэж яарахгүй байх хэрэгтэй. Сонсголгүй хүүхэд хичээл ойлгож, сурч чадаж байгаа бол 5,6 дугаар ангийн хичээлийн агуулгаас суралцуулж болно.

Сонсголгүй сурагчдыг уншиж сурах чадварын хүрээнд дараах чадварыг эзэмшүүлэхэд анхаарч ажиллана.

- Үсэг, авиаг хурууны үсэг, амны хайрцагаар илэрхийлж сурах
- Битүү болон задгай үеийг зөв унших
- Хам үгийн хүрээнд үгийг уншиж утгыг зөв ойлгох
- Өгүүлбэрийн утгыг ойлгож, өгүүлбэрийг ялгаж сурах
- Эхийг уншиж, утга агуулгыг ойлгож сурах

Авиа, үсэг таниулах

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Авиа үсгийг таньж мэдэх нь аливаа үгийг хэлэхэд авиа үсгийг зөв дуудан унших, хэлэх, ялган сонсох зэрэг унших, бичих, ярих чадварын үндэс суурь нь болж өгдөг. Сонсголгүй болон сул сонсголтой хүүхэд бүрийн суралцахуйн хэрэгцээ, тохируулга нь өөр хоорондоо харилцан адилгүй байдаг. Энэ нь тухайн суралцагчийн сонсголын чадвар бүрэн алдагдсан эсвэл тодорхой хэмжээнд суларч алдагдсан зэргээс хамааралтай. Тиймээс багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс хүүхдийн онцлог, хэрэгцээг ялган танин мэдэж хичээлийг үр дүнтэй зохион байгуулах нь зүйтэй.

Сул сонсголтой хүүхдийн хувьд сонсголын чадвараас хамаарч ялгаатай түвшинд авиа үсгийн дуудлагыг сонсож, олон удаагийн давтамжтай сонссон авиа үсгээ өгүүлэхүйн эрхтний тусламжтайгаар дуудаж сурах боломжтой байдаг. Харин бүрэн сонсголгүй хүүхэд авиа үсгийн дуудлагыг нь сурахаас илүүтэй үгэн бус илэрхийлэл буюу тухайн авиа үсгийг дуудахад уруулын хайрцгийн зөв хэлбэрийг баримжаалан илэрхийлж сурах нь цаашдын сурах үйл явцад илүү үр дүнтэй байдаг. Учир нь авиа үсгүүдийн дуудлагуудыг урьд өмнө сонсож байсан удаа огт үгүй тул сонсож байгаагүй авиагаа өөрийн таамгаар хэлэх гэж оролдох нь маш их хүндрэлтэй, амнаас нь гарч байгаа авианы зөв, бурууг ялган таних боломжгүй.

Сонсголгүй хүүхдэд авиа үсгийн дуудлагыг голчлон таниулахаас илүүтэй аливаа үг, өгүүлбэрийг дохионы хэлээр илэрхийлэн дохиход гарын таван бүрдүүлбэрийн нэг болох үгэн бус илэрхийлэл буюу уруулын хайрцгийн хөдөлгөөнийг зөв баримжаалахыг таниулахад анхаарах нь илүү үр дүнтэй юм.

Жишээ нь: Хүүхдэд “А” үсэг таниулахдаа самбар дээр том, жижиг бичмэл болон дармал “А” үсэг бичсэнийхээ дараа “А” хурууны үсгийг гаргана. Ингэхдээ амнаас гарах авиан дээр огт анхаарал хандуулалгүй том үсэг болон жижиг үсгийн ялгааг илэрхийлэх арга, үсгийг хуруугаар илэрхийлэхэд амны хайрцаг ямар байх шаардлагатайг зааж, зөвлөж өгнө. Хүүхдүүд хурууны үсгийг зөв үсэглэсний дараа хэрхэн бичмэлээр бичихийг заана. Үсгээ бичүүлчихээд “Энэ ямар үсэг вэ?” гэж асуух, “А” үсгийг хурууны үсгээр илэрхийлээд “Энэ үсгийг бичмэлээр бичээрэй.”, дармал үсгийг харуулаад дэвтэрт нь бичмэлээр бичүүлэх гэх мэт аргуудыг ашиглан хуруу, гарын үеийг зүгшрүүлж бичих, хуруугаар үсэглэх дадалд суралцуулна. Зарим хүүхдийн хувьд сургуульд орохоосоо өмнө хурууны үсгээ аль хэдийн сурсан байдаг. Эдгээр хүүхдүүд хараахан сураагүй байгаа хүүхдийг бодоход хурууны үсгээр үсэглэх хурд сайтай байдаг. Иймд авиа, үсэг таниулах хичээл дээр хуруу нь зүгшрээгүй хүүхдүүдтэй түлхүү ажиллан анхнаас нь зөв үсэглэх дүрмийг баримтлан заах, үсэглээд сурчихсан ч алдаатай зүйл ажиглагдвал дор дор нь засаж сургах нь зүйтэй.

“А” үсгийг хурууны үсгээр илэрхийлэхийн тулд гарын 5 хурууг бүгдийг нь атгах ба эрхий хуруу бусад 4 хуруун дээр байрлахаар атгана. Тохойноос дээш хэсэг бүхэлдээ эгц дээшээ тэгш байх ёстой бөгөөд гарын бугуйг урагш нь унагавал гараа зангидсан мэтээр буруу ойлгогдоно.



Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Үсэг бүтээх үндсэн зурлагыг бичүүлж, цагаан толгойн үсгийг хурууны үсгээр нэрлүүлж сургахаас гадна бичмэл, дармал үсгийг ялган уншуулж сургах хэрэгтэй. Цагаан толгойн үсэгтэй танилцуулахын тулд "Г" гийгүүлэгчтэй танилцуулах, уншуулж сургах аргын талаар доор тайлбарлан бичлээ.

1. Дохионы хэлний гарын хэлбэр нь "Г" үсгээр эхэлсэн дохионы холбоотой зургийг нь сонсголгүй хүүхдэд үзүүлж, юу болохыг асууж ярилцана. Тухайн зургийг зааж "гутал, гомдох, гол" гэх мэтээр "Г" үсгэн гарын хэлбэртэй дохионуудыг илэрхийлж үзүүлнэ.

Зураг 10. "Г" үсгээр эхэлсэн дохионы зураг



2. Дармал "Г" үсэг харуулж, хурууны үсгээр "Г" гэж тайлбарлана. Хүүхдүүд гарын хэлбэр "Г" үсэгтэй дохионы хэл сурч, танилцсан учир үсэг заахад хурууны үсгээр төвөггүй илэрхийлж чадна. Тухайн үсгийн зурагт үзүүлэн ашиглана.
3. Бичмэл "Г" үсгийн зурлага үзүүлж, агаарт бичүүлэх дасгал хийлгэж болно. Сонсголгүй хүүхдээр тухайн үсгийн зурлагыг бичүүлнэ.
4. "Г" үсгийг сурч мэдсэн эсэхийг баталгаажуулахын тулд тус үсгийн дармал болон бичмэл үсгийг самбарт байрлуулт ямар үсэг болохыг асууж болно. Эсвэл үзсэн үсэгнүүдтэй хамт хольж байрлуулан "Г" үсгийг олуулж болно. Багш хурууны үсгээр үсгийг бичмэлээр бичээрэй гэж хэлээд, хүүхдийн үзсэн үсгүүдийг хурууны үсгээр илэрхийлж хэлнэ. Хүүхдүүд үсгээ таньж, бичмэлийн зурлагын дагуу бичихыг ородоно.

Зураг 11. "Г" үсэг таниулахад ашиглах үзүүлэн материал



Авиа таниулахад багш юуг анхаарах вэ?

Сонсголгүй хүүхдэд цагаан толгойн үсэг, авиаг зааж таниулахдаа дохионы хэлээр тайлбарлаж, үсгийг хурууны үсгээр уншуулж танилцуулна. Харин авиатай нь танилцуулах, үсгийн дуудлагыг зөв дуудаж, ялган дуудаж сургах ажлыг хэл заслын багш нар монгол хэлний хичээлийн бус цагаар заах нь оновчтой. Монгол хэл, хэл заслын хичээлийг тусад нь явуулж байж сонсголгүй хүүхэд монгол хэлний хичээлийн агуулгаа бүрэн сурах боломжтой. Монгол хэлний хичээлийн цаг дээр сонсголгүй хүүхдийг аман хэлээс уншуулж сургахыг оролдсоноор тухайн хичээлийн агуулгыг сурч чадахгүй хоцрогддог.

Багш сурагчдыг уншуулж сургахдаа үсэг дохиход гар нь зүгшрээгүй сурагчдын гарыг зүгшрүүлэн зөв үсэглүүлж сургах, ойролцоо дохих үсгийг андуурч байгаа, үгүйг хянаж зөв илэрхийлж сургах, тухайн үсгээ амны хайрцгаар зөв хөдөлгөөн гаргаж буйг анхаарна. Харин үсгийнхээ авиаг зөв ярьж, уншиж байгаа эсэхэд их анхаарах хэрэггүй. Авиа үсгийг зөв дуудаж сургахад хэл заслын багш анхаарч ажиллах хэрэгтэй.

Хэрхэн үнэлэх вэ?

Сонсголгүй хүүхэд авиаг зөв дуудаж, ярьж байгаа эсэхийг үнэлэхээс татгалзах хэрэгтэй. Хурууны үсгээр зөв илэрхийлж байгаа болон бичмэл, дармал үсгээ уншаад хурууны үсгээр илэрхийлж чадаж байгаа эсэхийг үнэлэх хэрэгтэй.

Үе уншуулах

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Үеийг уншуулахдаа хурууны үсгээр илэрхийлэн уншина. Задгай болон битүү үе бүтээлгэн уншуулна. Мөн үеийг сайн нүдлэн таниулснаар сонсголгүй хүүхэд үг бүтээн унших суурь болж өгнө. Хэрчмэл үсгээр үе бүтээлгэн уншуулах нь сонсголгүй хүүхдүүдэд их тохиромжтой байдаг.

Үеийг уншуулахдаа зөв дуудах талаас бус амны хайрцгаар зөв илэрхийлж байгаа талаас анхаарах ёстой. Жишээ нь: “ма, мэ, ми, мо, му, мө, мү” үеүдийг уншихдаа хурууны үсгээр “ма” гэж зөв үсэглэж байгаа хэдий ч амаараа “мо” гэж байгаа юм шиг амны хайрцгаар гаргаж байвал засан, амны хайрцгийг зөв болгоно. Амны хайрцгаар илэрхийлэхдээ дуутай уншиж болно. Дуудлага буруу байвал монгол хэлний хичээл дээр бус хэл заслын хичээл дээр зөв дуудаж сурахыг заана. Му, мү, мө гурван үеийг хэлэх үед амны хайрцаг адилхан харагддаг. Тиймээс сонсголгүй хүүхдүүд тухайн авиаг ялгаж уншихдаа хурууны үсгээ амны хайрцагтай хамт уншина.

Зураг 12. “М” үсгийн үе таниулахад ашиглах үзүүлэн



Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Хэрчмэл үсэгтэй карт – эгшиг болон гийгүүлэгч үсэг бүхий хэрчмэл үсгэн картуудыг хооронд нь холбон үе бүтээлгэн хурууны үсгээр уншуулна.

Зурагт карт, үзүүлэн – үе бүхий зураг, хурууны үсэгтэй үзүүлэн, картуудыг ашиглан уншуулж болно. Тод сайн харагдахаар бүтээгдсэн байна. Эгшиг үсэг нь дан өнгөтэй байвал ялган уншихад амар байдаг.

Багш юуг анхаарах вэ?

Багш сурагчийг үеийг уншихдаа хурууны үсгээр зөв илэрхийлж байгааг олон бичмэл, дармал үеийг уншаад ялган илэрхийлж, зөв таньж байгаа эсэхэд анхааран ажиллана. Үеийг уншуулахдаа зөв дуудах талаас бус амны хайрцгаар зөв илэрхийлж байгаа талаас анхаарах ёстой.

Хэрхэн үнэлэх вэ?

Сонсголгүй хүүхдийг үнэлэхдээ сайн муугаар үнэлэх бус тухайн үеийг хурууны үсгээр тод, амны хайрцгаараа зөв илэрхийлж байгааг үнэлж болно. Үеийг адил төстэй үетэй андуурахгүй унших, дармал, бичмэлээс уншиж чадаж байгаа эсэхийг голчлон үнэлнэ.

Үг уншуулж сургах

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Хүүхэд эхийн хэвлийд байхаас л оюун ухаан нь хөгжиж эхэлдэг. Хүүхэд төрсөн цагаасаа сонсголоороо дамжуулан орчинтойгоо танилцаж, үгийн баялгаа нэмэгдүүлсээр байдаг. Сургуульд орж бичиг үсэг сурч эхэлснээр тухайн үгээ бичгээр буулган, уншихдаа үгээ таньж мэддэг. Харин сонсголгүй сурагчдын хувьд төрсөн цагаасаа өөрийн төрөлх дохионы хэлээрээ орчинтойгоо танилцаж, харилцаанд орж байдаг. Үгийг зурагт карт, үзүүлэн, хэрчмэл үг, тараах материал зэргийг ашиглан дохионы хэлээр зааж таниулан ойлгуулна. Хэрчмэл үг уншуулан зурагт карттай холбох, үе ашиглан үг бүтээлгэн уншуулах, сонирхолтой дасгал даалгавар гүйцэтгүүлэн унших чадварыг хөгжүүлэх нь маш чухал юм. Дохионы хэлээр чөлөөтэй харилцдаг хүүхдүүдийн хувьд тухайн үг, өгүүлбэрийн утгыг дохионы хэлээр хэрхэн илэрхийлдэг болохыг сайн харуулж нүдлүүлэх нь чухал байдаг. Сонсголгүй хүүхдэд үг уншуулахдаа цээжлэх, утгыг ойлгож авах дараах аргыг ашиглаж болно.

- Гарын ижил хэлбэртэй үгийг уншуулах:
Дохионы хэлний гарын ижил хэлбэрээр илэрхийлэх дохионы үгийг уншуулж болно. Жишээлбэл: “А” үсгээр эхэлсэн гарын хэлбэртэй дохионы үгнүүд болох “ажил, аврах, алах, найз, жил, чулуу, зодолдох, дасгал” гэх мэтийг уншуулж тогтоолгож болно. Гарын ижил хэлбэртэй дохиог илэрхийлж үгийг уншуулахаас гадна утгыг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй.
- Үгсийн аймгийг бүлэглэн уншуулах
Жишээлбэл: Жинхэнэ нэр, тэмдэг нэр, үйл үг, тооны нэр зэрэг үг бичсэн хэрчмэл карт болон тухайн үгийг илэрхийлсэн зурган карт бэлтгэнэ. Өгөгдсөн зургийг харж, нэрийг нь олон үг дундаас олж холбох даалгавар хийлгэн, үг уншуулан тогтоолгож болно.
- Бяцхан толь бичиг бүтээлгэн уншуулах
Жишээлбэл: Сэдэв бүрээр боловсруулан гаргасан “Бяцхан зурган толь бичиг” бүхий хэрэглэгдэхүүнийг ашиглан үг уншуулж, тогтоолгож болно. Тухайн хэрэглэгдэхүүн овор багатай, хаана ч явсан хэрэглэхэд амархан байхаар бүтээгдсэн байвал хүүхдэд хэрэглэхэд амар байдаг.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Багш сонсголгүй хүүхдэд үгийг таниулахдаа дохионы хэлээр сайн ярьж тайлбарлахаас гадна үгийн утгыг тодорхой илэрхийлсэн үзүүлэн ашиглана. Хүүхэд тухайн үгийг уншаад ямар утга илэрхийлсэн үг болохыг санахгүй байсан ч зургийг хараад санаж, улмаар уншаад амархан тогтоож авдаг.

Зураг 13. Юмсын зураг болон нэр бүхий үзүүлэн



Хараан дээр суурилсан сургалтын үзүүлэн материал бэлдэж, боловсруулан гаргах нэн чухал болно. Сургалтын материалаар баялаг байж, сургалтаа явуулснаар сонсголгүй хүүхэд илүү сайн ойлгож, үгийг уншиж тогтоож авна. Сонсголгүй хүүхдэд үг таниулахдаа тухайн ижил үг, ойролцоо утгат үг, салаа утгат үг, эсрэг утгат үг зэрэг үгийн ялгааг зааж таниулах хэрэгтэй.

Энэхүү ялгааг таниулаагүйн улмаас сонсголгүй хүүхэд “хар” гэсэн үгийг уншихдаа “хар өнгө” гэдгээр ойлгон уншина. Бичгийн хэлээс уншихдаа “инээмсэглэх” гэдэг үгийг таниад түүний ойролцоо утгат үг болох “хөхрөх, мишээх” үгийг уншсан ч утгыг нь ойлгохгүй байдаг. “Гарах” гэдэг үгийг уншихдаа зөвхөн хаалгаар гадагш гарах гэсэн утгаар уншиж мэддэг бол “кино гарах, ууланд гарах, гарцаар гарах” зэрэг үгийг уншихдаа “кино гадагшаа хаалгаар гарах, ууланд гадаа гарах” гэсэн буруу утгаар ойлгодог.

Сонсголгүй хүүхдийг уншуулж сургахын тулд юун түрүүнд үгийн нөөцийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт юм. Ижил үг, ойролцоо үг, салаа утгатай үг зэрэг үгийг тайлбарлахдаа харааны хүртэхүйгээрээ уншиж, мэдээлэл хүлээн авах боломж бүрдүүлж өгөх нь чухал. Үгийг уншуулахдаа дараах зурагт үзүүлэнг ашиглаж, ялгааг зургаас үзүүлэн тайлбарлаж болно.

Зураг 14. Үгийн утгыг таниулахад ашиглах зураг

Ижил үг		
хар – үйл үг	хар – өнгө	хар- сөрөг зан авир
Ойролцоо утгат үг		
инээмсэглэх	Хөхрөх	Мишээх

Салаа утгат үг		
кино гарах	ууланд гарах	гарцаар гарах
		

Холбоо үг уншуулж сургах

Сонсголгүй хүүхдэд холбоо үг гэж юу болох талаар тайлбарлаж, түүний тухай ойлголт өгөх нь чухал. Үйл үгсийг ашиглан холбоо үг бүтээлгэн уншуулах, зурган картаар холбоо үг бүтээн унших, асуулт тавьж холбоо үг зохион унших нь сонсголгүй хүүхдийн унших чадварыг хөгжүүлэхэд нэн тустай. Жишээлбэл: “унших” гэсэн үгийн утгыг тайлбарлаж, “Юуг уншиж болох вэ?” гэсэн асуулт асууна. Унших боломжтой боломжгүй зүйлийн нэрсийг хэрчмэл үгээр танилцуулж уншуулна. Хүүхдээр унших боломжтой зүйлийн нэр нь хаана байгааг олж уншуулаад, “унших” гэсэн үгтэй холбуулж холбоо үг бүтээлгэн уншуулна. Жишээлбэл: ном унших, сонин унших, сэтгүүл унших, захидал унших гэх мэт. Мөн “идэх” гэсэн үгтэй холбоо үг уншуулахдаа идэж болох зүйлийн нэрсийг бичиж, холбоо үг үүсгэн утгыг нь тайлбарлаж уншуулна. Сонсголгүй хүүхдэд бичвэрээс үгсийн утгыг тайлбарлалгүй уншуулах бус тайлбарлаж өгч байж уншуулах нь үр дүнтэй.

Багш юуг анхаарах вэ?

Багш сонсголгүй сурагчдад үгийн утгыг нь ойлгуулахгүй, автоматаар цээжлүүлэхээс аль болох татгалзах хэрэгтэй. Үг бүрийг уншуулахдаа заавал утгыг нь ойлгуулж, тайлбарлаж өгч уншуулах шаардлагатай. Ингэснээр хүүхэд үгийн утгыг мэдэж амархан ойлгож тогтоож авдаг. Тухайн үгийг дохиогоор хэрхэн илэрхийлэхийг зааж өгвөл зохино. Сонсголгүй хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, дохионы хэлний чадварыг сайжруулахад багш төрөл бүрийн аргыг ашиглах шаардлагатай.

Хэрхэн үнэлэх вэ?

Аливаа үгийг цээжилснийг бус утгыг нь мэдэж авсан эсэхийг ашиглаж хүүхдийн үг унших чадварыг үнэлэх хэрэгтэй. Утгыг нь мэдэхгүй үгийг цээжилсэн байгааг үнэлэх нь буруу юм. Утгыг ойлгож авахгүйгээр үг цээжилбэл амархан мартдаг. Дохионы хэлээс уншуулж үг бичүүлэх, бичгийн хэлээс уншуулж үгийг тайлбарлуулах хэлбэрээр үнэлж болно.

Өгүүлбэр уншуулж сургах

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Сонсголгүй хүүхдийн эх хэл нь дохионы хэл бол хоёрдогч хэл нь монгол хэлний бичгийн хэл юм. Монгол хэлийг дохио хэлбэрт оруулсан хэлний нэг хувилбар гэдэг буруу ташаа ойлголт нийгэмд байдаг. Монгол дохионы хэл нь өөрийн гэсэн хэл зүй, үгийн сантай бие даасан хэл. Монгол хэл, дохионы хэл хоёрын өгүүлбэрийн бүтцийн дараалал нь өөр байдаг. Өөрөөр хэлбэл дохионы хэлээр илэрхийлсэн зүйлээ дохионы бүтцийн дагуу монгол хэлээр бичиж илэрхийлэх боломжгүй. Мөн монгол хэлний зөв бүтэцтэй өгүүлбэрээс шууд уншиж ойлгоход төвөгтэй байдаг.

Аав хөдөөнөөс машинаар ирсэн” өнгөрсөн цаг дээрх өгүүлбэрийг илэрхийлэхдээ дохиогоор “ААВ ХӨДӨӨ МАШИН ИРЭХ” гэж үг бүрээр дохиж илэрхийлвэл “аав, хөдөө, машин, ирэх” гэсэн дөрвөн төрлийн дохио болж дохионы хэлний бүрэн өгүүлбэр болж чадахгүй.

“Аав хөдөөнөөс машинаар ирсэн” өгүүлбэрийг зөв бүтцээр унших чадвар өгөхийн тулд дохиогоор нөхцөл, бүтээвэртэй хамт илэрхийлэх хэрэгтэй. Энэхүү өгүүлбэрийг дараах байдлаар илэрхийлнэ.

Хүснэгт 5. Үгийн утгыг таниулахад ашиглах зураг

№	Дохих үг	Хэрхэн дохиж илэрхийлэх талаар тайлбар
1	Аав	Дохиогоор “ААВ” гэж дохино.
2	хөдөөнөөс	Хөдөө нь өөрийн байгаа газар биш хол газар тул дохиогоор илэрхийлэхдээ цээжний урдаа “ХӨДӨӨ” гэж дохиж бус хоёр гараа цээжнээсээ хол байрлалтай “ХӨДӨӨ” гэж дохино. Гарахын тийн ялгалын “-ӨӨС” нөхцөл нь дараагийн “ИРЭХ” гэсэн дохионд илэрнэ. Дохиогоор “ирэх” гэж дохиход хөдөөнөөс гарч байгаа нь гарахын тийн ялгалын “-өөс” нөхцөлийг илэрхийлнэ.
3	машинаар	Үйлдэхийн тийн ялгалын “-аар” нөхцөлийг “машин” дохиог дохиж байхдаа хөдөлгөөн нэмж илэрхийлнэ. Үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийг тухайн дохиог хөдөлгөөн оруулж илэрхийлдэг.
4	ирсэн	Энэхүү дохиог долоовор хуруугаар “ирэх” гэж дохихгүй ба юугаар ирснээр дохиж илэрхийлнэ. Жишээлбэл: алхаад ирсэн бол алхах үйлдэл хийж ирж байгаагаар, онгоцоор ирсэн бол онгоц нисээд ирж байгаагаар, унадаг дугуйгаар бол дугуй унаад ирж байгаагаар дохиж илэрхийлнэ. Машинаар ирж байгаа бол машин ирж байгаа дохиогоор илэрхийлнэ. Төгсгөлд нь өнгөрсөн цагаар төгсгөх “-сэн” нөхцөлийгүгэн бус илэрхийллээр илэрхийлнэ.

Өгүүлбэрийн утгыг зөв ойлгож уншуулахын тулд тухайн өгүүлбэрийг илэрхийлсэн зурагт үзүүлэн ашиглаж тайлбарлах нь илүү үр дүнтэй. “Аав машин угааж байна”, “Аавын машин угааж байна” гэсэн хоёр өгүүлбэрийг хэрхэн уншиж ойлгуулах талаар зурагт үзүүлэн ашиглан тайлбарлах хэрэгтэй. Энэхүү хоёр өгүүлбэр нь өөр утгыг илэрхийлж байгаа ч сонсголгүй хүүхэд уншаад “аав өөрөө машинаа угааж байна” гэж адил утгаар ойлгоно.

Эхний зурагт “Аав машин угааж байна.” өгүүлбэрт тийн ялгалын ямар нэг нөхцөл ороогүй бол аав өөрөө машин угааж байгааг илэрхийлж байна гэдгийг зураг ашиглан тайлбарлана. Харьяалахын тийн ялгал ороогүй үг нь шууд тухайн үгийн утгыг илтгэдэг бол тийн ялгал орсон үг холбоо харьцаа зааж, үгийг үгтэй холбож өөр утгыг илэрхийлдэг талаар зааж ойлгуулах хэрэгтэй. Харьяалахын тийн ялгалын “-ын” нөхцөлтэй “аавын машин” үг байгаа нь аав өөрөө биш өөр эзэн бие машин угааж байгааг тайлбарлаж болно.

Аав машин угааж байна.



Аавын машин угааж байна



Монгол хэлний энгийн өгүүлбэр дэх хүүрнэх, асуух, анхааруулах, захирах зэрэг өгүүлбэрийн онцлог, хэв шинжийг дохионы хэлээр илэрхийлэх арга зэргийг таньж мэдсэнээр уншихад дөхөмтэй байдаг. Хүүрнэх өгүүлбэр “Аав хөдөөнөөс машинаар ирсэн” гэсэн өгүүлбэрийг дохиогоор илэрхийлсэн аргаар дохиж ярина. Асуух өгүүлбэрийг дохиогоор илэрхийлэхдээ асуух үгээ төгсгөлд нь асууж, толгойгоо бага зэрэг өргөн, асууж байгаа нүүрний хувирал гарган илэрхийлнэ. Анхааруулах өгүүлбэрээр дохиж ярихдаа өгүүлбэрийн төгсгөлд толгойгоо дохиж, сануулж буй царайны хувирал гарган илэрхийлнэ. Харин захирах өгүүлбэрийг хөмсгөө бага зэрэг зангидсан үгэн бус илэрхийлэл үзүүлж, толгойгоо дээш, доош, баруун, зүүн чигийн аль нэг тийш хөдөлгөж тушаах маягаар дохин илэрхийлнэ.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Сонсголгүй хүүхдэд өгүүлбэрийг уншуулахад ашиглах хэрэглэгдэхүүн нь хараан дээр суурилсан зураг, дүрстэй, хөдөлгөөнтэй сургалтын хэрэглэгдэхүүн байна. Аль ч хамаагүй зураг дүрс ашиглах бус заах хичээлийн агуулга, илэрхийлж буй үг, өгүүлбэрийн утгад тохирсон зураг, дүрстэй үзүүлэн байна. Мөн үгийг зөв байрлуулж өгүүлбэр бүтээхэд хэрэглэх хэрчмэл үг, өгүүлбэр нөхөж бичихэд зориулан тараах материал зэргийг ашиглаж болно.

Багш юуг анхаарах вэ?

Багш зөв бүтэцтэй өгүүлбэрийг унших чадвар олгохдоо дохионы хэлээр тайлбарлаж, дохионы хэлний бүтцээр дохиж илэрхийлж заана. Ном, самбараас хуулж бичих, автоматаар цээжилж тогтоох аргыг хэрхэвч ашиглаж болохгүй. Сонсголгүй хүүхэд уншиж сурахад юун түрүүнд монгол хэлний нөхцөл, түүний утгыг мэдсэн байх хэрэгтэй. Нөхцөл бүтээврийн утгыг мэдэхгүй байснаар өгүүлбэрийг бүрэн ойлгож чаддаггүй. Монгол хэлний нөхцөл бүрийн утгын ялгааг таньж мэдсэнээр өгүүлбэрийг унших боломжтой.

Хэрхэн үнэлэх вэ?

Бичгийн хэлээс өгүүлбэрийг уншихдаа монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн дагуу уншиж, дохиогоор илэрхийлж байгааг үнэлж болох хэдий ч тус өгүүлбэрийн утгыг ойлгосон эсэхийг харгалзах хэрэгтэй. Утгыг нь ойлгохгүй, өгүүлбэр бүрээр дохиж илэрхийлж унших нь зөв арга биш. Уншсан өгүүлбэрээ дохионы хэлний бүтцээр, утга агуулгыг зөв илэрхийлж чадаж байгаа эсэхийг үнэлэх нь зөв арга төдийгүй хүүхэд ойлгож байгаа нь чухал байдаг.

ХОЁР: Дохионы хэлээс унших чадвар олгох

Ямар чадвар эзэмших вэ?

Аливаа аман мэдээллийг дамжуулахад түүнийг хүлээн авах нь сонсох үйлдлээр илэрнэ. Сонсох чадвар гэдэг нь хүний яриаг сайтар анхаарч, тэдний юу ярьж байгааг бүрэн гүйцэд ойлгож, мэдээллийг бүрэн хүлээн авч, хариу үйлдэл үзүүлэхийг хэлдэг. Өөрөөр хэлбэл сонсох чадвартай байна гэдэг нь хүнтэй харилцах харилцааны соёлын нэг хэлбэр юм.

Идэвхгүй сонсогчдын хувьд хүний яриаг сонсож байдаг ч ямар санаа ойлгуулах гэснийг нь бүрэн ухаардаггүй бол идэвхтэй сонсогчид хүний яриаг давтуулалгүй гүйцэд ойлгож, шаардлагатай хариу үйлдлийг оновчтой илэрхийлдэг. Идэвхтэй сонсогчид нь харилцан ярианы явцад хүний ярианд бүрэн анхаарч байгаагаа ямар нэг байдлаар илэрхийлж байдаг бөгөөд ингэснээр ярьж буй хүний зүгээс нөгөө хүнээ анхаарч байгааг ажиглан, өөртөө итгэлтэйгээр бүхнээ ярих нөхцөлийг бүрдүүлж өгдөг байна. Сайн сонсогч байснаар хүн бусадтай илүү гүнзгий холбоо үүсгэдэг бөгөөд бусдын итгэлийг хүлээдэг, асуудлыг оновчтойг шийдвэрлэдэг, илүү өргөн хүрээний мэдлэгтэй болдог, чухал мэдээллийг орхигдуулдаггүй зэрэг давуу талтай.

Хүүхдүүд багшийнхаа ярьж, зааж буй зүйлийг сайн сурч, ойлгож авахын тулд идэвхтэй сонсогч байх хэрэгтэй төдийгүй багш хүүхдүүдийг идэвхтэй сонсогч байлгахын тулд хичээл сургалтын үйл ажиллагаагаа хүүхдийн онцлогт тохирсон сонирхолтой аргаар явуулах хэрэгтэй болдог.

Сонсголгүй хүүхдийн хувьд сонсох, аман хэлээр ярилцах боломжгүй учир сонорыг нь хараа орлож, аман хэлийг нь дохионы хэл орлодог. Дохионы хэлээр ярьж буй аливаа мэдээллийг сонсголгүй хүүхэд харааны тусламжтайгаар дохионы хэлнээс уншиж ойлгож авдаг учир тэдний дохионы хэл унших чадварыг сайжруулах нь зүйтэй юм.

“Бага ярьж, сайн сонс гэж нэг ам, хоёр чих заяасан” гэсэн үг байдаг. Хүнтэй харилцан ярилцахад ярьж буй хүнийхээ яриаг сонсож, “сайн сонсогч байх” чадвар хүн бүрт хэрэгтэй болдог. Сонсголгүй хүүхэд дохионы хэлээр өгүүлэгчийн яриаг “сайн сонсох” буюу дохионы хэлээс уншиж, анхааралтай харах чадвартай байх нэн чухал. “Сайн сонсогч” буюу дохионы хэлээс уншиж, анхааралтай харах чадварт сургахын тулд багш дараах зөвлөгөөг сонсголгүй хүүхдэд өгч, дагаж мөрдүүлэхэд анхаарч ажиллах нь чухал.

Сонсголгүй хүүхдүүд бусдын дохионы хэлээрх яриаг яагаад анхааран унших хэрэгтэй вэ?

- Дохионы хэлээс ойлгож, анхаарч уншсанаар сонсголгүй хүүхдүүд суралцаж байдаг. Анхаарлаа өөр тийш хандуулах, дотроо өөр юм бодоход дохионы хэлээр ярьж буй хүнийхээ яриаг ойлгохгүй болдог.
- Дохионы хэлээр ярьж буй хүний өөрийг нь анхааран харж, сонсдог хүнд хүмүүс дуртай байдаг. Бусдыг өөртөө татах хамгийн шилдэг арга бол дохионы хэлээрх яриаг анхааралтай сонсож ойлгох юм.
- Сонсголгүй хүүхэд ярьж буй өгүүлэгчийн дохионы хэлээрх яриаг анхааралтай уншиж, ойлгосноор мэргэн шийдвэрт хүрч, зөв шийдвэр гарган асуудлыг шийдэх чадвартай болдог.
- Сэтгэл зүрх, оюун бодлоо тухайн хүндээ бүрэн төвлөрүүлж дохионы хэлээрх яриаг анхааралтай унших хэрэгтэй юм. Харж байхдаа өөр юм бодох, утсаа оролдох, нүүр

царайндаа тоомжиргүй байдлыг харуулах, харц салган өөр тийш харах зэргээс зайлсхийх хэрэгтэй.

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмших вэ?

Дохионы хэлний хэл зүйн дүрмийг ялгаж унших

Сонсголгүй хүүхдийг дохионы хэлээс унших чадварыг сайжруулахын тулд биеийн хэлэмж, үгэн бус илэрхийлэл, дохионы үгийн сан, дохионы хэлний хэл зүйн бүтэц дүрмийн ойлголт өгч, ялгаатай байдлыг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Сонсголгүй хүүхдүүд дохионы хэлээ өөрсдөө аяндаа сурчихна гээд орхиж болохгүй ба харин сургуульд орсон цагаас нь хойш хөгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй. Сонсголгүй хүүхдийн дохионы хэлний чадвар хурдан хөгжих тусам дохионы хэлээр ярьж буй зүйлийг уншиж ойлгох чадвар нэмэгддэг.

Дохионы хэлний таван бүрдүүлбэр: Монгол хэлэнд авиа, авиалбарууд нийлж үг бүтээдэг бол дохионы хэлэнд таван бүрдүүлбэр нийлж байж нэг дохио бүтээдэг. Дохионы хэлний таван элемент болох гарын хэлбэр, байрлал, хөдөлгөөн, алганы чиглэл, үгэн бус илэрхийллийн аль нэг элементийг буруу илэрхийлснээр сонсголгүй хүүхэд дохионы хэлнээс уншихдаа буруу уншиж ойлгох эрсдэлтэй. Тиймээс дохионы хэлний таван бүрдүүлбэрийг танилцуулж, элемент бүрийн ялгааг тайлбарлан ойлгуулах шаардлагатай. Жишээлбэл:

Хөдөлгөөн: “Ажил” гэдэг үгийн дохионы хэлний нэг гарыг доош, нөгөө гарыг дээш шулуун чиглэлтэй давтах хөдөлгөөнийг өөрчлөөд хагас эргүүлэх хөдөлгөөнөөр дохиж илэрхийлвэл “ажил” биш “алах” утгыг илэрхийлж, дохионы хэлээрх ярианы агуулга утгагүй болно. Сонсголгүй хүүхэд дохионы хэлнээс уншихдаа дохио бүрийн хөдөлгөөний ялгааг сайтар ажиглаж унших хэрэгтэй.

Алганы чиглэл: “Баримт мэдээлэл олоорой” гэсэн өгүүлбэрийг илэрхийлэхдээ хоёр гарын дээд алганы чиглэлийг доошоо чиглэлтэй илэрхийлэх ёстой байтал дээшээ чиглэлтэй илэрхийлснээр уг өгүүлбэр “Мэдээлэл олоод өгөөч” гэсэн утгатай болно. Алганы чиглэлийг өөрчилж дохиод ярьж буй зүйлийн агуулга мөн өөрчлөгдөж байна. Энэ талаар сонсголгүй хүүхдэд ялгааг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй. “Баримт” гэвэл алганы чиглэл дээшээ харсан, “байгаа” дохионы алганы чиглэл зүүн тийш, “өгөөч” дохионы алганы чиглэл дээшээ харсан ялгаа, дохионы үгийн нөөцийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Сонсголгүй хүүхдийн дохионы хэлний үгийн нөөц нь баялаг байх тусам дохионы хэлээр ярьж буй зүйлийн агуулгыг сайн ойлгодог. “байгаа, өгөөч” гэсэн дохиод мэддэг ч “баримт” гэдэг дохиог мэдэхгүй бол тухайн дохиог “өгөөч” гэсэн утгаар ойлгож магадгүй. Дараах зургаас алганы чиглэл ойролцоо дохионы ялгааг харж болно.

Зураг 16. Алганы чиглэл ойролцоо дохионы хэл



Үгэн бус илэрхийлэл: “Унтах, хэвтэх, хонох” үгийг дохионы хэлээр илэрхийлэхдээ гарын хэлбэр, байрлал, алганы чиглэл, хөдөлгөөн адилхан дохиогоор илэрхийлнэ. Үгэн бус илэрхийлэл буюу нүүрний хувирал, толгойн хөдөлгөөн ялгаатай илэрхийлэгдэнэ. “Унтах” үгийг дохиодоо нүдээ аньж дохио бол, “хэвтэх”-ийг нүдээ нээж дохино. Харин “хонох” дохиог илэрхийлэхдээ толгойгоо хажуу тийш алгандаа хүргээд салгаж дохино. Монгол дохионы хэлэнд хэд хэдэн үгийг нэг дохиогоор илэрхийлэх, эсвэл нэг үгийг олон дохиогоор илэрхийлж ярьдаг. Сонсголгүй хүүхдэд дохионы хэлний олон хувилбартай дохиог танилцуулснаар дохионы хэлээр ярьж буй хүний ярианд ямар утга нь орсонг ялгаж чаддаг.

Дохионы хэлний таван бүрдүүлбэрийн аль нэгийг буруу илэрхийлсэн тохиолдолд дохионы хэлээр ярьж буй зүйлийн агуулга алдагдаж, сонсголгүй хүүхэд буруу ойлгох, ойлгохгүй байх тохиолдол гардаг. Тийм учраас сонсголгүй хүүхдийн дохионы хэлний хэл зүйн бүтэц дүрэм, дохионы үгийн санг нэмэгдүүлж, дохионоос уншиж ойлгох чадварыг сайжруулах зайлшгүй хэрэгтэй.

Хурууны үсэг: Дохионы хэлээр ярьж байхдаа заримдаа хурууны үсгээр нэр томьёо, оноосон нэрийг илэрхийлж ярьдаг. Хурууны үсгээр үсэглэж ярихад сонсголгүй хүүхдүүд мэдэхгүй үгээ тогтоож авч чадахгүй байх тохиолдол их байдаг. Сонсголгүй хүүхэд дараах гурван шалтгааны улмаас хурууны үсгээс уншиж, үгийг тогтоож авч чадахгүй байдаг.

1. **Танил бус үг:** Сонсголгүй хүүхдийн мэдэхгүй танил бус үгийг хурууны үсгээр үсэглэж хэлсэн үед уншиж чаддаггүй. Хүний нэр, газар орны нэр зэрэг оноосон нэрүүд болон урт үгийг хурууны үсгээр илэрхийлэхэд эхний хэдэн үсгийг уншиж, цааш нь уншиж чадалгүй алддаг.
2. **Хурууны үсгээр унших дасгал:** Юмыг нэрлэх, хүний нэр хэлэх, бичсэн үг, өгүүлбэрээ үсэглэж хэлэх зэрэгт багш өөрөө ярих олон сонсголгүй хүүхдээр хурууны үсгээр яриулдаг. Хурууны үсгээр унших чадварыг сайжруулах зорилгоор дасгал хийлгэхэд анхаардаггүйгээс сонсголгүй хүүхдүүд хурууны үсгээс унших чадвар хангалтгүй байдаг.
3. **Хурууны үсгийн дүрэм:** Хурууны үсгээр үсэглэн ярихдаа дүрмийн дагуу үсэглэж ярих ба харагдах байдал тодорхой, ойлгомжтой, цэвэрхэн үсэглэж яривал зохино. Хурууны үсгээр ямар нэг үг илэрхийлж хэлэхдээ хурууны үсгийн чиглэлийг хааш нь харуулж үсэглэж ярихаа бодолцох зүйтэй. Зөв байрлалруу харуулж хурууны үсгээр ярихад сонсголгүй хүүхдүүд илүү сайн ойлгодог. Жишээлбэл: “үүл” гэсэн үгийг үсэглэхдээ “Ү” үсгийн гарын алгыг урагш биш өөрлүүгээ харуулж үсэглэнэ. Хурууны үсгээр үг илэрхийлэхэд заавал ямар зүгт харуулж үсэглэж ярина гэсэн дүрэм байхгүй ч ярьж буй хүн өөрт эвтэйхэн, уншиж буй хүнд тод харагдахаар үсэглэх ёстой.

Сонсголгүй хүүхдийн хурууны үсгээс унших чадварыг сайжруулахын тулд сонсголтой хүүхдэд заадаг хурдан уншлага хийх, цээж бичиг бичүүлэх хичээлийг хурууны үсгээр зааж болно. Тухайн хичээлээр сонсголгүй хүүхдийн хурууны үсгээр унших чадвар сайжрахаас гадна үгийн нөөц нэмэгдэх боломжтой. Дараах эхийг хэд ашиглан хурууны үсгээс унших чадварыг сайжруулж болно.

Ээжийгээ зүүдлэн нойрсов.

Шоргоолж тарвасны хэлтэрхий олж үүр лүүгээ чирэв. Үүрэндээ орвол авгалдай нь тайван нойрсож байлаа. Тэр авгалдайгаа тэврэн үнсэж эрхлүүлэв. Шоргоолж авчирсан тарвасаа авгалдайдаа өгөө. Бор ходоодоо божийтол хооллосон авгалдай нь инээмсэглэн унтав.

Шоргоолж үлдсэн хэсгийг нь өвлийн хүнсэндээ хэрэглэхээр далд хийв. Тэгээд дахиад л ой уруу гүйв. Харин авгалдай нь ээжийнхээ гарт тэврүүлэн зүүдэлж байв.

Алхам 1: Хурдан уншлага - Эхийг багш сонсголгүй хүүхдэд харуулахгүй, тэдний нас, сэтгэхүйн түвшинд таарсан хурдтайгаар хурууны үсгээр үсэглэн ярина. Сонсголгүй хүүхдүүд багшийн хурууны үсгээр ярьж байгааг анхааралтай харж, уншиж ойлгохыг хичээнэ. Багш хурууны үсгээр ярихдаа харагдах байдал тод, ойлгомжтойгоор ярих хэрэгтэй. Сонсголгүй хүүхдийн хурууны үсгээс уншиж байгаа үеийн нөхцөл байдлыг харгалзан багш өөрийн мэдрэмжээр хурдаа тохируулж болно.

Хурууны үсгээс анхлан уншуулахдаа хоёроос дээш үетэй урт үгийг үсэглэхдээ үеийн дунд тодорхой хугацааны зогсолт авч ярина. Жишээлбэл: шор-гоолж, тар-вас-ны, хэл-тэр-хий, үүр-эн-дээ, ав-гал-дай, нойр-сож, бай-лаа гэх мэтээр үе хооронд зогсолттой үсэглэн ярина.

Алхам 2: Уншуулж тэмдэглэл хөтлүүлэх - Сонсголгүй хүүхдүүд хурууны үсгээр зөв уншиж байгаа эсэхийг баримтжуулахын тулд уншсан зүйлээ бичиж тэмдэглэх дасгалаар шалгаж болно. Тухайн эхээс дан үг, холбоо үг, богино өгүүлбэрийг сонгон авч хурууны үсгээр үсэглэж ярьж, хүүхдээр бичүүлнэ. Жишээлбэл: “хэлтэрхий, авгалдай, үнсэж эрхлүүлэв, Шоргоолж тарвасны хэлтэрхий олж үүр уруугаа чирэв.” гэх мэт үг, өгүүлбэрийг ашиглаж болно. Хүүхдийн бичсэн тэмдэглэлийг уншиж, хурууны үсгээс уншиж чадаж байгаа эсэхийг дүгнэж болно.

Алхам 3: Ойлгож унших - Эхний хоёр алхмыг хийсний дараа багш эхийн бичвэрийг сонсголгүй хүүхдүүдэд харуулж, эхээс танил бус үг, эхийн агуулгыг нэг бүрчлэн тайлбарлаж өгнө. Эхийн агуулга, үгийн утгыг ойлгосон сонсголгүй хүүхдээр эхийг ойлгож унших дасгал хийлгэнэ. Хурдан уншлагын үеийн хурууны үсгээр илэрхийлэх хурдаас арай бага хурдтайгаар эхийг дахин үсэглэж ярина. Багшийг хурууны үсгээр ярьж байх үед сонсголгүй хүүхэд тухайн эхийн тайлбарыг санан ойлгож уншихыг хичээнэ. Жишээлбэл: “Шоргоолж тарвасны хэлтэрхий олж үүр лүүгээ чирэв.” гэсэн өгүүлбэрийг хурууны үсгээс уншиж байхдаа тухайн өгүүлбэрийн агуулгыг ойлгож уншина.

Алхам 4: Цээж бичиг - Дээрх алхмын дагуу хурууны үсгээс унших дасгалыг гүйцэтгэснээр сонсголгүй хүүхдэд тухайн эхийн агуулга, үг, өгүүлбэртэй бага зэрэг танил болсон байна. Багш эхийг дахин хурууны үсгээр ярьж, хүүхдээр цээж бичиг бичүүлнэ. Эхийн хаана нь том үсгээр эхэлсэн, төгсгөлийн цэг байгаа талаар хэлэхгүй ба хүүхдүүд эхийн бичвэр уншсан өмнөх мэдлэгээ сэргээн санаж, багшийн хурууны үсгээр ярьж байгааг уншиж цээжээр эхийг бичнэ. Том үсгийн дүрэм, цэг, таслалын дүрмийн талаар мэдлэгтэй байна. Жишээлбэл: “Тэр авгалдайгаа тэврэн үнсэж эрхлүүлэв.” гэсэн өгүүлбэрийг үсэглэн ярихад хүүхэд өөрөө “Тэр” үгийн “Т” үсгийг томоор, “эрхлүүлэв” үгийн төгсгөлд цэг тавьж бичнэ.

Сонсголгүй хүүхдийн хурууны үсгээр унших чадварыг сайжруулах дасгал хийлгэж ажилласнаар тухайн чадвар сайжрахаас авхуулаад үгийн нөөц нэмэгдэх, цээжлэн тогтоох, сэтгэн боловсруулах зэрэг чадварууд дагаад нэмэгдэх боломжтой. Монгол

хэлний хичээлийг сонсголгүй хүүхдэд заахад үг, холбоо үг, өгүүлбэр, нөхцөл, дагавар, үгсийн аймаг, эх, цогцолбор гээд олон зүйлд хурууны үсгийг бусад хичээлээс илүү ашиглах шаардлагатай болно. Аливаа эхийн утга, агуулгыг тайлбарлахгүйгээр хурууны үсгээр уншуулж, дасгал хийлгэх нь үр дүн багатай байдаг.

Монгол хэлний нөхцөл бүхий дохионы хэлээр яриаг унших нь

Өөрийн гэсэн бүтэц дүрэм бүхий дохионы хэл нь монгол хэлний нөхцөл, дагавар зэрэг хэл зүйн бүхий л дүрмийг багтаасан байдаг. Гэхдээ дохионы хэлийг монгол хэлний өгүүлбэр зүйн бүтцийн дагуу дохиж ярина гэсэн үг биш. Монгол хэл өгүүлбэр зүйн бүтэцтэй байдаг шиг дохионы хэл ч гэсэн өөрийн бүтэцтэй. Жишээлбэл:

Монгол хэлэнд “Манай аав улаан өнгийн машинд дуртай” гэсэн зөв бүтэцтэй өгүүлбэрийг дохионы хэлээр “МАНАЙ ААВ МАШИН/-Д/ ДУРТАЙ ӨНГӨ УЛААН” гэсэн бүтэцтэй дохиогоор ярьдаг. Дохионы ярианы хэлээр илэрхийлж буй бүтэцтэй өгүүлбэрийг найруулга, бүтцийн алдаатай гэж үзэх боломжгүй. Учир нь сонсголгүй хүүхдийн эх хэл дохионы хэл нь хэн нэгний зааж сургаснаар биш байгалийн жамаар бий болсон хэл байдаг. Монгол хэлний тогтсон бүтэцтэй өгүүлбэрийн үг нэг бүрийн дагуу дохиж ярихад сонсголгүй хүүхэд сайн ойлгож чаддаггүй. Сонсголтой хүмүүст монгол дохионы хэлний бүтэцтэй өгүүлбэртэй дохио нь ойлгомжгүй, сонин санагддаг шиг сонсголгүй хүүхдэд монгол хэлний бүтэцтэй өгүүлбэр мөн тэгж санагдана. Сонсголгүй хүүхдийг сурган хүмүүжүүлбэл, харилцан ярилцъя гэвэл багш болон эцэг эх нь хүүхдийнхээ эх хэлний бүтцийн дагуу ярих зайлшгүй юм.

Сонсголгүй хүүхдийг дохионы хэлнээс уншиж ойлгох чадвартай болгохын тулд дохионы хэлний бүтэцтэй өгүүлбэрээр ярьж байх хэрэгтэй. Хүүхэд дохионы хэлээр цагаар төгсгөх нөхцөлийг ашиглан ярьдаг хэдий ч аль нь ямар нөхцөл болохыг тайлбарлаж, монгол хэлний нөхцөлтэй холбож зааж өгөхөд амархан ойлгодог. Хүүхдийн ашиглаж байгаа нөхцөл бүхий дохионы хэлийг холбож заахгүй, зөвхөн монгол хэлний дүрэм заагаад байвал ойлгоход хүндрэлтэй байдаг. Өнөө үед сонсголгүй хүүхдэд монгол хэлний хичээл зааж байгаа багш нар ихэвчлэн энэ аргаар хичээлээ зааж байдаг. Жишээлбэл: Сонсголгүй хүүхэд дохионы хэлээр “Өчигдөр эмээ хөдөөнөөс ирээгүй” гэж дохионы хэлний бүтэцээр ярьж байхад багш тодотгон холбох “-ээ” нөхцөлийн дараа үгүйсгэх “-гүй” нөхцөл нь “ирээгүй” гэсэн үгэнд илэрч байгааг олж хараад, өөр өөр жишээгээр баяжуулан тайлбарлаж өгөх хэрэгтэй. Сонсголгүй хүүхэд “аа+гүй” нөхцөлийг ингэж дохидог юм байна гэдгийг мэдэж аваад, улмаар “Би орой хоолоо идээгүй. Гэрээ цэвэрлээгүй, Хичээлдээ яваагүй” гэж өгүүлбэр бичихдээ “аа+гүй” нөхцөлийг зөв ашиглаж бичиж чаддаг болно. Иймэрхүү аргаар сонсголгүй хүүхдийг монгол хэлний нөхцөлтэй танилцуулж, бичгийн хэлнээс болон дохионы хэлнээс уншуулж сургах боломжтой.

Сонсголгүй хүүхэд “явсангүй - явдаггүй - яваагүй - явмааргүй - явахгүй” үгийг өгүүлбэрт холбон дохионы хэлээр илэрхийлэхдээ зөв ярьж, дохионы хэлээс зөв уншдаг боловч аль нь “яваагүй”, аль нь “явахгүй” гэдгийг ялгаж, бичгийн хэлээр илэрхийлж чадахгүй байдаг. Эдгээр үгийн ялгааг тайлбарласнаар сонсголгүй хүүхэд дохионы хэлнээс уншсанаа бичгийн хэлээр ялган илэрхийлж чаддаг болно. Уг тодотгон холбох нөхцөлийн дараа орсон үгүйсгэх нөхцөлтэй үгийг дохионы хэлээр хэрхэн илэрхийлэхийг тайлбарлая.

№	Нөхцөл	Жишээ	Дохионы хэлээр тайлбарлах нь
1	-сан+гүй	явсангүй, идсэнгүй	“ЯВ+БАЙХГҮЙ” гэсэн дохионы хэлээр илэрхийлэх ба “байхгүй” гэхэд гараа алдлан, хоёр мөрөө дээш хөдөлгөн буулгаж илэрхийлнэ. Тухайн үг ямар утга илэрхийлж байгааг дохионы хэлээр илэрхийлэх ёстой. “Ах хөдөө явсангүй” гэсэн өгүүлбэрийг илэрхийлэхдээ ах нь хөдөө явах ёстой байсан ч яваагүй байгаа утгыг илэрхийлж дохино.
2	-даг+гүй	явдаггүй, иддэггүй	“ЯВ+ЯВ+БАЙХГҮЙ” гэж дохих ба “байхгүй” дохио нь олон хувилбараар илэрхийлэгддэг. Энэ дохионы утгыг илэрхийлэхэд нэг гарын хэлбэр нь “О” болж доош нь шулуун чиглэлтэй хөдөлгөж дохино. “Ах хөдөө явдаггүй” өгүүлбэрийн санаа нь ах хөдөө байнга яваад байдаггүй, бараг явдаггүй гэсэн санааг дохиогоор илэрхийлнэ.
3	-аа+гүй	яваагүй, идээгүй	“ЯВ+БАЙХГҮЙ” гэсэн дохиогоор илэрхийлнэ. “байхгүй” гэхийг нэг гарын хэлбэрээ “О” үсэг болгож, хоёр тийш нь хагас нуман хэлбэртэй хөдөлгөх ба үгэн бус илэрхийлэл нь хэлээ бага зэрэг гаргаж, хазсан байдлаар, толгойгоо бага зэрэг сэгсэрч дохино. Явах гэж байгаа ч хараахан яваагүй байгаа гэсэн агуулгыг илэрхийлж дохино.
4	-маар+гүй	явмааргүй, идмээргүй	“ЯВ+ДУРГҮЙ” гэж дохих ба “дургүй” үг дохиог нь хэд хэдэн хувилбарт дохиогоор илэрхийлдэг. “Дургүй” дохионы нэг болох нэг гарын долоовор хурууг амны хажуугаас нэг удаа эргэх хөдөлгөөн хийж гарын хэлбэрээ өөрчлөн “5”-ын тооны дохио болгож дохино. Амаа бага зэрэг ангайн хэлээ гаргасан үгэн бус илэрхийллээр дохино. Явмааргүй байгаа дургүй байгаа утга нь ойлгогдохоор дохино.
5	-х+гүй	явахгүй, идэхгүй	“ЯВ+ҮГҮЙ” гэж дохиогоор илэрхийлэх бөгөөд “үгүй” дохионы хувилбар болох “В” үсэгтэй нэг гарын хэлбэрээ, хагас нумарсан хөдөлгөөнөө хоёр тийш хөдөлгөх ба толгойгоо сэгсэрч, хөмсгөө үл ялиг буулган дохино. “Үгүй” гэх дохионы хувилбар болох “Ү” үсэгтэй гарын хэлбэрээр дохидог дохиог үгүйсгэх “явахгүй, идэхгүй” зэрэг үгэнд ашиглах тохиромжгүй.

Цээж бичиг хийх:

Амнаас авиа гарган хэлсэн үгийг бичиг рүү буулгахад гаргасан авиа болгон үсгээр бууж бичигдэхгүй байх мөн гаргаагүй авиа ч үсэг болж бичигдэх тохиолдол байдаг. Олон удаагийн давтамжтай цээж бичиг хийхэд үгийг зөв бичих дадалд суралцан, гар, нүдний ой тогтоолт сайжирна. Харин сонсголгүй хүүхдээр цээж бичиг хийлгэх гэж байгаа үед хоёр аргын аль нэгийг сонгон хэрэглэж болно.

Нэгдүгээр арга: Энэ арга нь хүүхдийн хоёр дахь хэл болох монгол хэлний үгийн санг шалгахад тохиромжтой. Аливаа үгийн дохиог багш дохиж, хүүхэд дэвтэр дээр бичнэ. Гэхдээ анхан үед тийн ялгалаар хувилаагүй нэрлэсэн үг байвал тохирно.

Хоёрдугаар арга: Хоёр ба түүнээс дээш үгээс бүрдсэн өгүүлбэр, эхийг цээжээр бичүүлэх арга. Цэг, таслал, тэмдэгт, үг бүрийг үсэглэж илэрхийлнэ. Цээж бичгийг сонсголтой хүүхдээр хийлгэхэд 3-4 орчим үгсийг нэг дор 2-3 удаагийн давтамжтай

хэлдгийн адилаар нэг агуулгад хамаарах үгсийг нэг дор 2-3 удаагийн давтамжтай үсэглэж бичүүлнэ. Бүх үг болон тэмдэгтийг нэг бүрчлэн үсэглэх нь бэлэн будаа идүүлж байгаатай ижил мэт санагдах ч цээж бичиг хийж хэвшсэн, гар, нүдний ой тогтоолтод үгийг хэрхэн зөв бичихийг сурсан хүүхдэд хялбар байж, хэрэн зөв бичихээ хараахан сурч амжаагүй хүүхэд тэр бүр анзаарахгүй өнгөрөөх нь элбэг тохиолдоно.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Дохионы хэлээс уншуулах чадвар эзэмшүүлэхэд дохионы хэлтэй дүрст бичлэг, дохионы хэлний толь бичиг зэрэг янз бүрийн материал ашиглаж болно. Мөн зурагт үзүүлэн, хэл зүйн дүрэм, нөхцөлийг тайлбарласан үзүүлэн материал ашиглаж болно.

Сонсголгүй хүүхдийг дохионы хэлээс уншуулах чадвартай болгохын тулд монгол хэлний нөхцөлөөр илэрхийлэгддэг дохионы хэлний ялгааг заавал тайлбарлаж, ойлгуулж өгөхөд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн материал ашиглавал зохино. Ингэснээр сонсголгүй хүүхэд дохионы хэлээс уншиж ойлгож, улмаар бичгийн хэлрүү буулгах чадвартай болоход ач холбогдолтой юм.




Дохионы хэлээр ярихдаа цагаар төгсгөх нөхцөлтэй үгийг илэрхийлэх бүрэн боломжтой. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагаар төгсгөх нөхцөлтэй дохиог хэрхэн уншуулж сургах, ялгаж ойлгох талаар товч тайлбарлая. Юун түрүүнд сонсголгүй хүүхдийн харааны хүртэхүйд суурилсан нөхцөлийн утгыг илэрхийлсэн зурагт үзүүлэн бэлдэж, заах шаардлагатай.

Зураг 9. Цагаар төгсгөх нөхцөлийг илэрхийлсэн зураг



Одоо, өнгөрсөн, ирээдүй цагаар төгсгөх нөхцөлийг ялгаж дохихдоо дохионоос гадна ихэвчлэн үгэн бус илэрхийллээр ялгаж дохидог. Цагаа төгсгөх нөхцөлийг илэрхийлсэн зарим хувилбар дохиог жишээ болгон тайлбарлаж хийлээ.

Хүснэгт 7. Цагаар төгсгөх нөхцөлийг илэрхийлсэн дохио, тайлбар

Өнгөрсөн цаг “-сан ⁴ ”	Одоо цаг “-ж байна”	Ирээдүй цаг “-на ⁴ ”
		
<p>Энэхүү зураг нь “хийсэн” гэсэн дохио бөгөөд “-сан⁴” нөхцөлийг “УА” гэсэн үсгээр илэрхийлсэн амны хөдөлгөөн гаргаж дохино.</p>	<p>Энэ зураг “Бороо орж байна” гэсэн гурван үгтэй өгүүлбэрийг илэрхийлсэн нэг дохио юм. Монгол хэлний өгүүлбэрийн дагуу “БОРОО ОРЖ БАЙНА” гэж гурван дохиогоор ярих нь</p>	<p>“Уулзна” гэсэн үгийг дохиогоор илэрхийлж байна. Уулзаагүй байгаа, уулзана гэж бодож байгаа учир “уулзна” үгийг дохихдоо бодох үйлдэл үзүүлж байгаа нүүрний хувирал гаргаж дохино.</p>

<p>“ИД+УА, ДУУС+УА, ХАА+УА” гэж дохих нь “идсэн, дууссан, хаасан” гэсэн утгыг илэрхийлнэ.</p>	<p>дохионы хэлний бүтцийн бус дохио болно. Бороо орох үйлдлийг дохиогоор хэд хэд давтан хийх нь “Бороо орж байна” гэдгийг илэрхийлнэ.</p>	<p>“уншина, хийнэ, явна” гэсэн ирээдүй цагаар төгсгөх нөхцөлтэй үгийг дохихдоо толгой дохиж, бодох үйлдэлтэй царай гаргана.</p>
---	---	---

Монгол хэлний хичээлийн нөхцөл болон өгүүлбэрийг хэрхэн дохионы хэлээр илэрхийлэх талаар жишээ болгон авч үзлээ. Үүнээс харвал монгол хэлний хичээлийн агуулгыг дохионы хэлээр бүрэн илэрхийлэх боломжтойг мэдэж болно.

Сонсголгүй хүүхдийг дохионы хэлээс уншуулах чадвар эзэмшүүлэхэд монгол хэлний дүрмийг, дохионы хэлээр хэрхэн илэрхийлдэг талаар ойлголт, мэдлэг өгөх хэрэгтэй. Учир нь тухайн илэрхийлэгдэж буй дохионы хэлийг бичгийн хэлрүү хэрхэн бичиж буулгадаг талаар дохионы хэлтэй нь холбон зааж өгөхөд үр дүнтэй байдаг.

Багш юуг анхаарах вэ?

Дохионы хэлнээс унших чадварыг сайжруулахын тулд юун түрүүнд багш нь дохионы хэлний бүтэц дүрмийн дагуу дохиж ярьдаг, үгэн бус илэрхийлэл, биеийн хэлэмж зэргийг тодорхой ашиглаж ярьдаг байх нь чухал.

Сонсголгүй хүүхдийн эх хэл дохионы хэлний бүтэц дүрмийн дагуу тодорхой ярьж чадахгүй, сонсголгүй хүүхдийн дохионы хэлнээс унших чадварыг сайжруулна гэж ярих боломжгүй юм. Дохионы хэлнээс унших чадвар нь сайжирснаар сонсголгүй хүүхдийн аливаа дохионы хэлээрх мэдээллийг хүлээн авах, ойлгох чадвар нэмэгдэж, цаашлаад хичээлээ сайн ойлгож, бичгийн чадварт нь ахиц гарах боломжтой. Иймээс сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш нар өөрийн дохионы хэлний чадвараа сайжруулахад анхаарч ажиллахаас гадна сонсголгүй хүүхдийн дохионы хэлнээс унших чадварыг хөгжүүлэх хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.

Хэрхэн үнэлэх вэ?

Сонсголгүй сурагчдыг дохионы хэлээр уншсанаа ойлгосон эсэхийг үнэлэх хэрэгтэй. Үүний тулд дохионы хэлээс уншсан зүйлийн талаар асуулт асуух, сэтгэгдлийг сонсох аргаар үнэлж болно. Мөн дохионы хэлээс уншсанаа өөрийн үгээр тайлбарлан ярьж болно. Сонсголгүй хүүхэд нь дохионы хэлээс уншсанаа ойлгоогүй бол асуултад хариулж, ярьж чадахгүй байдаг.

3.2 ДОХИОНЫ ХЭЛЭЭР ЯРИХ ЧАДВАР

Ямар чадвар эзэмших вэ?

Харилцааны хүчирхэг залуур болсон хэл, уураг тархи хоёр нэгдэн яриаг үүсгэдэг. Сонсголтой хүүхэд сонсголоороо сонсож, аман ярианы хэлээр ярьдаг бол сонсголгүй хүүхэд хараагаараа хүртэж, монгол дохионы хэлээр ярьдаг. Сонсголтой, сонсголгүй ялгаагүй хүүхэд бүрийн ярианы чадварыг хөгжүүлэх нь нэн чухал. Хүүхдийн ярих чадварыг хөгжүүлснээр хүнтэй зөв харилцаж, өөрийгөө илэрхийлж илтгэх цаашлаад нийгэмшихүйн чадвар буюу хувь хүний хандлага төлөвшилд нөлөөлнө.

Сонсголгүй хүүхэд дохионы хэлээр ярихдаа дүрслэл ихтэй, энгийн дүрслэлтэй хоёр хэлбэрээр дохиж ярьдаг. Тус хэлбэрээр ярихдаа дохионы хэлний хэл зүйн найруулга, бүтэц, дүрмийн дагуу ярилцдаг бол дүрслэл ихтэй хэлбэрийнх сайн, энгийн дүрслэлтэй хэлбэрийнх муу гэсэн ойлголт байхгүй. Сонсголгүй хүүхэд, хүмүүст илүү хүртээмжтэй, ойлгомжтой байдаг нь дохиогоор дүрслэл ихтэй илэрхийлэх хэлбэр юм.

- 1. Энгийн дүрслэлтэй** - Энэхүү хэлбэрийн дохионы хэлээр уран зохиолын бус эх, телевизийн орчуулга, хурал чуулган, албан ажил, ярилцлага зэрэг үйл ажиллагааны үед ярина. Энгийн дүрслэлтэй дохионы хэлээр ярихдаа нүүрний хувирал хэт их гаргахгүй, мөн сэтгэлийн хөдөлгөөн, дүрслэлийг дохиогоор илэрхийлэхдээ хөдөлгөөн, орон зайн байрлал, нүүр царайны хувирал, биеийн хэлэмжийг яг бодит мэтээр бус эдгээрийг тодорхой хэмжээгээр ашиглаж ярина.
- 2. Дүрслэл ихтэй** - Энэ хэлбэрийн дохионы хэлээр сэтгэлийн хөдөлгөөн, дүрслэл бүхий уран зохиолын аливаа эхийг нүүр царайны хувирал ихтэй, биеийн хэлэмж, хөдөлгөөн, орон зайн байрлал, үйл явдал зэргийг тод томруунаар яг бодит мэтээр илэрхийлж ярьдаг. Өөрөөр хэлбэл киноны үйл явдал, зохиолын үйл явдлыг яг бодит мэтээр нүдэнд үзэгдэж, сэтгэлд мэдрэгдэхээр дохиогоор илэрхийлэхийг хэлнэ. Энэхүү хэлбэрээр ярихад дохионы хэл мэдэхгүй хүмүүс ч уран яруу, тод томруун илэрхийлж байгааг хараад ойлгох боломжтой байдаг. Багш дүрслэл ихтэй дохионы хэлбэрээр хичээл зааж ярихад сонсголгүй хүүхдүүд илүү сайн ойлгож, мартахааргүй тогтоож авдаг.

Сонсголгүй хүүхэд бүр энэ хоёр хэлбэрийн аль нэгээр ярих байгалиас заяасан чадвартай байдаг ч ярих зүйлийн сэдэв, агуулга болон орчны байдлаас шалтгаалан дохионы хэлээр ярих хэлбэрээ сонгож, ярих шаардлагатай болно. Ямар үед дүрслэл ихтэй хэлбэрийн дохиогоор, ямар үед энгийн дүрслэл хэлбэрээр ярих ёстой гэсэн дүрэм байхгүй ч орчин, уулзалтын зорилго сэдэвтээ мэдрэмжтэй хандаж ярих хэрэгтэй. Сонсголгүй хүүхдэд хичээл зааж байгаа багш бол дүрслэл их хэлбэрээр дохиж хичээлээ заах нь илүү үр дүнтэй төдийгүй сонсголгүй хүүхдийн онцлогт тохирсон байдаг.

Сонсголтой, сонсголгүй хүүхэд бүр өнгө дүрстэй, үйл явдалтай сонирхолтой хүүхэлдэй кино болон жүжиг үзэх дуртай байдаг шиг дүрслэл ихтэй дохионы хэлээр ярихдаа нүдэнд харагдтал, сэтгэлд мэдрэгдтэл уран тод ярихаар сонсголгүй хүүхэд сонирхон харж, улмаар сайн ойлгож авдаг.

Хүүхдэд энгийн болон дүрслэлтэй дохиогоор ярих чадвар эзэмшүүлэхийн тулд багш нь өөрөө тухайн хэлбэрийн дохиогоор ярьдаг, дохионы хэлний өндөр чадвар эзэмшсэн байх хэрэгтэй. Хүүхэд дохионы хэлээр дүрслэлтэй болон энгийн хэлбэрээр ярих ялгааг мэдэж, хэрэглэж сурснаар орчин нөхцөл, уулзалтын зорилгодоо тохируулан хүнтэй зөв харилцаж чадна.

Сонсголгүй хүүхдийг ойлгомжтой ярьж сургахын тулд өөрийгөө илэрхийлж ярих, уншсан, сонссон, сурсан зүйлийнх нь гол агуулгыг товч тодорхой, эмх цэгцтэй, сонирхолтой төдийгүй ахуйн дохио зангаа оруулахгүй ярих чадвар эзэмшүүлэхэд багш анхаарна. Энэхүү чадварыг эзэмшүүлэхийн тулд дараах үйл ажиллагаагаар дэмжин, ажиллаж болно.

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

1. Өөрийгөө илэрхийлж ярих

Сонсголгүй хүүхдийн өөрийгөө илэрхийлэх чадварыг сайжруулахын тулд хүүхдийн өөрийнх нь бодол санаа, ойлголт, саналыг яриулж болно. Сонсголгүй хүүхдийн санаа бодлоо бичгээр, яриагаар илэрхийлэх хоёр чадварыг сайжруулахад төрөл бүрийн аргыг ашиглана. Тухайн сонсголгүй хүүхдээр зохион бичлэг бичүүлэхэд хүүхэд юуг бичихээ мэдэхгүй байх, бичилгүй орхих, бусдын бичсэн зохион бичлэгийг хуулан бичих, автоматаар цээжилсэн зүйлсээ бичих тохиолдол их байдаг. Зохион бичлэг бичүүлэхийн өмнө өгөгдсөн сэдвээр хүүхдийн санаа бодлыг яриулж, дараа нь тухайн зохион бичлэгийг бичүүлэхэд дөхөм байдаг. “Мөнгөн өвөл” сэдвээр өөрийгөө илэрхийлж ярих, зохион бичлэг бичихэд дараах алхмаар ажиллаж болно. Энэхүү алхмаар ажилласнаар сонсголгүй хүүхдийн өөрийгөө илэрхийлэх, санаагаа бичгээр илэрхийлэх, мэдээлэл олох анализ хийх чадвар дээшилнэ.

- “Мөнгөн өвөл” сэдвээр өөрсдийн санаа бодлоо яриа болон бичгээр илэрхийлэх даалгавар өгнө.
- Тухайн сэдвийн “Мөнгөн өвөл” гэсэн нэрийн утгыг онцлон тайлбарлаж өгнө. “Мөнгө” нь цалин цагаан өнгөтэй, гялалзан харагддаг бөгөөд өвлийн улирлын байгалийн өнгийг мөнгөтэй адилтган, “Мөнгөн өвөл” гэж нэрлэсэн байгааг тайлбарлана.
- Сурагчдаар “Мөнгөн өвөл” сэдвийн тухай бодох хугацаа өгнө.
- Хүүхдээр өвлийн улирлын талаар интернет, номоос болон өмнө багшийн зааж байсан хичээлүүдээс мэдээлэл хайх, цуглуулж, анализ хийх боломж олгоно. Багш өөрөө өвлийн улирлын тухай мэдээлэл, зурагт үзүүлэн танилцуулж хүүхдийг мэдээллээр хангаж болно.
- “Мөнгөн өвөл” сэдвээр хүүхдүүд ярих зүйлийнхээ дэс дарааллыг товч үгээр тэмдэглэнэ. Ярих зүйлээ дэлгэрэнгүй бус товч үгээр хэрхэн бичиж тэмдэглэхийг багш сонсголгүй хүүхдэд заасан байна. Мөн зохион бичлэг бичих эхлэл, гол хэсэг, төгсгөл гэсэн бүтцийн талаар танилцуулсан байна.
- Сонсголгүй хүүхдийг багшийн болон бусад хүүхдийн өмнө “Мөнгөн өвөл” сэдвээр бичсэн зохион бичлэгийн утга санааг илэрхийлж яриулахын өмнө ганцаараа ярьж бэлтгэл хийх боломж олгоно.
- Хүүхэд “Мөнгөн өвөл” сэдвээр зохион бичлэгийн бүтцийн дагуу өөрийн санаагаа илэрхийлж ярих ба агуулгаа нуршихгүй, товч тодорхой ярина. Дохионы хэлээр товч тодорхой хэрхэн ярих талаар багш сонсголгүй хүүхдэд заасан байх хэрэгтэй. Дохиогоор ярихдаа дохионы хэлний бүтцийн дагуу ярихаас гадна нүүр царайны хувиралтайгаар, уран тодоор ярина.
- Хүүхэд “Мөнгөн өвөл” сэдвээр зохион бичлэгийн агуулгаа ярьж дууссаны дараа багш болон хүүхдүүд санаагаа хуваалцсанд баяр хүргэж урамшуулах хэрэгтэй. Урам авсан сонсголгүй хүүхэд илүү хичээл зүтгэлтэй болдог. Багш ярьсан зүйлийн сайн тал, сайжруулах зүйлийн талаар зөвлөгөө өгнө.

- “Мөнгөн өвөл” сэдвээр ярьсан зүйлээ сонсголгүй хүүхэд бичгээр буулган зохион бичлэг хийнэ. Хүүхдийн бичсэн зохион бичлэгтэй танилцан, алдаатай бичсэн үг, өгүүлбэрийг хэрхэн зөв бичих талаар тайлбарлан, засан сайжруулж бичиж өгнө.

Анхаарах зүйл:

Өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд зохион бичлэг, өгүүлбэр, өөрт тохиолдсон явдал, бусдад тохиолдсон явдал, сургамжит өгүүлэг, бяцхан номбүтээн түүнийгээ дохионы хэлээр илэрхийлэн ярьж энэхүү чадварыг хөгжүүлэх боломжтой юм.

Сонсголгүй сурагчид зохион бичлэг бичихдээ зөв бүтэцтэй өгүүлбэр бичиж чадахгүй, эсвэл яаж бичихээ мэдэхгүй байдаг. Энэ нь үгийн нөөц бага, зөв бүтэцтэй өгүүлбэр бичиж чадахгүйгээс болдог. Үүнээс гадна өөр нэг шалтгаан байдаг нь зохион бичлэгийн сэдэв, бичих ёстой агуулгыг ойлгодоггүйгээс болж бичиж чаддаггүй байна.

Багш юун түрүүнд сонсголгүй сурагчдад зохион бичлэг бичих сэдэв, агуулгыг нь төрөл бүрийн аргаар маш сайн тайлбарлаж өгөх ёстой. Сэдэв, агуулгыг ойлгосон сурагч зохион бичлэгээрээ илэрхийлэх зүйлийн талаар ойлголттой болно.

Багш өөрөө сурагчийн дохионы хэлээрх яриаг маш сайн ойлгож, зөвлөгөө өгч чаддаг байх хэрэгтэй. Зохион бичлэг бичүүлэхийн өмнө агуулгаа дохионы хэлээр ярьж тайлбарласнаар сонсголгүй сурагч өгүүлбэрийн бүтцийн алдаатай байсан ч санаагаа бичгээр буулгах боломжтой болно. Зохион бичлэгийг бичих бус ярьж сургахын өмнө ямар бүтэц, дараалалтай бичдэг талаар ойлголт мэдлэг өгсөн байх шаардлагатай.

2. Бусадтай харилцан ярих


Бусадтай харилцан ярих нь хүн бүрд байх ёстой харилцааны нэг чадвар юм. Бусадтай харилцан ярихын тулд анхааралтай сонсох буюу дохионы хэлээр ярьж буйг унших, эргэцүүлэн бодох, санаа бодлоо товч тодорхой илэрхийлэх, асуулт асуух, мэдээллийг зөв ойлгох зэрэг зэрэг нарийн ур чадвар шаарддаг. Харилцан ярианд өгүүлэгчийн ярьж буй зүйлийг анхааралтай харж унших (сонсох), нь маш чухал бөгөөд сонсголгүй хүүхэдтэй харилцан ярилцахдаа өгүүлэгчээс харц салгахгүй байх хэрэгтэй.

Бусадтай харилцан ярих чадварыг сайжруулахын тулд багш нэг сэдвээр сонсголгүй хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг зохион явуулж болно. Уг хэлэлцүүлэг дээр сонсголгүй хүүхдүүдийг дохионы хэлээр ярилцуулж, багшаас гадна хүүхдүүд хэлэлцүүлгийг чиглүүлэн явуулж болно.

Хэлэлцүүлэг хийснээр хүүхдүүд өөрийн үзэл бодлоо баримттай, товч тодорхой илэрхийлэх, бусдын яриаг дуустал унших (сонсох) чадварт суралцах төдийгүй бусадтай харилцан ярих чадварт суралцана.

Хэлэлцүүлэг гэдэг нь ямар нэг асуудлын талаар санал нэгдэх юмуу, эсэргүүцэх замаар харилцагчтайгаа санал бодлоо хуваалцахыг хэлнэ. Хэлэлцүүлэг хийснээр бие биетэйгээ санал солилцож, алдаа оноогоо мэдэх сайн талтай. Хэлэлцүүлэг явуулахад дараах зүйлийг анхаарч явуулна.

Загвар 1. Хэлэлцүүлэг зохион явуулах дараалал



- Хэлэлцүүлгийн сэдэв сонгох

Сонгосон сэдэв нь бүх хүүхдэд сонирхолтой, дэмжих болон эсэргүүцэх санал зөрөлдөөнтэй байвал сайн. Жишээлбэл: Ангид гарч байгаа хаягдал цаасыг яаж багасгах вэ? гэсэн сэдвээр хэлэлцүүлэг зохион явуулж болно.

- Хэлэлцүүлэгт бэлтгэх

Сонсголгүй хүүхэд хэлэлцүүлгийн сэдвийг маш сайн ойлгож, сэдэвтэй холбоотой материалыг ном, сонин сэтгүүл, интернэтээс судалж, тухайн мэдээллээ дохионы хэл мэддэг хүмүүсээр орчуулга хийлгэж мэдэх, мөн гэр бүлийнхэн, сонсголгүй ах, эгчээсээ асууж ирсэн байх хэрэгтэй. Жишээлбэл: Цаас хэрхэн бүтдэг, цаасны хог хаягдлаар юу хийдэг талаар судалгаа, тоо баримттай мэдээлэл олж ирсэн байна.

- Хэлэлцүүлэгт оролцогчид

Сонсголгүй хүүхдүүд өөрсдийн дундаас саналаараа шүүгч, хөтлөгч томилж, бусдыг хоёр баг болгон хуваана. Хөтлөгч хэлэлцүүлгийг чиглүүлэн явуулах ба шүүгч багуудын саналыг шүүн эцсийн дүгнэлтийг гаргана.

- Хэлэлцүүлгийн дэс дараалал

Хөтлөгч “Ангид гарч байгаа цаасан хаягдлыг яаж багасгах вэ” гэсэн сэдвээр хэлэлцүүлэг эхлэхийг хэлж, хэлэлцүүлгээ эхэлнэ. Багууд дэс дараалалтай ярих ба нэг баг дэмжсэн, нөгөө нь эсэргүүцсэн байдлаар ярьж хэлэлцэнэ.

- Хэлэлцүүлгийн үед мөрдөх зүйл

Эсрэг баг нөгөө багийн сонсголгүй хүүхдийн дохионы хэлээр ярьж байгааг дуустал уншина /сонсоно/. Ярих зүйлээ дохионы хэлээр бусдад үнэмшилтэй хэлж ярина. Багууд зөв гэж үзсэн зүйл дээрээ санал нийлнэ. Хэлэлцүүлгийн эцэст “Ангид гарч байгаа цаасан хаягдлыг хэрхэн багасгах” талаар хамтын шийд гаргана.

Анхаарах зүйл:

Сонсголгүй сурагчид хоорондоо ямар ч асуудалгүй харилцан ойлголцож ярилцдаг ч өгөгдсөн сэдвээр хэлэлцүүлэг явуулж, бие биенийхээ санал бодлыг сонсож, хүндэтгэлтэй хандаж, бусадтай зөв харилцах чадварт сурах шаардлагатай. Сонсголгүй хүүхэд хоорондоо хэлэлцүүлэг хийх боломжгүй хэмээн үзэж болохгүй юм. Хэлэлцүүлэг хэрхэн зохион явуулах арга замын талаар зааж, дадлага хийлгэснээр сонсголгүй хүүхдүүд сурч, улмаар өөрсдөө хэлэлцүүлэг хийж сурна.

Багш сурагчдынхаа харилцан яриаг сайн ойлгож, саад болохгүй байх шаардлагатай. Сурагчдын дохионы хэлээр ярьж буй нь өөр өөрсдөд нь зориулагдсан чөлөөтэй ярих боломжоор хангасан байвал хэлэлцүүлгийн сэдэвтээ илүү анхаарал хандуулж, ярилцана. Харин багшийн дохионы хэлний чадварын түвшинд зориулж ярьж байвал хэлэлцүүлгийн сэдэвтээ анхаарч, ярихад саад тулгарна. Хэрхэн удаан дохих, энгийн дохио хэрэглэвэл багш ойлгох вэ гэдэгт анхаарч хэлэлцүүлэгтээ анхаарах боломжгүй болох эрсдэлтэй.

3. Асуултад хариулж ярих

Хичээлд байнга хэрэглэдэг танин мэдэхүйн хэрэгсэл бол асуулт юм. Суралцахуйн бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан хүүхдийн хөгжлийг дэмжих орчин үеийн хичээл, хичээлийн соёлын хөгжилд асуултын гүйцэтгэх үүрэг маш их. Асуултыг ямар зорилгоор, хэнд зориулж төлөвлөх, бэлтгэх, хэрэгцээтэй үед нь яаж оновчтой хэрэглэх вэ? Хэзээ хэрхэн асуух вэ? гэх мэт асуудлыг анхаарч, асуултаа асуух хэрэгтэй. Суралцагчдад зориулсан асуулт нь нэг талаас тухайн ангийн сурагчдын танин мэдэх онцлогт нийцсэн,

нөгөө талаас сургалтын дидактик шаардлагыг хангасан байх учиртай. (Д.Эрдэнэсан "Монгол хэл заах арга" УБ., 2021. 70-р тал)

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш нар тухайн хүүхдийн сурах онцлогт нийцүүлж байна гээд хэт хялбар, сэтгэхүйн үйлд хөтлөх зорилгыг хангаж чадахгүй асуулт асуух нь үр дүнгүй юм. Багш асуултаа үгэн бус илэрхийллийг оролцуулж, дохионы хэлний бүтэц дүрмийн дагуу, сурагчдад ойлгомжтой, товч тодорхой, асуулт асуух хэрэгтэй. Сонсголгүй хүүхдийн асуултад хариулж ярих чадвар болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд блүүмийн асуултаар эх задлах аргыг ашиглаж болно. Жишээ нь:

“Зааны тавилан”

Нэгэн аялагч залуу хөдлөх ч үгүй, хол явах ч үгүй нэгэн заантай тааралджээ. Залуу эзнээс нь очиж “Энэ заанууд яагаад чөлөөтэй явахгүй байгаа юм бэ?” хэмээн асуухад хариуд нь:

“Зааныг тугал байхаас нь хөлийг нь модтой холбосон олсоор уядаг юм. Тэд эхэндээ явах гэж оролддог ч, уяанаасаа зүүгдэж унадаг учраас өөрийгөө хол явж чадахгүй гэдэгтээ насан туршдаа итгэдэг болчихдог юм” гэжээ. Яг л энэ зааны ижил бид эртнээс итгэсэн тэр л зүйлсээсээ болж “Хэзээ ч хийж чадахгүй” хэмээн боддог. Тиймээс та нэг удаа унасан эсвэл олон удаа бүдэрсэн аль нь ч байсан, тухайн зүйлийгээ “бүтэхгүй” гэж бодох хэрэггүй.

Дээрх эхээс блүүмийн аргаар асуулт асуухын тулд эхлээд эхийг хүүхдэд уншуулсан, шинэ үг бүрийн утгыг тайлбарласан, эхийг бүтнээр нь дохионы хэлээр ярьж, агуулгыг сайн ойлгуулсан байна. Дараах блүүмийн асуултыг асууна.

Загвар 2. Блүүмийн асуулт



Блүүмийн таван асуултыг сонсголгүй хүүхдээс асуухдаа дохионы хэл, үгэн бус илэрхийллийг маш ойлгомжтойгоор гаргаж асуух ба асуулт тус бүрийг хэрхэн асуух ёстой гэсэн тодорхойлолт байхгүй. Сонсголгүй сурагчид асуултад хариулж чадахгүй

байх шалтгаанууд байдаг. Багш тухайн шалтгааныг ялган ойлгож, ажиллах аргаа өөрчлөх, сайжруулах хэрэгтэй. Үүнд:

1. Асуултыг ойлгохгүй байх

Сонсголгүй хүүхэд багшийн асуултыг ойлгохгүй үед хариулж чадахгүй байдаг. Сонсголгүй хүүхэд асуултад хариулж чадахгүй бол багш шууд дүгнэхээс татгалзаж, асуултыг нь ойлгосон эсэхэд мэдрэмжтэй хандаж, асуултыг ойлготол дахин тодорхой асуух хэрэгтэй. Асуултаа тодорхой, ойлгомжтой асуухын тулд дохионы хэлээр ярьж асуухаас гадна нүүрний хувирлаа маш тодорхой илэрхийлж гаргах нь зүйтэй.

“Заанууд яагаад чөлөөтэй явж чадахгүй байсан бэ?” гэсэн асуултыг асуухдаа дохионы хэлээр “ЗААН+УУД ЧӨЛӨӨТЭЙ ЯВЖ ЧАДАХГҮЙ ЯАГААД?” гэж асууна. Дохионы хэлээрх асуух өгүүлбэрт асуултыг сүүлд нь асууна ба “ЯАГААД?” гэж асуухдаа тухайн дохиог илэрхийлэхээс гадна нүдээ том болгож, толгойгоо бага зэрэг дээш өргөн асуух хэрэгтэй. Энэ үйлдлийг хийхгүй зөвхөн дохиогоор “ЯАГААД?” гэвэл сонсголгүй хүүхдүүд асуултыг сайн ойлгохгүй. “ЗААН+УУД” гэсэн дохионы “+ууд” нөхцөлийг дохиогоор илэрхийлэхдээ “ОЛОН, БҮГД” дохионы аль нэгийг ашиглан дохино.

2. Асуултын хариуг мэдэхгүй байх

Багшийн асуултыг ойлгож байгаа ч хариуг нь мэдэхгүйн улмаас сонсголгүй хүүхэд хариулж чадахгүй байдаг. Энэ нь асуултын өмнөх мэдлэг, мэдээллийг ойлгож аваагүй, дутуу ойлгосноос үүдэлтэй. Багш энэ тохиолдолд сонсголгүй хүүхдийн онцлогт тохирсон аргаар өмнөх мэдлэг, мэдээллийг бататгах шаардлагатай. Өмнөх мэдлэгийг бататгахдаа дараах аргыг ашиглаж болно. Жишээлбэл: “Зааны тавилан” эхийг бататган заахдаа

- a) *Дохионы хэлээр тайлбарлах* – тухайн эхийг өмнө нь дохионы хэлээр тайлбарлаж ярьсан ч сонсголгүй хүүхдүүд ойлгоогүй байх үед багш өмнөх тайлбартаа анализ хийж сайжруулан, илүү ойлгомжтойгоор бататган тайлбарлах хэрэгтэй.
- b) *Жүжигчилэн үзүүлэх* – “аялагч залуу, зааны эзэн, заан” гэсэн гурван дүрээр багш ганцаараа эсвэл хоёр хүний тусламжтайгаар жүжиглэн үзүүлэх
- c) *Үзүүлэн материал ашиглан тайлбарлах* – эхэд гарч буй дүрийн үзүүлэнг самбарт байрлуулан тайлбартайгаар үзүүлж болно.
- d) *Сонсголгүй хүүхдээр яриулах* – багш өөрөө зааж тайлбарлахаас гадна сонсголгүй хүүхдээр эхийг дохионы хэлээр яриулж болно. Хүүхэд дутуу ярих эсвэл дараагийн үйл явдлыг мартаад ярьж чадахгүй байх үед тусламж үзүүлэх хэрэгтэй. Хүүхэд өөрөө тухайн эхийг дохиогоор ярьсны дараа илүү сайн ойлгож авдаг.

3. Яаж хариулахаа мэдэхгүй байх

Сонсголгүй хүүхэд багшийнхаа асуусан асуултыг ойлгож, хариуг нь мэдэж байгаа хариундаа эргэлзэж хэрхэн илэрхийлэхээ мэдэхгүй, ярьж чадна гэдэгтээ итгэлгүй байх тохиолдол бас байдаг. Ийм үед багш сонсголгүй хүүхдийг хариул гэж тулгахгүй, урам өгч зоригжуулах, ярих зүйлээ бэлдэх хугацаа өгөх хэрэгтэй.

Багш нэг газраа зогсон асуултаа асууж, нөгөө талд нь зогсон хариулах маягаар биечлэн үзүүлж болно. Хариултыг хэлэхдээ олон хувилбартай хариулт бэлтгэн үзүүлээд, хүүхдээр зөв хувилбарыг сонгуулан, учир шалтгааныг хэлүүлнэ. Багш асуултад хэрхэн хариулж байгаа болон өөр буруу хариулт хэлж байгаа эсэхийг сонсголгүй хүүхдүүд харснаар, ямар асуултад ямар хариу хэлэхийг ялгаж ойлгох боломжтой болно.


бичвэрийнхээ агуулгыг илэрхийлж чадсан байна.

хоёр морьтой гэсэн бичвэрийн агуулгыг гаргажээ.

амьдардаг гэсэн өгүүлбэрийг илэрхийлсэн зураг байна.

Үлгэрийн дүрийн “ярьж байгаа, бодож байгаа” үйлдлийн бичвэрийг зургаар илэрхийлэхдээ ойлгож ялгахад амархан байхаар гаргах хэрэгтэй. Болдоггүй бор өвгөн ярьж байгааг амны хажууд дугуй дүрсээр, бодож байгааг толгойн хажууд үүл шиг хэлбэртэй дүрсээр илэрхийлнэ. Бодож, ярьж буйг ялгаж илэрхийлж гаргаагүй бол сонсголгүй хүүхэд үлгэр унших, ярихдаа хэн бодож байна? хэн ярьж байна? гэдгийг ялгаж ойлгох, дохиогоор ярихад төвөгтэй байдаг. Жишээлбэл:

Зураг 18. Үлгэрийн бодох, ярих үйлдлийг илэрхийлэх үзүүлэн



Үлгэрийг дохиогоор ярихдаа үлгэрт гарч буй баатруудын хэн нь хаана зогсож, юу ярьж байгаа түүний дагуу зогсож ярих байрлалаа өөрчлөн үлгэрээ ярих хэрэгтэй. Болдоггүй бор өвгөн баруун талд доогуур зогсож, хурмаст тэнгэр зүүн талд дээгүүр зогсож байгаад ярилцахыг тайлбарлахдаа баруун тал руу нуруугаа бөхийлгөн дохиогоор ярина. Харин нуруугаа жаахан гэдийлгэн зүүн талд зогсон хурмаст тэнгэрийн яриаг дохиж ярина.

Зураг 19. Үлгэрийн дүрийг хэрхэн ялгаж дохих талаар



Мөн үлгэрт амьтан гарч ярьж байвал тухайн амьтны гадаад байдал, хөдөлгөөнийг дуурайн ярих. Жишээлбэл: арслан архирах-гэхээр нүүрний хувирлаа ууртай болгож, орилж байгаагаар, хулгана шүдээрээ мэрэх-гэхийг биеэ тонгойлгон жижигхэн мэтээр шүдээрээ мэрэх үйлдэл гаргаж ярих.

Багш үлгэрийн үйл явдлыг дохионы хэлээр уран тод, үйлдэх хөдөлгөөнтэй дэс дараагаар тайлбарлан дохиж ярьсны дараа мэдэхгүй шинэ үгийн утгыг тайлбарлан, сурагчдаар бичвэрийг уншуулна. Мөн үлгэрээс авсан сургамжийн талаар хүүхдүүдээс асууж харилцан ярилцаж, сургамжлан тайлбарлаж өгнө. Боломжтой бол тус үлгэрийг бичлэг хэлбэрээр үзүүлж, бататгаж болно.

Үлгэртэй танилцуулах хичээлийг дээрх дэс дарааллын дагуу сонсголгүй хүүхдэд танилцуулсны дараа уг дарааллын дагуу хүүхдээр яриулж, үйл явдлыг дэс дараагаар ярих чадварыг сайжруулах боломжтой. Сонсголгүй хүүхэд сайн ойлгож, сурч чадсан бол аливаа зүйлийг дэс дарааллын дагуу ярих чадварт суралцаж чадна.

Анхаарах зүйл:

Сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш тэдний харааны хүртэхүй дээр суурилсан сургалтын материал бэлдэж, ашиглах нь нэн чухал. Болдоггүй бор өвгөн үлгэр нь нийт 51 слайд бүхий цахим үлгэр юм. Болдоггүй бор өвгөний ярьж байгаа, бодож байгааг

дүрсээр ялган харуулсан. Сонсголгүй сурагч нь өвгөнийг ярьж байгаа, бодож байгаагийн алин болохыг хараад ойлгох боломжтой юм.

Сонсголгүй сурагч харааны хүртэхүйгээрээ зурагт үлгэрийг илүү сайн хүлээн авч, бичвэрийг уншиж ойлгохгүй байсан ч зургийн үйл явдлыг хараад бичвэрийг уншиж ойлгох боломжтой.

5. Уран тодоор дохиж ярих

Сонсголгүй хүүхдийн уран тод дохиж ярих чадварыг хөгжүүлэхийн тулд шүлэг уншуулж болно. Шүлэг нь уянгын зохиол тул уянгалаг шинжтэй, шүлэглэсэн хэлбэртэй байна. Шүлэг яруу найргийн яруу сайхан үг хэллэгийн сэтгэлд хоногших хүч чадлын тухай ойлголт өгөхийн тулд шүлгийг уран яруу, айзам хэмнэлттэйгээр уншиж ярьдаг. Сонсголгүй хүүхэд шүлгийг дохионы хэлээр уран яруу сайхнаар ярих боломжтой. Сонсголгүй хүүхдэд шүлгийг дараах аргаар зааж болох ба "Халуун элгэн нутаг" шүлэгтэй танилцуулахдаа доорх зүйлийг анхаарч ажиллана.

Шүлгийг уран тод уншдагийг урьдчилан ойлгосон байх хэрэгтэй. "Халуун элгэн нутаг" шүлгийг заахдаа эхлээд мэдэхгүй үг хэллэгийг сонсголгүй хүүхдээс асууж утгыг нь тайлбарлаж өгнө.

"Халуун элгэн нутаг" шүлэг	Үгийн утгын тайлбар
Элэг зүрхнээс уяатай	1. Элэг зүрх = сэтгэл зүрх
Энхрий Монгол нутаг минь	2. Энхрий = сайхан, элгэмсэг
Эцэг эхээс заяатай	3. Эрдэнэ = үнэ цэнэтэй
Эрдэнийн алтан өлгий минь	4. Өлгий = төрсөн газар нутаг
Цэцгийн шимийг тэтгэсэн	5. цэцгийн шим = юмны ашиг шим тэжээл
Цэнгэлийн хавар айлчлахад	6. айлчлах = хүрч ирэх, зочлох
Мөрөн гол нь дуугаа дуулж	7. сарьдаг = өндөр уулын оргил
Мөнх сарьдаг нь мишээдэг ээ	8. мишээх = инээх, гялалзах
Сэрүүн салхи сэвсүүлэн	9. сэвсүүлэх = сэвэлзэх, зөөлөн үлээх
Хацар нүүрийг илбэн байж	10. илбэх = зөөлөн хүрэх, илэх
Сэтгэл дотрыг ариулсан	11. ариулах = муу муухайг засах, ариун
Халуун элгэн нутаг минь	нандин байх

Дараа нь шүлгийн нэгээс хоёр мөр бүрийн утгыг дохионы хэлээр тайлбарлаж өгнө. Шүлгийн мөр бүрийн утга, агуулгыг тайлбарлаж өгөлгүйгээр шүлэг цээжлүүлж, яриулах нь үр дүнгүй. Жишээлбэл: "Элэг зүрхнээс уяатай энхрий Монгол нутаг минь" гэсэн мөр нь монгол нутгаа үргэлж сэтгэл зүрхэндээ бодож явдаг гэдгийг илэрхийлж байгааг тайлбарлана. Мөн "Эцэг эхээс заяатай эрдэнийн алтан өлгий минь" гэсэн мөр нь энэ дэлхийд бид хүн болж эхээс мэндлэхэд эх орон бидэнд өвлөгдөн ирдэг гэдгийг илэрхийлснийг хэлнэ. Шүлгийн мөр бүрийн утгыг тайлбарлахад сонсголгүй хүүхэд ойлгож, улмаар цээжлэх, шүлгээ ярихдаа сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэлтэйгээр ярихад ач холбогдолтой байдаг.

Шүлгийн бичвэр, үгийн утга, мөр бүрийн утга санааг тайлбарласны дараа шүлгийг дохионы хэлээр хэрхэн уншиж ярихыг заана. Шүлгийг ярихдаа биеийн хэлэмж, нүүрний хувирлыг дохионы хэлтэй хослуулан илэрхийлж уран тодоор дохиж ярина.

Шүлэг ярихдаа сэтгэлийн хөдөлгөөний илэрхийллээ нүүрний хувиралгүй ярихад шүлэг биш, энгийнээр дохиж ярьж байгаа юм шиг болно. Шүлгийг уншиж ярихдаа нүүрний хувирал, сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг хэрхэн гаргах талаар шүлгийн зарим мөрөөс жишээ болгон тайлбарлалаа.

№	Шүлгийн хэсгээс	Дохионы хэлээр уншиж ярихдаа
1	Элэг зүрхнээс уяатай Энхрий монгол нутаг минь	СЭТГЭЛ ЗҮРХ+ЭЭС УЯА+ТАЙ САЙХАН МОНГОЛ НУТАГ МИНЬ гэж дохионы хэлээр илэрхийлэхдээ <ul style="list-style-type: none"> ▪ сэтгэл зүрх – дохиог илэрхийлэхдээ сэтгэл дотроо баярлаж, сэтгэл хангалуун байгаа мэт нүүрний хувирал гаргаж дохино. ▪ холбоо+той – гэж дохихдоо нэг гараа зүрх хавьцаа байлгаж, нөгөө гараа цээжний урдаас наашлуулж, хоёр гараа хооронд нь холбож, толгой дохин илэрхийлнэ. Нүүрний хувирал гаргаж, сэтгэлийн хөдөлгөөн үзүүлэхгүй дохиогоор ярихад утга агуулга ойлгомжгүй болно. Жишээлбэл: СЭТГЭЛ ЗҮРХ ХОЛБОО САЙХАН МОНГОЛ НУТАГ МИНЬ Ингэснээр “зүрхнээс, уяатай” гэсэн үгийг тодорхой илэрхийлж чадахгүй байх төдийгүй шүлэг уншиж байна гэж мэдэгдэхгүй, утгын авцалдаагүй болно.
2	Мөрөн гол нь дуугаа дуулж	ТОМ ГОЛ ДУУ ДУУЛЖ гэж эхний мөрийг дохиогоор илэрхийлэхдээ “хүн дуу дуулах” шиг дохихгүй ба голын мөс хайлж, хоржигнон урсах чимээг илэрхийлж байгаагаар уруулын хөдөлгөөн, толгойн хөдөлгөөний хамтаар дүрслэн дохино. Хүн дуулж байгааг илэрхийлдэг дохио ашиглавал “Гол дуулж байна” гэж ойлгогдохоор болж логикийн алдаатай болно.

“Халуун элгэн нутаг” шүлгийг ойлгомжтой тодорхой арга зүйгээр заалгасан сонсголгүй хүүхэд шүлгийн агуулга, утга санааг ойлгож, дохионы хэлийг нүүрний хувирал, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэлтэй уран тод дохин ярьж чадна. Уран тодоор илэрхийлж ярих чадварыг зөвхөн шүлэг дээр бус богино өгүүллэг, үлгэрийг ч ашиглан хөгжүүлж болно.

Анхаарах зүйл:

Сонсголгүй хүүхдийг уран тодоор дохиж яриулж сургахын тулд багш өөрөө тухайн чадварыг сайтар эзэмшсэн байх шаардлагатай. Багш шүлгийг дохионы хэлээр урнаар дүрслэн дохиж байгааг сонсголгүй хүүхэд харж суралцах учир багшийн дохионы хэлний чадвар сайн байх нь гарцаагүй зүйл юм.

Шүлэгтэй танилцуулж байна гээд утга санааг тайлбарлаж өгөлгүй дохиогоор ярих, бичвэрийг цээжлүүлэх нь үр дүнгүй ба сонсголгүй сурагчид хэсэг хугацааны дараа мартдаг. Мөн шүлгийг дохиогоор ярихдаа сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэн гаргаж ярьж чадахгүй байдаг.

6. Тайлбарлаж ярих

Багш заасан зүйлээ өөрөө тайлбарлаж байхаас гадна сонсголгүй сурагчдаар бие даан тайлбар хийлгэж, санаа бодлыг нь сонсож, мэдэх шаардлагатай. Сурагчийн тайлбарлан ярих чадвар сайжрах төдийгүй өөртөө итгэлтэй болно. Утга санааг тайлбарлан ярих чадварыг нэмэгдүүлэхийн тулд эх, өгүүлбэр, холбоо үг, үгийн тайлбар, зүйр цэцэн үг зэргээр дамжуулан хөгжүүлэх боломжтой.

Зүйр цэцэн үгээр дамжуулан хүргэж байгаа агуулга, утга санааг нь тайлбарлуулахын тулд багш эхлээд тухайн зүйр цэцэн үгийг зааж таниулах хэрэгтэй. Сонсголгүй хүүхэд

шууд уншаад ойлгоход хүндрэлтэй байдаг учраас багшид дохионы хэлээр тайлбарлах шаардлага гарна. Зүйр цэцэн үгийг сонсголгүй сурагчдад хэрхэн зааж таниулах талаар авч үзвэл: Зүйр цэцэн үгийг үгсийг холбоо үгийг илэрхийлсэн зураг, дүрс зэрэг хэрэглэгдэхүүн ашиглах нь сонсголгүй хүүхдэд илүү дөхөм байдаг.

“Дуслыг хураавал далай

Дуулсныг хураавал эрдэм” зүйр үгийг заахдаа үг, холбоо үг, утгыг тайлбарласан зурагт үзүүлэн материал ашиглана. Энэхүү зүйр цэцэн үгийг хэрхэн заах талаар дэс дарааллыг дараах хүснэгтээр гаргалаа.

Хүснэгт 9. Зүйр үгийг дохиогоор тайлбарлах, таниулах аргачлал

№	Үзүүлэн материал	Заах арга зүй
1		Зүйр цэцэн үгийнхээ бичвэрийг сонсголгүй хүүхдэд уншуулна. Ойлгож байгаа эсэх, мэдэхгүй үг байгаа эсэхийг асууж лавлана. Сонсголгүй хүүхдээр өөрсдөөр нь уншуулахгүй шууд тайлбарлавал, хүүхэд аливаа зүйлийг хүнээр уншуулан бэлэнчилдэг болох эрсдэлтэй.
2		Тухайн зүйр цэцэн үгэнд байгаа “хураавал” гэсэн хоёр үгийн утгыг тайлбарлана. “хураах” гэдэг нь ногоо хураах, тоглоомоо хураахаас гадна өөр юу хурааж болох талаар асууж ярилцана. “Хураавал” үгийг “хураах бол” гэсэн утгаар тайлбарлаж өгнө.
3		Багш өөрөө эхэлж заахаас илүү хүүхдээс асууж, тайлбарлуулж байхыг чухалчилбал сайн. “дусал” гэдэг нь борооны дусал, угаалтуураас гоожих дусал янз бүрийн дуслууд байж болохыг хэлнэ. Ганцхан борооны дусал гэж хязгаарлагдмал хүрээнд бус дусал үгийн хувилбаруудыг тайлбарлах хэрэгтэй. Ингэснээр сонсголгүй хүүхэд “дусал” үг нь өөр үгтэй холбохоор янз бүрийн утгыг илэрхийлдэг болохыг мэдэж үгийн нөөц нэмэгдэх боломжтой.
4		“дуулах” үгийн утгын хоёр хувилбартай танилцуулна. Эхнийх нь дуу дуулах бол, хоёрдахь нь “сурсан, сонссон, мэдсэн” гэсэн утгыг илэрхийлдэг болохыг тайлбарлана. Зүйр цэцэн үгэнд аль утга нь илэрхийлэгдэж байгааг мэдэхийн тулд өгүүлбэрийг бүтнээр уншиж аль утга нь болохыг мэддэг талаар тайлбарлана.
5		Жижигхэн дусал уснууд бага багаар нэмэгдсээр далай шиг их устай болох боломжтойг тайлбарлана. Аяганд угаалтуураас дусал ус цуглуулж нэмэгдэж байгаа эсэхийг харуулж практик үйл хийлгэж үзүүлж болно. Дусал уснууд нэмэгдэж арвин их болох боломжтойг ойлгуулах хэрэгтэй.
6		“Дуу дуулсныг хураавал эрдэм” мөрийн утга юуг илэрхийлж байгааг асууна. Илэрхийлэх боломжгүй утга учир дуулах нь сонссон, мэдсэн, сурсан гэсэн хоёрдахь утгыг илэрхийлж байгааг тайлбарлаж өгнө. Аливаа зүйлийг бага багаар сурч мэдсэнээр тэр нь эрдэм болно гэсэн утга санааг илэрхийлж байгааг тайлбарлана. Зурган дээр багш хичээл зааж, хүүхдүүд заасан хичээлийг суралцсаар хожим эрдэм, ухаантай болно гэсэн санааг илэрхийлж байгааг хэлнэ.

Сонсголгүй хүүхэд зүйр цэцэн үгтэй танилцаж, суралцсанаар уг зүйр үгийн илэрхийлж буй агуулгыг өөрсдийн бодлоор тайлбарлаж болно. Багш сонсголгүй хүүхдийг сурсан зүйр үгийн агуулгыг өөр жишээгээр тайлбарлан ярихад дэмжлэг үзүүлж, анхаарч ажиллах хэрэгтэй. Сонсголгүй хүүхдээр “Дуулсныг хураавал эрдэм” мөрийн утгыг өөр жишээгээр тайлбарлахад багш чиглүүлэн ажиллана. Хичээлд сурч мэдсэн бүхэн эрдэм байхаас гадна аав ээж, ахмад хүмүүсийн үгийг сонсож сурах нь эрдэм, ажлыг бага багаар хийж сурах нь ч эрдэм гэх зэрэг жишээгээр яриулж болно.

Үгийн утгыг тайлбарлан ярих

Сонсголгүй хүүхдийн үгийн нөөц баялгийг нэмэгдүүлэх болон тайлбарлан ярих чадварыг сайжруулах зорилгоор багш хүүхдэд заасан үгийн тайлбараа, өөрөөр нь бие даан яриулж тайлбар хийлгэж байх хэрэгтэй. Юун түрүүнд багш үгийн утгыг тайлбарлахдаа дохионы хэлний бүтэц дүрмийн дагуу ярихаас гадна зураг дүрс бүхий үзүүлэн материал ашиглах нь зүйтэй. Үгийн утгыг хэрхэн тайлбарлаж болох, үзүүлэн материал ямар байх талаар авч үзье.

“барих” үгийн утгыг тайлбарлахдаа “юмыг гараараа барих” гэсэн тайлбарт хязгаарлагдахгүй, тухайн үгийн салаа утгыг мөн тайлбарлаж өгнө. Сонсголгүй хүүхэд “барих” үг нь зөвхөн гараар юм барих гэсэн ойлголттой байх нь уншиж, бичих чадварт сөрөг нөлөөлдөг. Багш “барих” үгийн утгыг янз бүрээр илэрхийлж байгаа зурагт үзүүлэн боловсруулж ашиглаж болно. Сонсголгүй хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэхэд онцлогт тохирсон үзүүлэн бөгөөд багш нар өөрсдөө сонсголгүй хүүхдийнхээ онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, тарааж өгөх материал болорвсруулах нь зүйтэй.

Зураг 20. Салаа утгатай үгийг таниулахад ашиглах материал



Үгийн салаа утгыг тайлбарлахаас гадна ижил үг, хэлц үг, ойролцоо утгатай үг, эсрэг утгатай үг зэрэг үгийн утгыг тайлбарлана. Үүний тулд сонсголгүй хүүхдийн хараан дээр суурилсан үзүүлэн, тараах материал, цахим хичээл боловсруулан бэлтгэвэл сайн.

Зураг 21. Эсрэг, ижил, ойролцоо үгийг таниулахад ашиглах материал

Анхаарах зүйл

Багш сурагчийн дохиогоор ярьж байгаа тайлбарыг маш сайн ойлгох хэрэгтэй. Багш өөрийнхөө дохионы хэлний чадварын түвшинд тааруулан сурагчаар яриулж болохгүй. Сурагчдын өөрийнх нь дохионы хэлний чадварын түвшингээр яриулж байх нь зүйтэй.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Сонсголгүй хүүхдийн дохионы хэлээр ярих чадварыг сайжруулахад янз бүрийн сургалтын хэрэглэгдэхүүн ашиглаж болно. Ярих чадварыг сайжруулах суурь хичээлийг сайтар зааж таниулах шаардлагатай. Аливаа зүйлийг маш сайн ойлгосон бол дохионы хэлээр илэрхийлж чадна. Хичээлээ заахдаа хараан дээр суурилсан төрөл бүрийн үзүүлэн, хэрэглэгдэхүүн ашиглаж болно.

Сонсголгүй хүүхэд ярьж байхдаа өөрийгөө хэр ярьж байгааг мэдүүлж ойлгуулахын тулд ярьж байгаа үед бичлэг хийж, дараа нь тухайн хүүхдэд үзүүлж болно. Хүүхэд бичлэгээс өөрийгөө ярьж байгааг харж, юун дээр анхаарахыг ойлгоно. Тиймээс дүрс бичлэг хийж, үзэх боломжтой утас, зөөврийн компьютер ашиглаж болно.

Дэс дарааллаар ярих зүйлийн агуулгыг илэрхийлсэн зурагт үзүүлэн, карт, хэрчмэл үзүүлэн зэрэг хэрэглэгдэхүүн ашиглаж болно. Хүүхэд уг хэрэглэгдэхүүнийг харж ярих зүйлийн дэс дарааг мэдэж авна.

Багш юуг анхаарах вэ?

Сонсголгүй хүүхдийг дохионы хэлээр ярих чадвар эзэмшүүлэхийн тулд багш ярих зүйлийн агуулгыг маш сайн тайлбарлаж өгнө. Багш өөрөө дохионы хэлний өндөр чадвартай байж, сонсголгүй хүүхэдтэй дохиогоор чөлөөтэй харилцдаг байна. Ярих чадварыг сайжруулахад багш хүүхдэд өгөх хичээлийн агуулгаа эмх цэгцтэй, дэс дараалалтай, хоорондоо холбоо хамааралтай өгдөг байна.

Хүүхэд өөртөө итгэхгүй, ярьж чадахгүй тохиолдолд хүчээр яриулахгүй байхад анхаарах ба ярих дадал суутал нь зааж, дэмжиж байх хэрэгтэй. Мөн ярьсан зүйлийн сул талыг эхэлж хэлэхээс өмнө сайн талыг нь эхэлж дурдаад, дараа нь анхаарах зүйлийн талаар зөвлөж хэлэх нь оновчтой.

Хэрхэн үнэлэх вэ?

Сонсголгүй хүүхдийн ярих чадварыг үнэлэхдээ удаан хурдан ярих, зөв буруу ярихыг бус ярьж байгаа зүйлээ ойлгож, хэрхэн илэрхийлж байгааг үнэлнэ. Өөрийгөө илэрхийлэн ярих, дэс дараагаар ярих, асуултад хариулж ярих, тайлбарлан ярих, уран тодоор дохиж ярих зэрэг харилцааны анхан шатны ярих чадварыг хэр эзэмшсэн байгааг үнэлж болно.

3.3 БИЧИХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Ямар чадвар эзэмших вэ?

Хүн анх бичиг үсэг сурч эхлэхдээ л үнэн зөв, алдаагүй, чадварлаг бичиж сурахыг эрмэлзэх нь цаашид бичгийн төдийгүй аман харилцааны чадварт ч нөлөөлдөг. Сонсголтой хүүхдийн хувьд уншиж сайн сураагүй бол сайн бичнэ гэж бараг байхгүй байдаг гэж үздэг бол сонсголгүй хүүхдийн хувьд ч адил байх талтай. Сонсголгүй хүүхдүүд бичихдээ үгийг буруу төгсгөх, дагавар нөхцөлийг оновчгүй хэрэглэх зэргээр дүрмийн алдаа гаргах нь элбэг байдаг. Өгүүлбэрийг зөв бүтэцтэй бичих нь хэлний нэгжүүдийн хоорондын харьцаа, холбоо хамаарлыг ойлгохоос шалтгаалдаг бөгөөд үүний талаар сонсголгүй хүүхдүүд ойлголт дутмаг байдгийг тэдний бичгийн ажил харуулдаг. Тэдний хувьд өгүүлбэрийг зөв бүтээхийн тулд үгс хоорондоо хэрхэн холбогддог талаар тодорхой ойлголттой болох, зөв бүтэцтэй өгүүлбэр бүтээх дасгалыг байнга давтах шаардлагатай. Сонсголгүй хүүхдүүд ихэвчлэн төсөөлөн бодохоосоо илүүтэйгээр мэддэг баримтынхаа талаар бичихийг илүүд үздэг хэмээн зарим судлаач үздэг байна. *Deaf students - Reading and Writing. Deaf Children Australia.*

<http://www.deafchildrenaustralia.org.au/>

<https://www.deafchildrenaustralia.org.au/wp-content/uploads/2021/06/reading-writing.pdf>

Mather, Wendling, Roberts (2009) нарын үзэж байгаагаар авиа зүйн мэдлэг тааруу байх нь дуу авианы дарааллыг тааж олоход саад болж, үгийн зөв бичгийн хэлбэрийг таних, санахад хүндрэл учруулдаг байна. Судлаачдын олонх нь сонсголгүй хүүхдийн унших, бичих чадварын тааруу байдгийг танин мэдэхүйтэй холбон тайлбарладаг бол Berninger (2009) ерөнхийд нь санах ой, ялангуяа бичих явцад ажиллах сэргээн санах үйлийн хооронд мэдэгдэхүйц холбоо байдгийг тайлбарлаад бичгийн бүтээгдэхүүн дэх зөв бичгийн дүрэм, дүрмийн бүтэц, бүтээврийн тухай мэдлэг, мэдээллийг цэгцлэх, бодлоо буулгах зэрэгтэй холбоотой асуудлуудыг авч үзсэн байна. Мөн сонсголгүй хүүхдийн бичих чадвар тааруу байдгийн нэг том шалтгаан бол багш нарын заах аргатай холбоотой талаар судлаач эрдэмтэд дурдсан байдаг. (Bano & Nameed, 2007). Бичгийн чадварт ерөнхийд нь дараах үндсэн хэдэн чадварыг хамааруулж үзнэ. Үүнд:

1. Аливаа дүрс, тэмдэг, үсгийг тигийн дагуу бичих. Уран бичих, хичээнгүй бичих, таталган бичих гэх мэт.
2. Аман мэдээллийг бичгийн мэдээлэл тэмдэг болгон алдаагүй зөв буулгаж бичих
3. Бодол санаагаа бичгээр илэрхийлэх, зохион найруулах ур чадвар
4. Хэл зүй, зөв бичгийн дүрмийг хэрэглэх чадвар

Бичих чадварыг хөгжүүлэх үйлийн зорилго нь бодол санаагаа утга төгөлдөр илэрхийлэх, мэдээлэл дамжуулах, танилцуулах үйлдэл юм. Бичиж сурах анхны алхам нь хуулан бичих, цээжээр бичих зэрэг үйлээр дамжин хөгждөг. Цаашлаад сонины товч мэдээ бичих, захидал, өдрийн тэмдэглэл бичих, үгийн сүлжээ бөглөх зэрэг нь бичгийн чадварыг хөгжүүлэхэд нөлөөлдөг. Тухайлбал: Найздаа захидал бичлээ гэж бодоход, тодорхой үйл явдлын талаар сонирхолтой өгүүлсэн байвал унших хүсэл төрүүлэх нь мэдээж. Суурь бичгийн чадвар сайтай байж гэмээнэ их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах үед лекцийн тэмдэглэл, реферат, өгүүлэл, илтгэл, тайлбар өгүүлэл, оюутны ангийн ажил, оюутны эрдэм шинжилгээний тайлбар, гарын авлага, эсээ гэх мэт төрөл бүрийн бие даах ажлуудыг гүйцэтгэх үед бэрхшээлтэй тулгарах нь бага болно. Сонсголтой хүүхдийн хувьд бичгийн эхийг бүтээхэд өгүүлэх эрхтэн зайлшгүй оролцдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл өгүүлэгч дотоод яриагаараа бичгийн эхийг бүтээдэг байна. Зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй бичихийн тулд өгүүлэгч эхлээд дотоод яриагаараа үгийг хэрхэн бичихээ боловсруулсан байдаг байна. Тэгэхлээр сонсголгүй хүүхэд нь харааны мэдрэхүйгээр

тогтоож, дохионы хэлээр санаандаа оруулж авсан зүйлээ дотроо тунгааж бичгээр илэрхийлнэ гэсэн үг.

1. Үсэг, үе, үг, холбоо үгийг бичүүлж сургах арга

Хамгийн түгээмэл гардаг бэрхшээл бол сонсголгүй хүүхдүүд зөв бүтэцтэй өгүүлбэр бичихэд хүндрэлтэй байдаг байна. Учир нь ярианы хэлэнд өгүүлбэрийн бүтэц зөв байх нь төдийлөн чухал биш байдаг. Жишээ нь: Дохионы хэлээр харилцаж байхад “Сургуулийн хүүхдүүд биеийн тамирын хувцасаа өмсөөд зал руу гүйлдэв.” гэсэн өгүүлбэрийг “Хүүхдүүд сургуулийн биеийн тамирын хувцсаа өмсөөд зал руу гүйлдэв.”, “Биеийн тамирын хувцас өмс, сургуулийн хүүхдүүд, зал руу, гүй.” гэсэншүү маягаар хэд хэдэн хувилбараар илэрхийлж болох бөгөөд дохионы ярианы хэлнээ үүнийг буруу гэхэд хэцүү юм. Тиймээс бичгийн хэлний өгүүлбэр нь дохионы хэлээр харилцаж байгаа “ярианы” хэлнээс өөр байна гэдгийг хүүхдэд анхнаас нь ойлгуулах шаардлага гарна. Салангид үе, үг, холбоо үгийг алдаагүй зөв бичиж сурахтай хамт зөв холбоо үг бүтээж бичихэд анхнаас нь чиглүүлэх шаардлагатай болно. Жишээ нь: Юмсын шинж чанар заасан тэмдэг нэрийг жинхэнэ нэртэй холбож бичих дасгалын олон хувилбарыг туршиж болно. Сонсголгүй хүүхдүүд хурууны үсэг, амны хайрцаг, харааны ойг хослуулан авиа үсгийг тогтоож нүдлэх дасгалыг сонсголтой хүүхдээс илүү олон цагаар нухацтай давтах шаардлагатай болно. Сонсголгүй хүүхдийн хувьд уншихдаа ямар бүтээврийг зөв уншсан бэ? гэдгийг багш мэдэх нь нэлээд бэрхшээлтэй асуудал юм. Жишээ нь: “Голын урсгал” гэдэг холбоо үгийг “Голыг урсгал” “Голоос урсгал” гэж уншсан уу аль эсвэл “Гол урсгал” гэж уншсан уу? гэдгийг багш анхан суралцах үеэс дохионы хэлний арга зүйгээр таньж мэдэж, алдааг засаж залруулж явахад анхаарах нь юунаас ч чухал. Сурагчид зөв уншиж байж, бичихдээ зөв бичиж сурна. Тэгэхлээр үсэг, үе, үгийг зөв бичиж сурах нь зөв уншиж сурсан эсэхтэй шууд холбоотой юм.

Үүнд сургахад багш нараас нэг хувилбартай олон янзын холбоо үг, өгүүлбэр дээр заах аргын сонирхолтой арга шийдлийг сонгож хичээлийн үйл ажиллагаагаа төлөвлөх шаардлага гарна гэсэн үг. Тухайлбал, холбоо үгийн олон янзын хувилбарыг таниулах шаардлагатай болно.

- Өндөр уул
- Маш өндөр уул
- Хадтай уул
- Хад ихтэй уул
- Модгүй уул
- Модтой уул
- Ууланд авирах
- Ууланд гарах
- Уулын орой
- Уулын оройд гарах
- Уулын оройд гарах сайхан.
- Уулын оройд гарах хэцүү санагддаг гэх мэтээр холбоо үгийн олон хувилбараас гадна богино өгүүлбэрийн олон хувилбарыг таниулах дасгалыг төрөл бүрийн үзүүлэн тарааж өгөх материалын тусламжтайгаар хийх шаардлага гарна. Ийм үед зурган үзүүлэн, ТӨМ материалыг олон янзын хувилбараар бэлтгэх шаардлагатай. 1, 2 дугаар ангийн хүүхдүүдэд маш энгийн хялбар дасгалаар дамжуулна. Жишээ нь:
- Миний ном

- Дүүгийн ном
- Ахын ном
- Эгчийн ном
- Ном унших
- Ном харах
- Ном нээх
- Зузаан ном
- Нимгэн ном
- Том ном

Жижиг ном гэх мэт ямар нэгэн үгийг бичих дасгал хийхдээ салангид үгээр биш, холбоо үгээр түүнийгээ алхам алхмаар дэлгэрүүлж бичих дасгал хийнэ. Тухайлбал: “Миний ном”, “Ширээн дээр байх”, “Монгол хэлний ном”, “Ном унших”, “Миний дүү унших” гэх мэтээр холбоо үгийг зөв үүсгэх дасгал хийж, түүгээрээ өгүүлбэр бүтээх дасгалыг дадал чадвар болтол хийх хэрэгтэй юм. Харин нэг хоёр хичээл дээр, ганц нэг удаа ийм маягаар хийгээд орхивол дадал болж үлдэхгүй удахгүй мартагддагийг анхаарах нь зүйтэй. “Үүний тулд үгийг хэрхэн холбох аргыг хэл зүйг заах аргаас сайтар судлаарай. Сурагчид “Миний ном” гэсэн холбоо үг байхаас биш “Ном миний” гэдэг холбоо үг бичиж болохгүйг сайтар ойлгож авах хэрэгтэй юм. Хүүхдүүдийг залхаахгүй, аль болох тэдний сонирхол дээр тулгуурлахын тулд багш төрөл бүрийн хэрэглэгдэхүүн, сургалтын арга ашиглах шаардлага гарна. Тухайлбал: Зургаас үг бичих. Багш хүүхдүүдэд хүүхэлдэй, сандал, халбага, бөмбөг, хувцасны шүүгээ, машин, шоо, цүнх, муур, нохой, тахиа, үхэр, таваг, сэрээ, тогоо, харандаа, пирамид, сойз, будаг зэргийг үзүүлнэ. Эдгээрийг хэрхэн нэрлэж бичих вэ? Эдгээрийг өөр хооронд нь холбож холбоо үг бүтээвэл яах вэ? Холбоо үгээ яаж өгүүлбэр болгох вэ? гэх мэт асуудал шийдэж болно. Хүүхдүүд дэвтэр дээрээ үгсийг аль болох сайхан, зөв, алдаагүй дахин бичиж сурах нь чухал. Мөн түүнчлэн төрөл бүрийн ойролцоо утгатай үгсийн утгыг ойлгож хэрэглэж дасгалыг олон удаагийн давтамжтайгаар хийх нь чухал юм. Энэ нь сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэх сайн талтай.

Өгүүлбэр бичүүлж сургах арга

Өгүүлбэрийг зөв найруулгатай бичиж сурахад хураангуй өгүүлбэрийг дэлгэрэнгүй болгох, холбоо үгийг дэлгэрэнгүй өгүүлбэр болгож хувиргах, энгийн өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэр болгож хувиргах төрөл бүрийн бүтээлч дасгал хийлгэх нь үр дүнтэй юм. Багш хичээлдээ аль болох олон янзын бүтээлч аргыг хэрэглэж сурах нь чухал.

Ямар аргаар бичихэд, ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

I. Өгүүлбэрийг холбон найруулж нийлмэл өгүүлбэр бүтээх

1. Хавар болно.
2. Байрны гадаа цэцэг ногоо ургана.
3. Хүүхдүүд шуугилдана. гэсэн өгүүлбэрийг холбон найруулж нийлмэл болговол “Хавар болохоор, байрны гадаа цэцэг ногоо ургаж, хүүхдүүд шуугилдана.”
 1. 1 сарын дараа шинэ жилийн баяр болно.
 2. 1 сарын дараа манай хичээл дуусна.
 3. Өвлийн амралт эхэлнэ. гэсэн өгүүлбэрийг холбон найруулж нийлмэл болговол “1 сарын дараа шинэ жилийн баяр болохоор өвлийн амралт эхэлнэ.” гэх мэтээр холбож зөв бүтэцтэй, зөв найруулгатай өгүүлбэр бүтээж сурах төрөл бүрийн дасгал хийж болох юм. Үүнийг багш хэрчмэл үзүүлэн, картын хэлбэрээр бэлтгээд сурагчид

хамтран эвлүүлэх гэх мэтээр багаар ажиллуулж болно. Дараах өгүүлбэрүүдийн жишээгээр хичээлээ баяжуулж болно. Тухайлбал:

1. Хаврын үдэш болно.
 2. Багачууд хүүхдүүд байрны гадаа тоглоно. (Бүтээх өгүүлбэр нь: Хаврын үдэш болж, багачууд хүүхдүүд байрны гадаа тоглоно.)
-
1. Өвөл болно.
 2. Ой мод цасаар бүрхэгдэнэ.
 3. Цасан цагаан ойд цэнгэг агаар дүүрнэ. (Бүтээх өгүүлбэр нь: Өвөл болж, ой мод цасаар бүрхэгдэхэд цасан цагаан ойд цэнгэг агаар дүүрнэ.)
-
1. Намар болно.
 2. Намар сургууль цуглана.
 4. Намар бид тариа ногоогоо хураахаар хөдөө явна. (Бүтээх өгүүлбэр нь: Намар болж сургууль цуглахад, бид тариа ногоогоо хураахаар хөдөө явна.)
-
1. Би өчигдөр кино үзсэн.
 2. Тэр кино маш гоё кино байсан
 5. Тэр кинонд эх хүний үрээ хайрлах сэтгэлийг өгүүлсэн. (Бүтээх өгүүлбэр нь: Миний өчигдөр үзсэн кино маш гоё байсан. Тэр кинонд эх хүний үрээ хайрлах сэтгэлийг өгүүлсэн.)
-
1. Би 7 хоногийн өмнө маш гоё ном уншсан.
 2. Тэр ном маш сонирхолтой.
 3. Тэр номон дээр адал явдал гардаг. (Бүтээх өгүүлбэр нь: 7 хоногийн өмнө миний уншсан ном маш сонирхолтой байсан. Яагаад гэвэл тэр ном адал явдалтай.) гэх мэтээр хүүхдэд багаас их рүү, хөнгөнөөс хүнд рүү бага багаар ахиулах төрөл бүрийн дасгалыг сонирхолтой хэлбэрээр олон удаагийн давтамжаар хийлгэж болно. Иймэрхүү дасгалыг эвлүүлэх аргаар хийлгэвэл хүүхэд залхахгүй байх талтай.

II. Өгүүлбэрт дэлгэрүүлэх хувиргал хийх арга

Дараах байдлаар өгүүлбэр дэлгэрүүлэхэд сурагчид алхам алхмаар үгсийг нэмж, хувиргаж сурах дадлагатай болно. Багш дэлгэрүүлэх үгсийг дараах хүснэгтийн аргаар өгөхөөс гадна үгс бүрийг тараах материалаар бэлтгэж эвлүүлэх аргыг ашиглаж болно. Тараах материалаар бэлтгэвэл сурагчид хамтран хийхэд илүү боломжтой болох юм. **“Бөмбөгийг тоглож байна”** гэвэл буруу **“Бөмбөгөөр тоглож байна.”** гэвэл зөв. **“Хашаанд тоглож байна.”** гэвэл зөв **“Хашаа тоглож байна”** гэвэл гэх мэт холбоо үгсийг зөв хэлбэршүүлэн бичиж сурахаас гадна эдгээр нь өгүүлбэрт орохдоо алхам алхмаар дэлгэрэн холбогддогийг ойлгуулах шаардлагатай. Дараах асуултад товч хариулахаас гадна дэлгэрүүлэх хувиргал хийж бичих ажлыг тогтмол хийх шаардлагатай байдаг.

1. Хүүхэд юу хийж байна вэ?
2. Хүүхэд тоглож байна.
3. Хүүхэд БӨМБӨГӨӨР тоглож байна.
4. Хүүхэд ТОМ бөмбөгөөр тоглож байна.
5. Хүүхэд том бөмбөгөөр ХАШААНД тоглож байна.
6. Хүүхэд том бөмбөгөөр МАНАЙ хашаанд тоглож байна.
7. ХОЁР хүүхэд том бөмбөгөөр манай хашаанд тоглож байна.

8. Хоёр ЖААХАН ЭРЭГТЭЙ хүүхэд том бөмбөгөөр манай хашаанд тоглож байна.
 9. бөмбөг – өөр - бөмбөгөөр, хашаа – д – хашаанд, хэний? – манай, миний

Хүснэгт 10. Өгүүлбэр дэлгэрүүлэх ажлын хуудас

Хэдэн?	Ямар ?	Ямар?	Хэн?	Ямар?	Юугаар?	Хэний?	Хаана?	Яаж байна?
Хоёр	жаахан	эрэгтэй	хүүхэд	том	Бөм- бөгөөр	манай	хашаанд	тоглож байна.
.....	оюутан
.....	хүн
.....	жолооч
.....	багш
.....	эгч
.....	охин
.....	дуучин
.....	жүжигчин
.....	хөгжимчин
.....	зураач
.....	орчуулагч
.....	жуулчин

III. Дунд болон ахлах ангийн сурагчдад нийлмэл өгүүлбэрийг холбон найруулах чадвар олгохын тулд тулгуур дохио, загвар ашиглах. Аль болох нэг ижил хэлбэрийг олон дахин давтаж танил дасал болж дадлагажсаны дараа багш дараагийн хэлбэрт шилжвэл үр дүнтэй. Тухайлбал:

- аас ⁴ ирсэн, авчирсан (..... өгсөн, харсан) **ЫГ** **сан⁴**.
- аас ⁴ ирсэн, авчирсан (..... өгсөн, харсан) **тэр** **сан⁴** гэх мэт

Үлгэрлэвэл: - 1. Надад “Миний ардын мянган сонин” ном бий. 2. Тэр номыг надад багш маань өгсөн. 3. Тэр номыг би найздаа өгсөн. (Бүтээх өгүүлбэр нь: **Багшийнхаа өгсөн “Миний ардын мянган сонин” номыг би найздаа өгсөн.**)

- 1. Надад биеийн тамирын хувцас бий. 2. Энэ хувцсыг Солонгосоос авчирсан. 3. Энэ хувцсыг би дүүдээ бэлэглэсэн. (Бүтээх өгүүлбэр нь: **Солонгосоос авчирсан биеийн тамирын хувцсаа би дүүдээ өгсөн.**)

Дасгал даалгаврын дараах жишээг ашиглаж болно.

1. Шүдний оо Оросоос авчирсан.
2. Тэр оог дүү маань авчирч өгсөн.
3. Энэ оогоор би өглөө бүр шүдээ угаадаг.

1. Монгол хэлний номыг багш маань өгсөн.
2. Энэ номыг би байнга хэрэглэдэг.
3. Энэ номыг би найздаа бэлэглэсэн.

1. Энэ сониныг өчигдөр уншсан.
2. Энэ сонины нэр “Өдрийн сонин”
3. Энэ сонин дээр эрүүл мэндийн тухай өгүүлэл гарсан байна.

1. Би “Хөх нуур” гэдэг үлгэрийн сайхан газар очсон.
2. Тэр газар олон сайхан зүйл байдаг.
3. Тэр газар Завхан аймагт байдаг.

1. Онгоц Японоос ирсэн.
2. Онгоц 8 цагт буусан.
3. Тэр онгоцоор миний ээж ирсэн.

1. Миний дүү надад төрсөн өдрийн бэлэг өгсөн.
2. Миний дүү тэр бэлгийг Их дэлгүүрээс авсан.

1. Утаа айл айлын яндангаас гарсан.
2. Утаа хотын агаарыг бохирдуулж байна.

IV. Видео бичлэг, зураг хараад өгүүлбэр зохиож бичих

Сонсголгүй хүүхдийн хувьд ихэнх зүйлийг харааны ойд тулгуурлан хүлээж авах тул. Багш төрөл бүрийн өнгөт зураг, видео бичлэгийг ашиглавал үр дүнтэй. Гэхдээ дурын ямар ч хамаагүй зураг, бичлэг ашиглаж болохгүйг анхаараарай. Жишээ нь:

Зураг 22. Өгүүлбэр зохион бичүүлэх үзүүлэн

- Ягаан цамцтай эмэгтэйн хажууд цэнхэр цамцтай хүн сууж байна.
- Цэнхэр пиджактай залуу уурлаж байна.
- Ягаан палаажтай эгчийн хажууд зогсож байгаа цэнхэр пиджактай залуу маш их уурлаж **байх шиг байна.**
- Гараа өргөөд, **хашгираад байх шиг байна.**
- Цаана нь байгаа залуу их **гайхаж байна.**
- Ер нь бусад хүмүүс их гайхаж байна.
- Улаан цамцтай эмэгтэй нүдний шилтэй байна. гэх мэт “байх шиг байна.” гэдэг үгийг ямар үед хэрэглэхийг нэмэлтээр тайлбарлана. Дахин өөрчлөн хэрэглэх дасгал хийнэ.



V. Өгүүлбэрт сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлж бичих

Сонсголгүй хүүхдийн хувьд сэтгэгдэл, үзэл бодлоо хэрхэн илэрхийлж бичих аргыг сонсголттой хүүхэд шиг ойлгож, эзэмших нь нэлээд бэрхшээлтэй болно. Тухайлбал: **Бодогдоно, санагдана, мэдрэгдэнэ** гэх мэт үгийн утгын ялгааг хэрхэн ойлгох вэ? Багш нар төрөл бүрийн өгүүлбэрт нэг янзын мэдрэмж илэрхийлсэн үгсийг олон хувилбараар хэрэглэж ялгааг сайтар ойлгуулах шаардлагатай юм. Тухайлбал: Харилцан яриа зохиож бичиж болох юм.

- Өвөл чамд ямар **санагддаг** вэ?
- Өвөл хүйтэн учраас надад **таагүй санагддаг.**
- Намар чамд ямар **санагддаг** вэ?
- Намар хичээл эхэлдэг болохоор надад **сайхан санагддаг.**

- Ууланд авирах чамд ямар **санагддаг** вэ?
- Уул өндөр тул надад хэцүү **санагддаг**.
- Эрдэм номыг сурах нь ууланд авирахтай адил **санагддаг**. гэх мэтээр “санагддаг” гэдэг үйл үг оролцуулан маш олон өгүүлбэр бичих дасгал хийж болно. Энэ удаад хүүхдүүд “санагддаг” гэсэн үгийг өгүүлбэрт хаана яаж хэрэглэдгийн учрыг олох нь чухал байна. Сонсголгүй хүүхдийн хувьд нэг ижил зүйлийг харааны ойгоор дахин давтан ажиглан харж тогтоох үйл давамгайлах тул багш нар аль болох нэг төрлийн, ижил бүтэц хэлбэртэй өгүүлбэрийг дахин давтан нүдлүүлэх дасгалыг уйгагүй хийх шаардлагатай болно. Гэхдээ хүүхдийг залхаахгүй ТӨМ, үзүүлэн, видео гэх мэт төрөл бүрийн хэрэглэгдэхүүнийг ашиглах нь үр дүнтэй арга болно.

Эх зохион бичиж сурахад багш юуг анхаарах вэ?

Зохион бичих чадвар олгох хичээл нь

1. Төлөвлөх чадвар

2. Бичих чадвар

3. **Хянах чадвар** гэсэн үндсэн гурван үе шаттай байвал үр дүнтэй. Заах арга барил сайтай багш нар бичих чадварыг шат дараатай эзэмшүүлж, бичих аргыг зааж өгөхөд анхаарлаа хандуулдаг. Тухайлбал: Хүүрнэн бичсэн, тайлбарлан бичсэн, эргэцүүлэн бичсэн зэрэг төрөл бүрийн хэв маягаар бичсэн эхийн оновчтой жишээ загваруудыг хичээлдээ ашиглах, төрөл бүрийн эхийн санг тарааж өгөх материалаар бэлтгэх. Сурагчдын бичсэн бичвэрийг цаг алдалгүй үзэж, цаг тухайд нь дэмжлэг үзүүлж, тэдний бүтээлийг шударгаар үнэлж, жишээ баримттайгаар урам зориг хайрласан санал сэтгэгдэл бичиж өгөх зэргээр дэмжин тусалдаг.

Сурагчдад өдөр тутамдаа бичих даалгавар өгөхдөө хэт урт хэмжээтэй бус, богино хэмжээний бичвэр бичих даалгавар өгөх нь залхаахгүй сайн талтай. Алдартай зохиолчдын бүтээлээс жишээ авч тайлбарлахад ашиглаж болох ч тэдний бүтээлтэй адил бичвэр бичих даалгавар нь сурагчдад хүндэддэг. Учир нь зохиолчдын үгийн сан, өгүүлбэрийн найруулга мэргэжлийн түвшний хүнд найруулгатай, зарим үг хэллэг нь гадаад хэл судалж буй мэт сэтгэгдэл төрүүлэх талтайг багш нар анхаарна. Гадаад хэлийг өдөр бүрийн байнгын тасралтгүй хичээл зүтгэлийн хүчээр сайн сурдагтай адил сайн бичдэг болохын тулд өдөр бүрийн тасралтгүй оролдлогыг эрхэм болговол үр дүнд хүрнэ. Багш өдөр бүр богино хэмжээний бичих даалгавар өгөхдөө аль болох сонирхолтой эрэлт хэрэгцээтэй хувилбарыг сонгох нь тохиромжтой юм. Тухайлбал: Ямар нэг зүйлийг шинээр сурсан туршлагынхаа тухай тэмдэглэл хөтлөх, ангийнхантайгаа э – мэйлээр харилцах, мөрөөдлөө хэрхэн биелүүлэх тухайгаа бичих, гэр бүлийнхнийхээ түүхийг зураг, бичвэр хослуулан бүтээх, ахлах ангийн сурагчдын хувьд нэмэлт даалгавраа бичгийн ажлаар гүйцэтгэх зэрэг байж болно. Намтар бичих даалгавар гүйцэтгэхийн өмнө сурагчдаар сонирхсон хүмүүсийнх нь намтрыг цуврал байдлаар уншуулж танилцуулна. Уншсан намтрынхаа талаар ангидаа ярилцаж болно. Үүний дараа өөрсдийн намтраа бичиж ангийнхандаа дохионы хэлээр, сэтгэл хөдлөлтэй уншиж өгөх боломж бүрдүүлнэ.

Өдөр бүрийн тасралтгүй бичих чадварыг хөгжүүлэх жижиг даалгаврууд нь өдөр өдрийн ахицаар хэмжигдэж байвал сурагчдад тэр хэмжээгээрээ бичих урмыг төрүүлнэ. Бичих чадварынхаа ахицыг графикаар тэмдэглэж, үр дүнг анги хамт олноороо хэлэлцэж болно. Энэ нь сурагчид өдөр тутмынхаа үйл ажиллагааг хянаж сурахад нөлөөтэй. Сонсголгүй хүүхдийн зохион бичих чадварыг хөгжүүлэхэд түгээмэл ашигладаг POSTER аргыг ашиглаж болно. Энэ нь бичихийн өмнөх бэлтгэл ажлыг хийснээрээ илүү үр дүнтэй

арга байж болно. POSTER нь бичихийн танин мэдэхүйн стратегийн зааварчилгаа (CSIW) сургалтын хөтөлбөрөөс (Englert, Raphael, Anderson, 1989) авсан POWER товчлолын өөр нэг хувилбар юм. Үүнийг ашиглах үед сурагчид бүтээх, хянах, засварлах ажлыг гүйцэтгэдэг.

Plan - төлөвлөх

Organize - цэгцлэх




Scribe – бичиж эхлэх


Translate – дохионы хэлнээс бичгийн хэл рүү буулгах

Edit - засварлах

Revise – эцэслэх

Хүснэгт 11. POSTER аргын тайлбар

<p>Planning:</p> 	<p>Төлөвлөлтийн явцад тухайн сэдвийн талаар мэддэг зүйлсээ болон бичих зорилгыг тодорхойлох ба уншигч нь хэн бэ гэдгийг харгалзан үзнэ. Хэрэв нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол, ямар мэдээлэл хэрэгтэй вэ?, Хэрхэн олж авах вэ? гэдгийг төлөвлөнө.</p>
<p>Organize:</p> 	<p>Сурагчид өөрсдийн санаагаа бичихэд зориулж дараалалд оруулна.</p>
<p>Scribe:</p> 	<p>Төлөвлөгөө, зураглалынхаа дагуу санаагаа өргөжүүлэх, боловсруулах замаар эх бүтээхэд шилжүүлнэ.</p>
<p>Translate:</p> 	<p>Санаагаа бичгийн болон дохионы хэлний алинаар, эсвэл холимог хэлээр гаргасан эсэхийг дахин тодруулж, дохионы хэлээр бэлдсэн бол бичгийн хэл рүү орчуулна. Хар ярианы үг орсон эсэх, үгсийн байрлал буруу болсон эсэхэд анхаарна.</p>
 <p>Edit:</p>	<p>Бичсэн эхээ дахин уншиж, тодруулах шаардлагатай санаанууд болон дүрмийн алдааг засварлах шаардлагатай байгаа эсэхийг хянана.</p>

Revise:		Эцсийн байдлаар бичиж, хянана.
---------	---	--------------------------------

Сурагчдад бичихийн өмнө бэлтгэл үе шатанд зохих хугацааг зарцуулах боломжийг бүрдүүлж, тодорхой даалгавраар энэхүү үйлийг хөтөлж хэрэгжүүлнэ. Тухайлбал: Өдрийн тэмдэглэлээ хэдэн үгэнд багтааж бичиж байгаа, өсөлт байгаа эсэх. Хувийн чадвар нь хэр зэрэг өсөж буйг тэмдэглэлийн дэвтэртээ оноогоор тэмдэглэж, өсөлтөө цаг хугацаатай нь харьцуулж графикаар илэрхийлэх даалгавар өгч хэрэгжүүлж болно. Энэ нь давхар суралцагчийн өөрийн үнэлгээний хэлбэр болох юм. Дараа нь бүх сурагчдын өсөлтийн явцаа тэмдэглэсэн тэмдэглэлүүдийг цуглуулж оноог тооцоолж болно. Долоо хоног бүрийн эхэнд тухайн долоо хоногт өмнөх долоо хоногийн бичсэн бичвэрийн үгийн тоог хэдээр ахиулах гэх мэт зорилтоо тодорхойлж болно.

Үйл явдлын дарааллыг бичих. *Үйл явдлын дарааллыг бичиж сурахад үйл үгийн холбох ба төгсгөх нөхцөлүүдийг зөв хэрэглэж сурах чадвар чухал. Зургийн үйл явдлыг хараад хүүхэд сэтгэл хөдлөлөө илэрхийлэн ярьж болох боловч үгсийн төгсгөл ямар байгаа вэ? гэдэгт багш хяналт тавих боломжгүй байдаг. Харин эх зохион бичихэд дохионы хэлнээс бичгийн хэл рүү хэрхэн буулгах ажилд нэлээд анхаарах шаардлагатай болно. Ямар нэг үйл явдал, зураг хөрөгтэй эх дээр ажиллах нь илүү үр дүнтэй болно. Жишээ нь: Нэгэн хүү дүүрэн торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ. (Д.Давааням “Торх”) эхийг зургийн үйл явдлаар харуулбал илүү сонирхолтой болно. Багш нар сурагчдын бичвэрийг үнэлэх аргыг аль болох олон янзын аргыг ашиглавал үр дүнтэй. Ёшинага-Итано, Синдер (1985) нар сонсголгүй хүүхдүүдийн бичвэрийг үнэлэх таван онооны шалгуурыг санал болгосон.*

1. Найруулгад ашигласан өгүүлбэр, үгийн тоо
2. Өгүүлбэр зүй
3. Найруулгын алдаа, төрөл
4. Ярианы үг хэллэг хэрэглэсэн тоо
5. Дүрмийн хувиргал

Bulletin of Education and Research April 2019, Vol. 41, No. 1 pp. 1-16 Writing Skills Development among Students with Deafness at Elementary Level Munawar Malik and Naseer ud Din*** SIWI (Strategic and Interactive Writing Instruction) нь сонсголгүй хүүхдүүдийн хэрэгцээнд нийцүүлэн бичих зааварчилгааны арга юм.

<https://centerondeafness.utk.edu/strategic-interactive-writing-instruction/#:~:text=SIWI%20is%20an%20approach%20to,writing%20and%20collaborative%2C%20interactive%20writing>

Зөв бичүүлж сургах арга зүй

Ямар чадвар эзэмших вэ?

Зөв бичих дүрмийн дагуу алдаагүй бичиж сурах нь сурагчдын эзэмшвэл зохих чадваруудын нэг юм. Тиймээс анхлан бичиг үсэг тайлагдах үеэс бичгийн энэ чадварыг анхаарна. Анхан суралцах үеэс энэ чадварт төдийлөн анхаараагүйгээс сурагчид насан туршдаа алдаатай бичдэг болох талтай байдгийг анхаарах шаардлагатай юм. Зөв бичих чадвар нь нэг үйлийг олон дахин давтсаны үрээр суралцагчид тогтож бий болсон олдмол рефлекс (техник чадвар) гэж үзэж болно. Заах аргын хувьд тухайн хувь багшийн өөрийн нь хичээл зүтгэл, бичиг үсэгт сурах үед хүүхдэд тохиолддог сэтгэл зүйн бэрхшээл, хялбар тогтоолгох олон янзын аргыг мэдэж тооцоолж байгаа байдал нөлөөлөхөөс гадна багш нар заах аргыг оновчтой хослуулан хэрэглэдгээрээ ялгардаг. Зарим хүүхэд хийсвэр томъёоллыг харуулах, тайлбарлах төдийд шууд тусган хүлээж авч ойлгодог бол зарим хүүхэд зураг хөрөг, бодит амьдралын жишээн дээр тулгуурлан хялбар аргаар тайлбарлахад, зарим хүүхэд тоглоом наадам, хошин шог, хөдөлгөөнт үзүүлэн гэх мэт хөгжилтэй аргаар заахад илүү ойлгож тогтоож хүлээж авдгаараа л ялгардаг. Нэг ангид ийм оюуны чадавхын хувьд олон янз байдгийг тооцож багш өөрийнхөө заах аргыг янз бүрээр өөрчилж шинэчилж байх шаардлагатай байдаг. Багш хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, мэдлэгийг өөрөөр нь бүтээлгэх үйлийг зөв аргаар удирдан чиглүүлдэг байх шаардлагатай юм. Зөв бичих дүрмийг тайлбарлахдаа, хамгийн хялбар энгийн аргаар аль болох үгсийг давтан бичиж тогтоох чадвар дээр тулгуурлан ойлгуулж, хэрэглэх чадварт сургавал үр дүнтэй.

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Алдаагүй зөв бичиж сурах чадвар нь үсгийн цагаан толгойг тогтоож нүдлэх, үеэр зөв холбож уншихаас эхэлнэ. Зөв бичиж сурах олон арга байна. Сонсголгүй хүүхдэд ихэвчлэн харааны ойд тулгуурлан нүдлэн тогтоох зарчмыг баримтална. Зөв бичгийн дүрмийг хэт хүндрүүлж, хүүхдүүдийг дургүй болгохоос зайлсхийх нь багшийн арга зүйтэй холбоотой. Нэг ижил хэлбэртэй бүтээвэр, үгийг давтаж бичих замаар адил талыг ажиглан тогтоох үйлд тулгуурлах нь үр дүнтэй. Жишээлбэл: унш + лага, бод + лого, сур + лага, турш + лага, зар + лага, ор + лого, найд + лага, дууд + лага, хаш + лага эсвэл бод + л, мэд + л, төр + л, үүс + л, гар + л, хур + л гэх мэтээр адил хэлбэртэй төрөл бүрийн залгаврыг залган бичих, залган эвлүүлэх тоглоомын арга гэх мэтээр хүүхдэд аль болох сонирхолтой хялбар аргыг сонгох шаардлагатай. Цээжээр бичүүлж сургах олон арга байна.

Нүдлэх цээж бичиг: Багш самбарт 2 – 3 үгээр, эсхүл бүтэн өгүүлбэрийг бичээд богино хугацаанд ажиглуулна. Сурагчид ажиглаж тогтоосны дараа самбарыг арчаад, бичүүлнэ. Аль эсвэл багш дохионы хэлээр хэлж бичүүлнэ. Мөн сурагчид өөрсдөө тогтоож авснаараа бичнэ. Мөн анги танхимын хананд нүдлэн тогтоох үгсийг томоор бичиж байрлуулах, үгсийг утгаар бүлэглэж тогтоолгох гэх мэт олон арга байж болно. Бүлэглэхдээ утгаар бүлэглэж болно. Жишээ нь: Хүний эрхтэн: Толгой, нүүр, хацар, чих, нүд, ам, хамар; Байгалийн юм үзэгдэл – нар, сар, бороо, манан, үүл гэх мэт. Олон дахин давтан нүдэлж бичих, үгсийг төрөлжүүлж бүлэглэж нүдлэх. Тухайлбал: Таван хошуу малын нэр, од гариг эрхсийн нэр, гал тогооны эдлэл хэрэглэлийн нэр гэх мэтээр төрөлжүүлж бүлэглэн нүдлүүлж болно.

Бие даан цээжилсэн шүлэг, зохиолыг цээжээр бичих: Сурагчид цээжилсэн шүлэг, зүйр үг, эсвэл богино хэмжээний үргэлжилсэн үгийн эхийг цээжлээд, түүнийгээ цээжээр бичих. Багш дохионы хэлээр дуудаж өгөхгүй. Нэлээд сайн сурсны дараа багш тодорхой хугацаа зааж, заасан хугацаанд цээжээр бичиж болно. Жишээлбэл: Д.Нацагдоржийн “Хэнз хурга” шүлгийг цээжилснээ 10 минутад багтааж бичээрэй гэх мэт. Энэ нь эхийг

цээжилж тогтоохоос гадна ямар үгийг яаж бичсэнийг давхар шалгаж, сурагчид өөрийгөө хянахад ч давуу талтай болно.


Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

“Га – га – га дуугараад галуу усанд шумбадаг. Гүг – гүүг, гүг – гүүг гэж хөхөө донгоддог. Гуруй, гуруй, гүүргий гүүргий, сөг сөг, тойг тойг... Армаг тармаг ойн чөлөөгөөр булаг хоржигноно.” Энэ мэт г үсэг янз бүрээр орсон үзүүлэн бэлтгэж уншуулах явцад г – г харагдах, хэлэгдэх байдлаар ялган тайлбарлана. Хамгийн гол нь г нь ардаа эгшигтэй, ардаа эгшиггүй хоёр тохиолдол буй ялгааг сайтар ойлгуулна. Багш самбарт 4 үе үг бичихийн хамт сурагчдаар нүдлүүлнэ, хуулуулна. Тухайлбал: арга – араг, эрэг – эргэ, барга – бараг, үнэг – үнгэ, бага – баг, өрөг – өргө, тарга – тараг, өнцөг – хөнгөн, торго – торог, тогос – тогтог гэх мэт бичүүлсний эцэст 1 дүгээр үеийн г хэлний хоолойн гүн угаар хэлэгддэг. 2, 3, 4 дүгээр үеийн г хэлний гүн биш угаар хэлэгддэг гэдгийг хүний хоолой төвөнхийн эрхтний зураг дээр тайлбарлаж харуулна. Видео бичлэг үзүүлбэл илүү үр дүнтэй болох юм.

Хэлний гүн үгийн г нь а, о, у эгшигтэй байна. Э, и, ө, ү эгшигтэй буюу эгшиггүй г нь хэлний гүн биш угаар хэлэгдэж байна. гэдгийг онцлон тодорхойлно. Н, г үсгүүд элбэг орсон сэдвээс ялгах эгшигийг олуулах дасгал хийнэ. Жишээ нь: “Аргал хоргол түлнэ. Хийнэ гээд хэд хонож болохгүй.” “Г + а, о, у Н + а, о, у, и, ө, э, ү, ь” Ийм бүдүүвч, өгүүлбэр бүхий үзүүлэн таниулах дээр ялгах эгшигийн ойлголтыг бататгана.

1. Энэхүү ялгах эгшигийг орхиж бичих буюу гэж бичиж болохгүй гэдгийг сануулж анхааруулах цээж бичиг хийж дүгнэх.
2. Сонгож авсан сэдвийг уншиж, ялгах эгшигтэй үгийг түүвэрлэх дасгал ажиллуулна.
3. Н, г ба ялгах эгшиг орсон хяналтын цээж бичиг хийхэд бэлтгэж н, г ба ялгах эгшигтэй үгс бүлэглэх. Ийм үгсийн зургийг төрөлжүүлэн цуглуулах. Жишээлбэл: аньс, балчиргана, гүзээлзгэнэ, чацаргана, бөөрөлзгөнө, тошлог, үхрийн нүд, харгана, улаалзгана. Дараах хэрэглэгдэхүүнийг өнгөөр ялгаж, тодоор бичиж хүүхдийн нүдэнд ил харагдах газарт байрлуулж болно. Мөн тараах материал бэлтгэж болно. Дүрмийг тулгуур дохионы аргаар зураг дүрсээр баяжуулан хялбар ойлгохуйцаар бэлтгэнэ. Жишээлбэл:

Загвар 3. Кирилл үсгийн зөв бичихийн ангилал




Д/д	Хэлбэр	Жишээ
1	Э:	э + зэн, о + рон, а + шиг, а + тар
2	Э + Г:	оч, он, ав, ир
3	Г + Э:	са + на, тоо, хий, бай, ха + лаа
4	Г + Э + Г:	гал, сар + лаг, дэв + тэр
5	Э + Г + Г:	улс, өвс, авч, өвч
6	Г + Э + Г + Г:	хувьс + гал, төгс + гөл, давт, давс, барьц
7	Э + Г + Г + Г:	элст, өвст, хөрст, давст
8	Г + Э + Г + Г + Г:	төрөлхтөн

Хүснэгт 13. Эгшиг зохицох ёс

Үгийн нэгдүгээр үед байх эгшиг	Хойшид тохиолдох эгшгүүд		
	Богино эгшиг	Урт эгшиг	Хос эгшиг
а, аа, ай, у, уу, уй, я, яа, яй, ю (у), юу	а, я	аа, яа, юу, уу, яу, ы, ий	ай, уй
о, оо, ой, ё, ёо	о, ё	оо, ёо, уу, юу, ы, ий	ой
ө, өө, е	ө, е	өө, еэ, үү, ий	эй, үй
э, ээ, и, ий, ү, үү, ү, еэ, юү, ю	э, е	ээ, еэ, үү, ий	эй, үй

Жишээ нь: асрах, хаалга, тооно, сувилах, хуурайлах, унь, хана, дээвэр, түших, тарих, өргөх, цаваг, эмчлэх, бүслүүр, уулгах, ширдэг, хаяавч, хооллох, ундлах, хэвтүүлэх, шалавч, дэвсгэр, оосор, уяа, эргэх, хошлон, өрх, тайвшруулах, зөвлөх, хатавч, яндан, боох гэх мэт

Загвар 4. Эгшигийн ангилал



Гээгдэх эгшгийн 4 тохиолдол

- I. а в г а + а а р
- II. б у д а г + и й н
- III. а р а в + н
- IV. б и ч и г + и й г

Балархай эгшиг

(I үеэс хойш орсон богино эгшиг)

Жишээ нь:

ц э ц э г

Гээгдэхгүй эгшгийн 7 тохиолдол

- I. з ү т г э л + ээр
- II. г э э г д э х + ийг
- III. т у г а л + аар
- IV. ү н э г + ийг
- V. ү з э г д э н э + ээ
- VI. ц э д э в + ийн
- VII. а в и р + в

Багш юуг анхаарах вэ?

Дунд ангид орж ирэх үедээ уншиж, бичих чадвар тааруухан сурагчид анхны суурь тавигдах үед нэгэнт хоцорсноос сэтгэл зүйн хувьд өөртөө итгэлгүй болсноос үүдэж бусад хичээлдээ ч суралцах бэрхшээлтэй төдийгүй суралцах сонирхолгүй болох хандлагатай болсон байдгийг багш тооцоолбол зохино. Энэ байдлыг залруулахын тулд тэдэнд сэтгэл зүйн эерэг хандлага төрүүлэх, сонирхлыг нь дэмжиж сурч мэдэх хүсэл сонирхолтой тал дээр илүү анхаарч ажиллах шаардлагатай байдаг. Багш нар өөрсдийн зөв бичих дүрмийн мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хэрхэн үнэлэх вэ?

Бага ангийн сурагчдыг буруу бичсэнээс нь оноо хасах, буруу муу хэмээн бусдаас ялгаж дорд үзэх хандлагаас зайлсхийнэ. Иймээс бага ангийн сурагчдад үнэлгээний тоглоомын аргуудыг ашиглана. Жишээ нь: Гэрлэн дохионы арга, гар өргөхгүй байх дүрэм, уутнаас нэр сугалах, картын арга гэх аль болох сурагчдыг идэвхжүүлэх аргыг хэрэглэх нь зохистой.

3.4 МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛ ЗҮЙН ОЙЛГОЛТЫГ ДОХИОНЫ ХЭЛЭЭР ОЛГОХ АРГА ЗҮЙ

Ямар чадвар эзэмших вэ?

Сонсголгүй хүүхдэд монгол хэлний хэл зүйн ойлголтыг хос хэл, соёлын арга зүйгээр олгосноор үгийг тохирох дагавар нөхцөлөөр зөв хувиргаж, алдаагүй бичих, зөв бүтэцтэй өгүүлбэр бүтээхэд суралцана.

Хос хэл, соёлын арга зүйгээр хэрхэн эзэмшүүлэх вэ?

Дохионы хэл нь хичээл зохион байгуулах гол арга тул багш энэ чадвараа нэмэгдүүлэхэд анхаарна.

- Заах үндсэн ойлголтууд
 - Хэлний харилцааны үндсэн нэгж болох бүтэц өгүүлбэрийн бүтэц дэх хэл зүйн үгсийг үгийн сан, утга зүй, хэл зүйн онцлог шинжээр нь бүлэглэн ангилсныг үгсийн аймаг гэнэ.
 - Холбоо үг бол хэлбэржсэн үгийг өгүүлбэртэй холбож байгаа завсрын түвшний нэгж юм. Холбоо үг нь холбох ёс, өгүүлбэрийн гишүүд, энгийн ба нийлмэл өгүүлбэртэй олон сэжмээр нөхцөлдөж, ерөнхийдөө өгүүлбэрийн хэсэг болж, түүний дотор багтаж байдаг нэрлэх нэгж мөн.
 - Өгүүлбэр бол хэл зүйн талаасаа үг, нөхцөлийн хослолыг дамжиж, нэр ба үйлийн бүрэлдэхүүн хэсэг буюу өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, түүнийг дэлгэрүүлэгч дэд гишүүд оролцож бүтсэн, загварт шинж чанартай хам бүтэц мөн.
- Үгсийн аймагт дараах ойлголтууд хамаарна.

Загвар 6. Үгсийн аймгийн ерөнхий ангилал



Хүснэгт 14. Үгсийн аймгийн ангилал (дэлгэрэнгүй)

Бодит үгс	Жинхэнэ нэр
	Орон цагийн нэр
	Тэмдэг нэр
	Тооны нэр
	Үйл үг
Төлөөлөх үгс	Төлөөний үг
Холбох үгс	Зэрэгцүүлэн холбох үгс
	Захируулан холбох үгс
Баймж үгс	Угтан чимэх үг
	Даган чимэх үг

1. Жинхэнэ нэр

Байгаль ертөнцийн хүн амьтан, юмс үзэгдлийг шууд нэрлэн зааж, тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцөлөөр хувилан, өгүүлбэрт ихэвчлэн өгүүлэгдэхүүн, тусагдахууны үүрэг гүйцэтгэдэг нэр үгсийг жинхэнэ нэр гэнэ. Нэрлэн тэмдэглэж байгаа зүйлийнх нь агуулга буюу ухагдахууны багтаамжаар нь ерийн нэр, оноосон нэр гэж ангилдаг. Нэг төрлийн олон юмыг нийтэд нь нэрлэсэн жинхэнэ нэрийг ерийн нэр гэнэ. Нэг төрлийн олон юмын дотроос аль нэгийг нь онцлон ялгахын тулд тусгайлан өгсөн жинхэнэ нэрийг оноосон нэр гэнэ.

Монгол хэлний жинхэнэ нэр нь тоо, тийн ялгал, хамаатуулах гэсэн хэл зүйн гурван айтай. Эдгээр айг илрүүлэх бүтээврүүдийг нэрийн хувилгах дагавар, нөхцөл гэнэ.

Жинхэнэ нэр болон нэрийн дагавар, нөхцөлийг дохионы хэлний аргаар яаж заах вэ?

Сонсголгүй хүүхдийн онцлогтой холбоотойгоор жинхэнэ нэрийг ялган таниулах, жинхэнэ нэрийг дагавар, нөхцөлөөр зөв хувиргаж, утга, үүргийг ойлгуулах гэсэн дарааллаар заах нь холбоо үг, өгүүлбэр, эх бүтээж сурахад суурь болно.

Жинхэнэ нэрийг таниулахдаа жишээ нь, багш “хэн?” гэсэн асуултыг дохиж дараа нь “багш, чи, би, сурагч” зэрэг үгсийг, “юу?” гэсэн асуултыг дохиж дараа нь “самбар, ширээ, сандал” зэрэг нүдэнд харагдаж буй үгсийг заан, дохино. “Хэн?, юу?” гэсэн асуултад хариулагдах үгс нь жинхэнэ нэр болох тухай дохионы хэлээр тайлбарлана. Ингэхдээ асуусан асуултын хариулт болох “багш, сурагч, самбар, ширээ” зэргийн зургийг харуулаад жинхэнэ нэр хэмээн хэлж өгнө. Мөн багш-сурагч, сурагч-сурагч харьцаагаар дохионы хэлээр ярилцан давтаж болно. Жишээ нь: Сурагч А харандаа руу заагаад “юу?” гэсэн асуултыг дохиж, Сурагч Б хариуг дохино. Сурагч А багш руу заагаад “хэн” гэсэн асуултыг дохиж, Сурагч Б “Сараа” багш гэж багшийн нэрийн хамт дохино. Сурагч В “Сурагч Б”-ийн дохисон үг “ерийн нэр, оноосон нэр”-ийн аль нь болохыг дохино гэх мэтээр хосоор, гурваар, багаар ажиллуулж болно. Асуулт асууж, хариулахад хэрэглэгдэх жинхэнэ нэрсийг зургийн хамт хэвлэж, тарааж өгсөн байж болно. Ерийн нэр, оноосон нэрийг ялган дохиулахын өмнө багш хараанд суурилсан, өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашиглан онолын ойлголтыг өгсөн байх шаардлагатай. Мөн хэрхэн харилцан ажиллахыг зааварлан, чиглүүлнэ.

Багш нэрийн тийн ялгалын нөхцөл, олон тооны дагавар, хамаатуулахын нөхцөлүүдийг заахдаа ингэхдээ дагавар, нөхцөлүүдийг хэрэглэснээр холбоо үг үүсэж, 2 үг нийлээд 1 утга илэрхийлж буйг ойлгуулах нь чухал. Сурагчид “Ямар дагавар, нөхцөлөөр ямар утга илэрхийлэх вэ?” гэсэн ойлголттой болно. Заахдаа жинхэнэ нэрээ давтах маягаар жишээлбэл, өөр лүүгээ заагаад “би” гэж дохиод, өөрийнхөө хамт 2, 3 хүүхэд зогсоогоод өөрсдийгөө зааж “бид” гэж дохино. Өөрийн ширээ рүү зааж “ширээ” хэмээн дохиод, ангийн нийт ширээ рүү зааж “ширээнүүд” хэмээн дохино. “Би-бид”, “ширээ-ширээнүүд” гэсэн үгсийн хоорондын ялгаа нь олон тооны дагаврыг хэрэглэсэнд буй болохыг дохионы хэлээр тайлбарлана. Ингэхдээ өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашиглан онолын ойлголтоо өгч болно. Олон тооны дагавруудыг таниулсны дараагаар давтуулахдаа багш-сурагч, сурагч-сурагч харьцаагаар дохионы хэлээр ярилцаж болно. Жишээ нь: Сурагч А-гийн дохисон нэр үгийг сурагч Б олон тоон дээр хувирган дохино. Сурагч В дохисон үгсийн ганц тоо болон олон тооны хэлбэрийг дэвтэрт бичиж багш шалгана гэх мэт.

- Багш хэл зүйн ойлголтуудыг цогц, нэгдмэл байдлаар олгоход анхаарах бөгөөд нэрийн холбоо үгийг хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:

“Угсруулах холбоонд байгаа бие даасан утгатай хоёр үгийн тодотгуулагч бүрдүүлбэр буюу цөм үг нь нэр үг байвал нэрийн холбоо үг гэнэ. Тодотгогч үг нь өмнөө, тодотгуулагч үг нь хойноо орж байрлах нь нэрийн холбоо үгийн хэлний гол ёс мөн”.

- Нэрийн холбоо үгийг дохионы хэлний аргаар хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:


Багш нэрийн холбоо үгийг хэрхэн зөв бүтэцтэйгээр бүтээх буюу тодотгогч үг, тодотгуулагч үг хоёрыг хэрхэн ялгаж, урд хойно нь байрлуулахыг заана. “Явал нэрийн холбоо үг болох вэ?” гэдгийг ойлгуулахдаа цөм болон дагуул үг хоорондоо нийлж puzzle бүтэх маягийн биет хэрэглэгдэхүүнийг самбарт дараалалгүй нааж сурагчдад үг тус бүрийн утгыг дохионы хэлээр таниулна. Жишээлбэл:

Загвар 7. Нэрийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ



Ингэсний дараа утгаар нь зөв харгалзуулж, холбоо үг бүтээх ба холбоо үгийн утгыг дохионы хэлээр тайлбарлана. Цөм үг нь нэр үг байгаа учраас нэрийн холбоо үг болж буйг, мөн дагуул буюу тодотгогч үгс нь ямар асуултад хариулагддагийг самбарт наасан жишээ үгс дээрээ суурилан, эсвэл өнгөт загвар, бүдүүвч, зураг зэргийг ашиглан ойлгуулж болно. Онолын ойлголтыг өгсний дараа сурагч А-г тодотгогч үгийг дохихыг, сурагч Б-г түүнд тохирсон цөм үгийг дохихыг зааварлан хосоор болон багаар ажиллуулах маягаар давтуулж болно. Онолын ойлголтыг өгөхдөө жишээ нь:

Загвар 8. Нэрийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ



Дээрх мэтээр тодотгогч үг ямар асуултад хариулагдахыг болон тодотгуулагч үгийн өмнө байрлахыг ойлгуулах нь зөв бүтэцтэй өгүүлбэр зохион бичихэд тустай.

Дасгал ажилд:

- “Эдгээр үгсээс тодотгогч/тодотгуулагч болох үгсийг сонгоорой.
- 2 баганад буй тодотгогч/тодотгуулагч үгсийг утгаар нь зөв харгалзуулаарай.
- Доорх үгсэд тохирох тодотгогч/тодотгуулагч үгсийг олж бичээрэй” зэрэг зааварчилгаа бүхий даалгавар ажиллуулж болно

1. Үйл үг

Бодит ертөнцийн юмс үзэгдлийн үйл хөдлөл, явц, байдлыг нэрлэн заасан үгсийг үйл үг гэнэ.

Үйл үндсийн дараа орж, үйлийн эзэн, болц байдал заах дагавраас гадна цаг, бие, баймж харьцаа заах ба үйл үгийг бусад үгтэй холбох үүрэгтэй хэл зүйн утгатай залгавруудыг үйлийн нөхцөл гэнэ. Үйлийн нөхцөлүүдийн нэг хэсэг нь үйл үгийг бусад үгтэй холбох, зарим нь өгүүлбэр төгсгөх үүрэгтэй.

- Үйл үг болон үйлийн дагавар, нөхцөлийг дохионы хэлний аргаар талаар багшид зөвлөх нь:

Сонсголгүй хүүхдийн онцлогтой холбоотойгоор багш үйл үгийг заахдаа нэр үгийн ард байрладгийг, үйл үгийг зөв төгсгөж байж зөв бүтэцтэй өгүүлбэр бүтдэгийг голлон заана.

Үйл үгийг таниулахдаа жишээ нь, багш “яах?” гэсэн асуултыг дохиж дараа нь “алхах” гэсэн үгийг дохиж алхана. Сууж буй сурагч руу заан “яах?” гэсэн асуултыг дохиж, “суух” гэсэн үгийг дохино. “Яах?” гэсэн асуултад хариулагдах үгс нь үйл үг болох тухай дохионы хэлээр тайлбарлана. Мөн багш-сурагч, сурагч-сурагч харьцаагаар дохионы хэлээр ярилцан давтаж болно. Жишээ нь: Сурагч А-гийн хийж буй үйлдлийг хараад сурагч Б “яах?” гэсэн асуултыг дохиж ба сурагч В хариуг дохиж мэтээр хосоор, гурваар, багаар ажиллуулж болно. Багш хараанд суурилсан, өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашиглан онолын ойлголтыг өгсөн байх шаардлагатай. Мөн хэрхэн харилцан, ажиллахыг зааварлан, чиглүүлнэ.

Үйлийн хэв, байдлын дагавар, холбох болон төгсгөх нөхцөлүүдийн утга, үүрэг хэрэглээг өнгөт зураг, загвар, бүдүүвч зэргийг ашиглан ойлгуулна. Жишээ нь, бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврыг заахдаа үйлийг санаачлагч эзэн, үйлийг биечлэн гүйцэтгэгч эзэн хоёрын ялгааг таниулахад анхаарна. Багш “Би ном уншив” гэсэн өгүүлбэрийг дохиж, ном унших үйлийг хийж харуулаад, дараа нь “Би сурагчаар ном уншуулав” гэсэн өгүүлбэрийг дохиж, нэгэн сурагчийг ном уншиж буй үйл хийж харуулахыг зааварчилна. Энэ мэт “Би самбар арчив, би сурагчаар самбар арчуулав. Би цонх хаав, би сурагчаар цонх хаалгав” зэрэг бусдаар үйлдүүлэх хэвийн 4 дагавар бүхий өгүүлбэрийг өөрөө үйлдэх хэвийн дагаварт бүхий өгүүлбэртэй харьцуулан дохионы хэлээр ялган таниулна. Өөрийн хэлж буй өгүүлбэртээ ашиглах бусдаар үйлдүүлэх хэвийн дагавраа бичиж хэвлэсэн байх эсвэл үзүүлэнгээр харуулах, самбарт бичих ба эдгээр дагаврын оролцоотойгоор “өөрөө хийх биш, өөр хүнээр хийлгэх” утга үүсэж буйг дохионы хэлээр тайлбарлана. Онолын ойлголтыг өгөхдөө, жишээ нь:

Хүснэгт 15. Бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврыг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ

Д/д	Бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврууд	Жишээ өгүүлбэр	Үйлийг санаачлан удирдах эзэн	Үйлийг биечлэн гүйцэтгэгч эзэн
1	-уул, үүл	Би дүүгээр ном уншуулав.	Би	Дүү
2	-лга ⁴	Дүү ээжээр цонх хаалгав.	Дүү	Ээж

3	-га ⁴	Ах намайг гадаа гар гав .	Ах	Би
4	-аа ⁴	Аав ахыг хаягдал цаас шат аа гэв.	Аав	Ах

Дасгал ажилд:

- Бусдаар үйлдүүлэх хэвийн дагавраар хэлбэржсэн үг бүхий өгүүлбэрүүд өгөөд *“Үйлийг санаачлан удирдах эзэн, үйлийг биечлэн гүйцэтгэгч эзнийг ялгаарай.*
- *Ааваараа/ээжээрээ/дүүгээрээ/багшаараа хийлгэдэг үйлдлүүдээрээ өгүүлбэр зохион бичээрэй”* зэрэг зааварчилгаа бүхий даалгавар ажиллуулж болно.

Төгсгөх нөхцөлүүдийг зөв хэрэглэж сурах нь зөв бүтэцтэй, утга төгс өгүүлбэр бүтээхэд чухал тул багш биеэр болон цагаар төгсгөх нөхцөлүүдийг заахдаа сайтар таниулан, ойлгуулж, аль нөхцөл аль цагийг зааж, ямар утга илэрхийлэхийг жишээгээр үзүүлэн тайлбарлана. Жишээ нь, багш самбарт цаг хугацааны шугам болгон 2 үзүүртэй сум зурж, түүн дээрээ өнгөрсөн, одоо, ирээдүй цагийг 3 өөр өнгийн хошойгоор цэглэн тэмдэглэнэ. Цагаар төгсгөх нөхцөлүүдийг өнгөөр ялган бичиж хэвлэсэн байх ба “-лаа⁴” нөхцөлийг барьж, самбарт тэмдэглэсэн шугамын өнгөрсөн цагийн хэсэгт зогсон “Би хичээлдээ явлаа” гэсэн өгүүлбэрийг, “-на⁴” нөхцөлийг барьж, самбарт тэмдэглэсэн шугамын одоо цагийн хэсэгт зогсон “Би хичээлээ хийж байна” гэсэн өгүүлбэрийг, “-на⁴” нөхцөлийг барьж, самбарт тэмдэглэсэн шугамын ирээдүй цагийн хэсэгт зогсон “Удахгүй амралт эхэлнэ” гэсэн өгүүлбэрийг дохино. Багшийн гарт буй нөхцөлүүд нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн утга ялгахад хамгийн гол үүрэгтэй байгааг дохионы хэлээр тайлбарлана. Онолын ойлголтыг заахдаа багш хараанд суурилсан, өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашиглаж болно. Жишээ нь:

Загвар 9. Цагаар төгсгөх нөхцөлийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ

- Бид жимс түү**лээ**.
- Ээж ажилдаа яв**жээ**.
- Багш хичээл заав**.**
- Би хичээлээ хийж бай**на**.
- Ээж хувцас оёж суу**на**.
- Удахгүй амралт эхэл**нэ**.



Өнгөрсөн



Одоо



Ирээдүй

Мөн багш-сурагч, сурагч-сурагч харьцаагаар дохионы хэлээр ярилцан давтаж болно. Жишээ нь, багш бэлдсэн цагаар төгсгөх нөхцөлүүдээсээ сурагч А-д өгөх бөгөөд сурагч А нөхцөлийг аваад өнгөрсөн, одоо, ирээдүй цагаар төгсгөх нөхцөлийн аль нь болохыг ялгаад самбар дахь шугамаас зохих байранд очиж дурын 1 өгүүлбэр зохион дохио ба сурагч А-гийн дохисон өгүүлбэрийг сурагч Б дэвтэрт бичнэ гэх мэт.

Үйлийн дагавар, нөхцөлүүдийн утга, үүргийг таниулсны дараагаар хэрэглэж сургах үүднээс үйл үндсэнд 2 ба түүнээс дээш дагавар нөхцөл залган өгүүлбэр зохиох дасгал хийлгэж болно. Жишээ нь:

- Сүүлийн долоо хоногт гэр бүлийнхнээрээ хийлгэсэн зүйлсээрээ өгүүлбэр зохион бичээрэй. *“3 хоногийн өмнө ааваараа хичээлээ заалгасан”* гэх мэт.
- Ирэх сард найзуудтайгаа аялалд явах тухай өгүүлбэр зохион бичээрэй. *“Бид 10 хоногийн дараа ууланд авирцгаана”* гэх мэт.

- Бүр мөсөн үйлдэх байдлын дагаврыг ашиглан өнгөрсөн болон ирээдүй цаг дээр тус бүр 3 өгүүлбэр зохион бичээрэй. “Ээж хоол хийчихсэн байв. Би хөдөө явчихаад ирнэ” гэх мэт.

- Багш хэл зүйн ойлголтуудыг цогц, нэгдмэл байдлаар олгоход анхаарах бөгөөд үйлийн холбоо үгийг хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:

“Угсруулах холбоонд буй бие даасан утгатай хоёр үгийн голлосон үг буюу цөм үг нь үйл үг байвал **үйлийн холбоо үг** гэнэ”.

- Үйлийн холбоо үгийг дохионы хэлний аргаар хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:


Багш үйлийн холбоо үгийг хэрхэн зөв бүтэцтэйгээр бүтээх буюу дагуул үг (тусагдахуун/байц), цөм үг (өгүүлэхүүн) хоёрыг хэрхэн ялгаж, урд хойно нь байрлуулахыг заана. “Яавал үйлийн холбоо үг болох вэ?” гэдгийг ойлгуулахдаа цөм болон дагуул үг хоорондоо нийлж puzzle бүтэх маягийн биет хэрэглэгдэхүүнийг самбарт дараалалгүй нааж сурагчдад үг тус бүрийн утгыг дохионы хэлээр таниулна. Ингэсний дараагаар хамтран утгаар нь зөв харгалзуулж, холбоо үг бүтээх ба холбоо үгийн утгыг дохионы хэлээр тайлбарлана. Цөм үг нь үйл үг байгаа учраас нэрийн холбоо үг болж буйг, мөн дагуул буюу тодотгогч үгс нь ямар асуултад хариулагддагийг самбарт наасан жишээ үгс дээрээ суурилан, эсвэл өнгөт загвар, бүдүүвч, зураг зэргийг ашиглан ойлгуулж болно. Жишээлбэл:

Загвар 10. Үйлийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ



Онолын ойлголтыг өгсний дараа сурагч А-г тодотгогч үг дохихыг, сурагч Б-г түүнд тохирсон цөм үг дохихыг зааварлан хосоор болон багаар ажиллуулах маягаар давтуулж болно. Онолын ойлголтыг өгөхдөө жишээ нь:

Загвар 11. Үйлийн холбоо үгийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ



Дээрх мэтээр дагуул үг ямар асуултуудад хариулагдахыг болон цөм үгийн өмнө байрлахыг (ихэнх тохиолдолд) ойлгуулах нь зөв бүтэцтэй өгүүлбэр зохион бичихэд тустай. Дасгал ажилд:

- “Эдгээр үгсээс дагуул үг/цөм үг болох үгсийг сонгоорой.
- 2 баганад буй дагуул үг/цөм үгсийг утгаар нь зөв харгалзуулаарай.
- Доорх үгсэд тохирох дагуул үг/цөм үгсийг олж бичээрэй” зэрэг зааварчилгаа бүхий даалгавар ажиллуулж болно

2. Орон цагийн нэр

Үйл хөдлөлийн болох орон байр, зүг чиг, цаг хугацааг нэрлэн заасан *наана, цаана, дээр, доор, дэргэд, хажууд, хооронд, урагш, хойш, баруун, зүүн, эрт, орой, хожим, сая, даруй, түр, мөдхөн, ашид, мөнхөд* гэх мэт үгсийг орон цагийн нэр гэнэ.

Орон цагийн нэрийг дохионы хэлний аргаар хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:

Багш орон цагийн нэрийг заахдаа дангаар нь бус нэрийн болон үйлийн холбоо үг, цаашлаад өгүүлбэрийн жишээнд тулгуурлана. Доорх мэт өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашигласан дасгал даалгавар ажиллуулж болно. Жишээ нь: *“Шар дүрсэд орон цагийн нэр, цэнхэр дүрсэд нэр үг, улбар шар дүрсэд үйл үг олж бичин, утга төгс өгүүлбэр бүтээгээрэй. Ингэхдээ үгсэд залгавар залгах шаардлагатай тохиолдолд тохирох залгаврыг залгаарай”* гэх мэт.

3. Тэмдэг нэр

Монгол хэлний тэмдэг нэр нь жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолдож, хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг заадаг үл хувилах үгс юм.

Тэмдэг нэрийг дохионы хэлний аргаар хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:

Багш тэмдэг нэрийг заахдаа дангаар нь бус нэрийн болон үйлийн холбоо үг, цаашлаад өгүүлбэр, эхийн жишээнд заана. “Орон цагийн нэр” хэсэгт оруулсны адил өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашигласан дасгал даалгавар ажиллуулж болно. Мөн эхийн өгүүлбэрүүдэд тэмдэг нэр нөхөх дасгал даалгавар ажиллуулж болно. Ингэхдээ сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт таарснаас гадна тэмдэг нэр элбэгтэй эх сонгоход анхаарна. Жишээ нь: “Цуутын цагаагч гүү” үлгэрийн доорх хэсэгт тохирох тэмдэг нэрийг нөхөж бичээрэй. (Улаанаар бичсэн үгсийг онгорхой орхих)

“Цуутын цагаагч гүү Цолмон **цоохор** унага, далан хоёр **ижил** сүрэг, дархан **хул** азаргатайгаа үзэсгэлэнт **ногоон** хөндийдөө идээшлэн бэлчдэг байжээ. Гэтэл нэгэн зун **үзэсгэлэнт** ногоон хөндий, **өргөн** тал нутагт нь ган гачиг болж, өвс ногоо ургасангүй”.

4. Тооны нэр

Бодит ертөнцийн юмс үзэгдлийн тоо ширхэг, дэс дугаар, хам цуг, бүхэл бутархайг нэрлэх үгсийг тооны нэр гэнэ. Тооны нэр нь жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолддог үл хувилах үгс юм.

Тооны нэрийг дохионы хэлний аргаар хэрхэн заах талаар багшид зөвлөх нь:

Багш тооны нэрийг заахдаа дангаар нь бус нэрийн болон үйлийн холбоо үг, цаашлаад өгүүлбэр, эхийн жишээнд тулгуурлана. “Орон цагийн нэр” хэсэгт оруулсны адил өнгөт загвар, зураг, бүдүүвч зэргийг ашигласан дасгал даалгавар ажиллуулж болно.

Үгсийн аймагт холбогдох ойлголтуудыг өгсний дараа, үгсийн аймгийн мэдлэг, ойлголтоо ашиглан өгүүлбэр бүтээж сурахад анхаарна. Жишээ нь, доорх мэтийн хялбар дасгалаас эхэлж болно.

“Доорх хүснэгтийг гүйцээж, өгүүлбэр бүтээгээрэй. Ингэхдээ үгсэд тохирох дагавар, нөхцөлийг зөв залгаж бичээрэй”.

Хүснэгт 16. Үгсийн аймгийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ

Д/д	Жинхэнэ нэр	Орон цагийн нэр	Тооны нэр	Тэмдэг нэр	Жинхэнэ нэр	Үйл үг
1	Би	Маргааш	2	Цэнхэр	Үзэг	Авна.
2	Ээж	Өчигдөр	4	Цагаан	Цамц	Угаасан.
3						
4						
5						

Хүснэгт 17. Үгсийн аймгийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ

Д/д	Ж.Н+Ж.Н	О.Ц.Н (То.Н-тэй)	Ж.Н+Ж.Н	Үйл үг	Үйл үг
1	Миний дүү	Маргааш 2 цагт	Хичээлийн шалгалт	Өгөхөөр	Явна.
2	Батаагийн ах	2 жилийн өмнө	Надад теннис	Зааж	Өгсөн.
3
4
5

“Дээр буй хүснэгтийг гүйцээж, өгүүлбэр зохиохдоо ямар үгсэд, ямар дагавар, нөхцөл ашигласнаа тодорхойлон бичээрэй”.

Хүснэгт 18. Нэрийн дагавар, нөхцөлийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ

Д/д	Залгавар залгасан жинхэнэ нэрийн үндэс	Залгасан залгавар	
1	Би	Харьяалахын тийн ялгал	-ий
2	Цаг	Өгөх оршихын тийн ялгал	-т
3	Хичээл	Харьяалахын тийн ялгал	-ий
4
5


Хүснэгт 19. Үйлийн дагавар, нөхцөлийг давтуулахдаа ашиглаж болох загварын жишээ















Д/д	Залгавар залгасан үйл үгийн үндэс	Залгасан залгавар	
1	Ав-	Ирээдүй цагаар төгсгөх	-на
2	Заа-	Зэрэгцүүлэн холбох	-ж
3	Угаа-	Өнгөрсөн цагаар төгсгөх	-сан
4
5








Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

Дээр дурдсан зөвлөмж, аргыг хэрэгжүүлэхдээ доорх хэрэглэгдэхүүнүүдийг компьютерт бэлдсэн үзүүлэнгээр харуулах болон хэвлэн ашиглах боломжтой.









Загвар 12. Жинхэнэ нэрийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ



Олон тооны дагавар				
Д/д	Жишээ үг	Утга	Үүссэн үг	Утга
1	Багш		Багш нар	
2	Эмэгтэй		Эмэгтэй чүүд	
3	Эрэгтэй		Эрэгтэй чүүл	
4	Ном		Ном ууд	
5	Цаад (хүн)		Цаад уул	
6	Нохой		Ноход	
7	Навч		Навч ис	

	Тийн ялгал	Нэр үг		Нөхцөл		Холбоо үг	Утга
1	Нэрлэх	аав	+	∅	=	аав хүчтэй	
2	Харьяалах	аав	+	ын	=	аавын найз	
3	Өгөх орших	аав	+	д	=	аавд өгөх	
4	Заах	аав	+	ыг	=	аавыг тэврэх	
5	Гарах	аав	+	аас	=	ааваас авах	
6	Үйлдэх	аав	+	аар	=	ааваар туслуулах	
7	Хамтрах	аав	+	тай	=	аавтай явах	
8	Чиглэх	аав	+	руу	=	аав руу очих	

Хүснэгт 22. Дагавар, нөхцөлийн үүргийг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ


			
Багш ном		Багшийн ном	
			
Утас ярих		Утсаар ярих	
			

Хүснэгт 23. Бусдаар үйлдүүлэх хэвийн дагаврыг таниулахдаа ашиглаж болох загварын жишээ

Д/д	Өөрөө үйлдэх хэвийн дагавартай өгүүлбэр	Өгүүлбэрийн утга	Бусдаар үйлдүүлэх хэвийн дагавартай өгүүлбэр	Өгүүлбэрийн утга
1	Би ном уншив.		Би дүү гээр ном уншу уу лав.	
2	Дүү цонх хаав.		Дүү ээж ээр цонх хаал г ав.	
3	Эгч гадаа гарав.		Эгч хүүхдүүдийг гадаа гар г ав.	
4	Аав шатаав. мод		Ээж ааваар мод шатаал г ав.	



Багш юуг анхаарах вэ?



Үгсийн аймаг тус бүрийн үндсэн шинж, ай, хэрэглээ, тэдгээрт суурилсан нэрийн болон үйлийн холбоо үг, холбоо үгийн байр, утга хэрэглээ зэргийг ойлгож, хэрэглэж сурах нь сонсголгүй хүүхдэд түгээмэл тохиолддог буруу бүтэцтэй өгүүлбэр, эх зохион бичих асуудлыг шийдвэрлэхэд суурь болж өгнө. Тиймд сурагчдад нэгдмэл, цогц ойлголт, мэдлэг олгох үүднээс хэлний нэгжүүдийн шаталсан харьцааг харгалзан, үгсийн аймаг, холбоо үг, өгүүлбэрийн талаарх хэл зүйн ойлголтуудыг интеграцичилсан байдлаар заахад анхаарна.

Хэрхэн үнэлэх вэ?

Сонсголгүй хүүхдийн монгол хэлний хэл зүйн чадварыг үнэлэх нь сонсголтой хүүхдийн монгол хэлний хэл зүйн чадварыг үнэлэхээс төдийлөн ялгаагүй. Тиймд багш хэл зүйн чадварыг шалгах тест, сорил зэргээр шалгалт авч үнэлгээг хийж болохоос гадна хичээлийн явцад явцын үнэлгээг тогтмол хийж, сурагчдаар өөрийн үнэлгээ болон чацуутны үнэлгээ хийлгэхэд анхаарах хэрэгтэй. Ингэхдээ сурагчдын онцлогт тохируулан хараанд суурилсан, өнгөт зураг, загвар, бүдүүвч бүхий ажлын болон үнэлгээний хуудас бэлдэж, зааврыг дохионы хэлээр тодорхой, ойлгомжтой тайлбарлана.

“Явцын үнэлгээний аргуудаас: Явцын үнэлгээ гэдгийг дүн, оноо гэхээс илүү хичээлийн үйл явц буюу багш сурагчийн харилцаа, багш өөрийнхөө хичээлийг оношлох үйл хэмээн үзнэ. Явцын үнэлгээг зөвхөн сурагчдыг уралдуулах, баг хооронд тэмцээн зохиох, самбарт өлгөсөн туулайны зургийг луувангаар тэжээх, мод чимэглэх, сурагчдын

хийсэн ажлыг оноогоор дүгнэж уралдуулах хэмээн ойлговол өрөөсгөл юм. Явцын үнэлгээ нь сурагчдыг үнэлж дүгнэхээс илүү тэдний ур чадварыг хөгжүүлэх, сэтгэх бодох чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгод чиглэнэ. Явцын үнэлгээ нь багш өөрийн хичээлийн үр дүнд анализ дүгнэлт хийх үйл явц хэмээн ойлгоно. Явцын үнэлгээний үед сурагчид хамгийн наад зах нь юу мэдэж, чадаж байгаа, юуг мэдэх, чадах шаардлагатай байгаагаа ойлгож гарах нь чухал юм” (Д.Эрдэнэсан “Монгол хэл заах арга” УБ., 2021. 253-р тал) гэсэн байдгийг багш анхаарах хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

1. ДХХОХ., (2017). “Монгол дохионы хэлний сурах бичиг”. Улаанбаатар. Сэлэнгэ пресс
2. МУБИС. Монгол хэлний тэнхим., (2022). Орчин цагийн монгол хэл, II боть. Улаанбаатар.
3. Намираа Б., (2016). “Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, түүний боловсрол”, Улаанбаатар. Ном хур ХХК.
4. НҮБ-ын Боловсрол Соёл, Шинжлэх Ухааны байгууллага., (2011). “Сонсголын бэрхшээл буюу дүлийрэлт” эцэг эх, багш, олон нийтэд зориулсан гарын авлага. Улаанбаатар. Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
5. Сонсголгүйн боловсрол ТББ., (2017). “Дохионы хэлний зурагт толь бичиг”. Улаанбаатар. Сэлэнгэ пресс
6. Эрдэнэсан Д., (2021). Монгол хэл заах арга. Улаанбаатар.
7. Эрдэнэсан Д., Гэрэлмаа.Д “Монгол хэл, үндэсний бичиг тулгуур лавлах” Улаанбаатар.
8. Munawar Malik and Naseer ud Din., (2019). Writing Skills Development among Students with Deafness at Elementary Level. Bulletin of Education and Research April 2019, Vol. 41, No. 1 pp. 1-16
9. C.S.Englert, T.E.Raphael, L.M.Anderson., (1989). Cognitive Strategy Instruction in Writing project, East Lansing, MI: Institute for Research on Teaching
10. Deaf students-Reading and Writing. Deaf Children Australia. <http://www.deafchildrenaustralia.org.au/>
11. Giampietro V, David AS, McGuire PK, et al. Dissociating linguistic and nonlinguistic gestural communication in the brain, Neuroimage, 2004, vol. 22 (pg. 1605-1618) <https://www.ucl.ac.uk/icn/people/mairead-macsweeney>
12. <https://www.deafchildrenaustralia.org.au/wp-content/uploads/2021/06/readingwriting.pdf>
13. Sign Language and the Brain: A Review | The Journal of Deaf Studies and Deaf Education | Oxford Academic (oup.com)
14. <http://www.leeds.ac.uk/educol/documents/000000306.htm>
15. http://www.scielo.br/scielo.php?pid=s010440602014000600004&script=sci_arttext&tlng=en

-----oOo-----